



Нээлттэй
Нийгэм
Форум

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

ТАТВАР ХУРААХ МЕХАНИЗМ

БОДЛОГЫН СУДАЛГАА

Бодлогын судлаач:

Г.АЛТАНЗАЯА (Доктор (Ph.D)),
2006 оны Бодлогын судалгааны
тэтгэлэгт хөтөлбөрийн судлаач,
ХҮДС-ийн багш,
ТИНЗ нийгэмлэгийн
гүйцэтгэх захирал

Судалгааны зөвлөх:

О.ЦОГ (Магистр)
ТЕГ-ын татвар хураалтын
хэлтсийн дарга

Улаанбаатар хот, 2007 он

DDC
352,44
A-486

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48,
Монгол Улс
Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

Уг судалгаагаар гаргасан дүгнэлт, саналууд нь судлаачийн үзэл бодлыг илэрхийлнэ.

© Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл ННФ-ын хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

Энэ судалгааны тайланг сонирхсон байгууллага, хувь хүмүүст хямдралтай үнээр худалдана.

ISBN 978-99929-0-317-1

“ADMON” компанид эхийг бэлтгэж хэвлэв.

АГУУЛГА

1. Удиртгал	7
2. Татвар хураалтын механизмын шударга, үр ашгийн шалгуур	13
2.1. Шударга байх	13
2.2. Үр ашигтай байх	15
2.3. Татвар хураалтын зардал	17
3. Татвар хураах механизмын өнөөгийн байдал, хамрах хүрээ	21
3.1. Татварын харилцаа	21
3.2. Татвар хураалтын эрх зүйн орчин, өнөөгийн байдал	22
3.3. Татварын механизмын ойлголтууд	45
3.4. Татвар хураалтын зохион байгуулалт	47
3.5. Татварын орлогын төлөвлөгөө, татвар хураалтын уялдаа	49
3.6. Татвар хураалтад хяналтын үүрэг	51
3.7. Татвар хураалтад мэдээ, мэдээллийн нөлөө	54
3.8. Татварын бүртгэлийн үүрэг	56
3.9. Татвараас зайлсхийх хандлага, хүлээлгэх хариуцлага	58
4. Дүгнэлт	62
5. Бодлогын хувилбар	65
5.1. Бодлогын хувилбарын шинжилгээ	65
5.2. Татвараа өөрөө тодорхойлон төлөх үүргийн хэрэгжилтийг хангах боломжит бодлогын хувилбар	73
5.3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг бүртгэх, тайлагнах хувилбар	80
5.4. Бодлогын зөвлөмж	92
Хавсралтууд	97

Хүснэгтийн жагсаалт

- Хүснэгт 1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн харьцуулалт
- Хүснэгт 2. ҮТЕГ-ийн зардлын бүтэц
- Хүснэгт 3. Татвар төлөгчийн бүртгэл
- Хүснэгт 4. Татварын өрийн төлөлтийн байдал
- Хүснэгт 5. Татварын өр
- Хүснэгт 6. Татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил
- Хүснэгт 7. ААНБОАТ-ын тайлан тушаалтын байдал
- Хүснэгт 8. ААНОАТ-ын татварын түвшин
- Хүснэгт 9. Аж ахуйн нэгж байгууллагын эдийн засгийн чадавх, татвар ногдуулалтын байдал
- Хүснэгт 10. 2005 онд Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хуулийн дагуу үзүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлт
- Хүснэгт 11. Татвар хураах механизмын чиг үүрэг
- Хүснэгт 12. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн хүрээн дэх татварын механизмын чиг үүрэг
- Хүснэгт 13. Улсын төсвийн татварын нийт орлогод ААНБОАТ-ын гүйцэтгэх үүрэг
- Хүснэгт 14. ААНБОАТ-ын төлөвлөгөөний биелэлт
- Хүснэгт 15. Татварын хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо
- Хүснэгт 16. Татвар хураах бодлогын талбар
- Хүснэгт 17. Үр дүнгийн матриц
- Хүснэгт 18. Татвар хураалтын механизмын бүрэлдэхүүн
- Хүснэгт 19. НББ-ийн, татварын бүртгэлийн зорилгоос зөрүү үүсэх нөхцөл
- Хүснэгт 20. НББ-ийн зорилго, татварын бүртгэлийн зорилгоос үүсэх зөрүүгийн шинж байдал, нөлөөлөл
- Хүснэгт 21. Тайлангуудын уялдаа /1-р хувилбар/
- Хүснэгт 22. Тайлангуудын уялдаа /2-р хувилбар/
- Хүснэгт 23. ААНОАТ-ын тайлангийн бүтцийн харьцуулалт

Графикийн жагсаалт

График 1. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогод гүйцэтгэх үүрэг

График 2. Татвар хураалт, хяналт шалгалтын байцаагч

График 3. 2006 оны маргаантай өр

График 4. Татварын хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж

График 5. Хяналт шалгалтын зөрчил, хариуцлага

График 6. ААНОАТ–ын тайлан тушаалт

График 7. Татварын ачаалал

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1. ААНОАТ–ын тайлангийн загвар

Хавсралт 2. НББ–ийн зорилго, татварын бүртгэлийн зорилгын зөрүү үүсэх нөхцлүүд

Хавсралт 3. Татвар цуглуулах механизм фокус ярилцлагын нэгтгэл

Хавсралт 4. Санал асуулга

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

1. УИХ Улсын Их Хурал
2. ҮСГ Үндэсний Статистикийн Газар
3. ҮТЕГ Үндэсний Татварын Ерөнхий Газар
4. ОУВС Олон Улсын Валютын Сан
5. МБАХ Мэдээлэл боловсруулалт автоматжуулалтын хэлтэс
6. ААНБОАТ Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар
7. ААНОАТ Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
8. ХЗДХЯ Хууль зүй Дотоод Хэргийн Яам
9. УТОХГ Улсын төсвийн орлого хяналтын газар
10. НТГ Нийслэлийн татварын газар
11. НДЕГ Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар
12. ГЕГ Гаалийн Ерөнхий Газар
13. ТЕХ Татварын ерөнхий хууль
14. НББОУС Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
15. ТЗАТ Төлбөл зохих албан татвар
16. НББ Нягтлан бодох бүртгэл

1. УДИРТГАЛ

БОДЛОГЫН АСУУДЛЫН АГУУЛГА

Үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 17-р зүйлийн 3-р заалт¹, Татварын ерөнхий хуулийн 10-р зүйлийн 1-р заалт², Татвар ногдуулалт төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуулийн 9-р зүйлийн 1-р заалт³, 15-р зүйлийн 1-р заалт⁴-д заасан эрх зүйн хүрээнд Монгол улсад татвар төлөгч нь өөрөө татвараа тодорхойлон төлдөг тогтолцоо үйлчилдэг. Энэ нь нийт татвар төлөгчдөөс татварын хуулиудыг хэрэгжүүлэхэд татвар төлөгчөөр бүртгүүлэх, татвар ногдуулах орлого, зүйлс, татвараа тооцоолох, түүнийгээ бүртгэж, тайлагнах ажилбаруудыг хуулийн хүрээнд хэрэгжүүлэхийг үүрэг болгосон гэсэн үг.

Энэ нөхцөлд татвараа хураах механизмын хэрэгжилт нь татвар төлөгчдийн татварын тайлангаа гарган тушааж буй үзүүлэлтээр хэмжигдэх юм. Судалгаанаас үзвэл, 2003, 2004, 2005 онуудад нийт хуулийн этгээдийн 90 орчим хувь нь аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тайлангаа татварын албанд тушаадгаас 50 орчим хувь нь “Х”⁵ болон алдагдалтай ажилласан гэж тайлагнажээ. Зөвхөн үлдсэн хэсэг нь орлогын албан татварыг ямар нэг хэмжээгээр төсөвт төлдөг байна. Бусад татваруудын тайлан тушаалт, ялангуяа иргэний болон төлбөр, хураамжийн тухайд үзүүлэлт бүр хангалтгүй байгаа.

Татвар төлөгчид татвараа өөрөө тодорхойлон төлөх үүргээ шударгаар хэрэгжүүлэх нөхцлийг хангаж чадахуйц механизмыг бий болгох нь нийгмийн хэрэгцээ юм.

¹ Хуулиар ногдуулсан албан татвараа төлөх

² Татвар ногдох зүйл, татвараа үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх

³ Татвар төлөгч татварын тайлан, орлого, татвар тодорхойлох хуудас /цаашид “татварын тайлан” гэх/ –ыг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу бөглөж, харъяалсан татварын албанд тушаана

⁴ Татвар төлөгч холбогдох баримт, бүртгэлд үндэслэн татварын ногдлоо өөрөө тодорхойлон татварын тайланд тусгана. Татвар төлөгч татварын ногдлыг буруу тодорхойлсон гэж үзвэл татварын алба, татварын байцаагч шалган тогтооно.

⁵ үйл ажиллагаа явуулаагүй

- *Тулгамдаж буй асуудал нь:*
Татвар хураалтад дараах шалтгаанаас үүдэлтэй тэгш шударга бус, үр ашиггүй татварын тогтолцоо үйлчилж байгаад оршино:
 - Монгол улсад татвар төлөгчдийн дийлэнх нь татвараа үнэн зөв тодорхойлж төлөхгүй байгаа;
 - Татварыг шударгаар төлөх нийгмийн сэтгэл зүй бүрдээгүй буюу татварыг нийгмийн өмнө хүлээсэн үүрэг гэдэг ойлголт төлөвшөөгүй, татвар төлөх явдлыг зөвхөн аж ахуйн нэгж байгууллагын үүрэг, аж ахуйн нэгжид хамааралтай мэтийн ойлголт иргэдийн дунд хавтгайрсан;
 - Татварын алба нь ч зөвхөн бүртгэлтэй цөөн тооны татвар төлөгчдөөсөө л татвар хураах явдлаар ажлаа хязгаарладаг;
 - Татвар төлөх үүргээ хэрэгжүүлээгүй нөхцөлд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо сул;
 - Татварын мэдээлэл, бүртгэлийн тогтолцоо хөгжөөгүй.

БОДЛОГЫН АСУУДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

- *Бодлогын асуудал нь:*
Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу татвар төлөгчид нийтээрээ татвараа шударгаар өөрөө тодорхойлон төлөх үүргээ хэрэгжүүлэх механизм үйлчилж чадаж байна уу?
- *Татвар хураах механизмын өнөөгийн байдлын үр дагавар нь:*
 - Татвар төлөгчдөд татвар төлөх үүргээ хэрэгжүүлэх идэвх, санаачлагыг алдагдуулах төдийгүй тайлан мэдээгээ татварт зориулан үйлдэх замаар татвараас зайлсхийх хандлага бий болсон;
 - Татвар төлөгчдөд татвар төлөхгүй байх, бага төлөх сэтгэлгээ бүрдсэн;
 - Татвар төлөх үүргээ хэрэгжүүлээгүйгээс ямар нэг хариуцлага хүлээхгүй байх боломж ихтэй;
 - Татвар төлөгч аль болох бүртгэлгүй үйл ажиллагаа эрхлэх боломжийг хайх сонирхлыг төрүүлэх;
 - Үүргээ шударгаар хэрэгжүүлэхийн оронд хаяг байршлаа өөрчлөх, зайлсхийх боломжуудыг эрэлхийх, авилгалд өртөх.
- *Татвар хураах асуудлыг сонирхогч талууд нь:*
Татвар хураах үйл ажиллагаа нь төр, татвар төлөгчийн хоорондох шууд харилцаанд явагдана. Төр нь татвараар бүрдэх төсвийн орлогоо цуглуулах, татвар төлөгч нь өөрт ногдох татвараа өөрөө тодорхойлон төлөх үүргээ хэрэгжүүлэх. Гэвч татвар нь нийгэм эдийн засгийн хүрээн дэх төрийн

зохицуулалт, хяналтын бодлогыг хэрэгжүүлэгч хэрэгсэл нь тул хамрагдахгүй эдийн засаг, нийгмийн хүрээ үгүй тул сонирхогч хүрээ өргөнтэй ажээ. Үүнд:

- Татварын бодлогыг тодорхойлж, татварын хууль тогтоомжийг боловсруулах, батлах субъектүүд (Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар, Сангийн Яам);
 - Татвар ногдуулах, цуглуулах үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага буюу татварын алба;
 - Төр, татвар төлөгчдөд туслалцаа үзүүлэх төрийн бус байгууллага;
 - Татвар төлөгчид (иргэн, хуулийн этгээд);
 - Татварын үр ашгийг хүртэгчид.
- *Судалгааны асуудлын бүрэлдэхүүн хэсэг нь:*
 - Татвар төлөгч нь татвараа шударгаар төлөх нөхцлийг хангах механизм үйлчлэх;
 - Татварын алба нь татварын хуулийг нийт татвар төлөгчдөд тэгш, шударга хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэх;
 - Татвар хураалт тэгш, шударга байхад туслах механизмыг нэвтрүүлэх.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны зорилго

Монгол Улсын татвар цуглуулах механизмын өнөөгийн байдлыг судлан, түүнд нөлөөлж буй шалтгаан, үр дагаврыг тодотгож, татвар төлөгч нь татвараа сайн дураараа төлөх дадлыг хэвшүүлэх боломжит хувилбар бүхий бодлогын зөвлөмж гаргахад оршино. Татварын төрөл зүйл бүрд татвар хураах механизмыг судлах боломж энэ ажлын хүрээнд хязгаарлагдмал тул зөвхөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийг судалгааны ажлын объект болгон авав.

Судалгааны зорилт

- Монгол Улсын татвар хураах механизмын өнөөгийн байдлыг эрх зүйн орчинтой уялдуулан судлах;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн татвар төлөгч нь татвараа өөрөө тодорхойлон төлөх үүргээ хэрэгжүүлж буй байдлыг судлан үнэлэх;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодорхойлон цаашид татвар цуглуулах механизмыг боловсронгуй болгох бодлогын зөвлөмжийг боловсруулах.

Судалгааны асуудлын хүрээ

Судалгааны асуудал нь Монгол Улсад дагаж мөрдөж буй татварын хуулиудын хэрэгжилтийг хангахад татвар хураах үйл ажиллагааны механизмуудын чиг үүргийг тодотгож авч үзсэн бөгөөд нийт татвар төлөгчдөд нийтлэг үйлчлэх татвар хураалтын механизмын асуудлыг хамарсан болно.

Судалгааны ажлыг зөвхөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хүрээнд ҮСГ, ҮТЕГ-ын тоо мэдээнд тулгуурлан хийсэн ба санал асуулгыг татвар төлөгч, татварын байцаагч гэсэн ангиллаар боловсруулан авсан.

Татвар төлөгчдөөс санал асуулгыг татварын албадаар тараан 2006 оны 3-р улирлын тайлан тушаалтын үеэр Улаанбаатар хот, Баянхонгор аймгаас авсан. Санал асуулгад нийт 799 татвар төлөгч, үүнд Хувьцаат компани 7%, Хязгаарлагдмал хариуцлагатай компани 73%, Нөхөрлөл 7%, Хоршоо 5%, Төсвийн байгууллага 7%, Төрийн бус байгууллагын 1%-ийн төлөөлөл оролцсон.

Татварын байцаагчдаас санал асуулгыг НТГ болон дүүргүүд, Баянхонгор аймгийн 159 байцаагчаас авсан. Санал асуулгад хамрагдсан татварын байцаагчдын 94% нь дээд боловсролтой, 67% нь эмэгтэй, 33% нь эрэгтэй, 40% нь 40–50, 32% нь 30–40, 17% нь 20–30, 11% нь 50–иас дээш насны хүмүүс байв.

Судлагдсан байдал

1998–2002 онд Японы Олон улсын Хамтын Ажиллагааны Агентлаг “Жайка”-аас бүх талыг хамарсан “Татварын тогтолцоог бэхжүүлэх судалгаа” сэдвээр 2 шаттай судалгааны ажил хийгдсэн. Энэ судалгааны ажлын зорилго нь Монгол Улсын татварын тогтолцоонд тулгарч буй бэрхшээлтэй асуудлыг судлан, үнэлэлт дүгнэлт өгөх, шийдвэрлэх арга замуудыг тодорхойлоход чиглэсэн байна. Энэхүү зорилгоо хэрэгжүүлэхэд татварын хуулиудад өөрчлөлт оруулах, шинээр хэрэгжүүлж болох механизмуудыг санал, зөвлөмж болгон гаргасан бөгөөд татварын тогтолцоо тэгш шударга бус, үр ашиггүй болсон, хууль нь зохих түвшинд боловсрогдсон ч хэрэгжүүлэх тал дээрээ маш их саад бэрхшээлтэй байгаа, татвараа өөрөө тодорхойлон тайлагнадаг ч түүний үнэн зөвийг шалгах боломж нөхцөл муу гэсэн дүгнэлтүүдийг өгсөн байна. Энэ судалгаагаар татварын тогтолцоонд тулгарч буй бэрхшээлтэй асуудлуудыг бүхэлд нь авч үзэн шийдвэрлэх арга замуудыг дараах чиглэлээр зөвлөмж болгожээ. Үүнд:

1. Хөх тайлангийн систем нэвтрүүлэх;
2. Албан квантын систем нэвтрүүлэх;
3. Татварын ногдлыг жишгээр тодорхойлох;
4. Татварын нягтлан бодох бүртгэлийн системийг нэвтрүүлэх;
5. Татварын мэдээ баримт цуглуулах, хяналт шалгалтын бэлтгэл шатны ажил;

6. Хэрэг бүртгэлийн систем;
7. Татварын маргааныг шийдвэрлэх эрх зүйн орчинг төлөвшүүлэх;
8. Татвар төлөлтийн орчинг бүрдүүлэх гэх мэт бүх талыг хамарсан олон зөвлөмж өгөхийн зэрэгцээ татварын хуулиудад орох өөрчлөлт, татварын мэргэшсэн нягтлан бодогчийн хуулийн төслийг бэлдэж өгсөн болно.

Энэ судалгааны ажилд өгөгдсөн санал зөвлөмжөөс нилээд нь хэрэгжиж байгаа ч татвар хураалтад шийдвэрлэвэл зохих асуудлууд шийдвэрлэгдээгүй байгаа нь татвар төлөгчдийн үүргээ хэрэгжүүлж буй өнөөгийн байдлаас тодорхой харагдаж байгаа билээ.

Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хуулийн хувьд хялбаршуулсан тогтмол татварын хэлбэрийг хэрэглэх, хяналт шалгалтанд тулгарч буй бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэх арга замууд болон үл хөдлөх хөрөнгө борлуулсан орлогод албан татвар ногдуулах асуудлыг өөрчлөх гэсэн зөвлөмжүүдийг өгснөөс хяналт шалгалтын хүрээнд нилээд нь хэрэгжиж байгаа төдийгүй татварын нягтлан бодогчийн тогтолцоог нэвтрүүлэх ажил эхлэлийн шатандаа явагдаж байна.

Уг судалгааны ажилд Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хуулийн хувьд татвар төлөгчийн тайлагнаж буй татварын тайлангийн үнэн зөвийг шалгах боломжгүй үр ашиг муутай тогтолцоо байгаа болохыг дүгнэж хяналт шалгалтанд тулгарч буй бэрхшээлтэй асуудлыг судлан, шийдвэрлэх арга замуудыг дараах зөвлөмжүүдээр гаргасан. Үүнд:

- Хяналт шалгалтын объектийг сонгох аргыг боловсронгуй болгох;
- Хяналт шалгалтын бэлтгэл ажлыг боловсронгуй болгох;
- Хяналт шалгалтанд хамрагдах аж ахуйн нэгжийг эцэслэн тогтоох;
- Татвар төлөлтийн хүснэгтийг боловсронгуй болгох;
- Хяналт шалгалтын аргыг боловсронгуй болгох;
- Хяналт шалгалтын байцаагчийн ур чадварыг дээшлүүлэх;
- Татварын тайлан гаргадаггүй татвар төлөгчийг илрүүлэх гэсэн зөвлөмжүүдийг өгсөн.

Монгол улсын төсөв, сангийн бодлого, засаглал хоорондын харилцаанд хийгдсэн дотоодын болон олон улсын хамтын ажиллагааны байгууллага, төслүүдээс хийгдсэн олон судалгаанд татварын тогтолцооны асуудал ямар нэг байдлаар хөндөгдөж татварын бодлогын нөлөөллийг авч үздэг нь тодорхой боловч татвар хураалтын тогтолцоонд тухайлан хийгдсэн судалгаа Жайкагийн судалгаанаас өөр хараахан үгүй юм.

ОУВС-гийн төсвийн хэргийн газраас 2001 онд засаглал хоорондын төсвийн харьцааны талаар зөвлөмж гаргахдаа татварын бүтэц, улс, орон нутгийн татварын хуваарилалтыг аж ахуйн нэгжээр бус татварын төрлөөр хуваарилах зохион

байгуулалтыг зөвлөж байсан байна. Мөн татварын албаны үр ашиггүй байгааг хураавал зохих татвараа хурааж чадахгүй байгаа байдал, татварын удирдлагын үйл ажиллагааг судлан дүгнэж, сайжруулах талаар зөвлөмжүүд өгөгдсөний үр дүнд 2003 оноос татвар хураалтад зохих хэмжээгээр ахиц дэвшил гарснаар төсөв ашигтай гарч байгаа үзүүлэлт харуулж байна.

Судлагдахууныг тодорхойлж буй хувьсагч

Татвар хураах механизмын бодлого нь харилцаанд оролцогч талуудын нөхцөл байдалтай уялдаж, үр дүнд нь эерэг нөлөө үзүүлэхэд чиглэнэ.

Оролцогч	Хувьсагч		
	Нөхцөл байдлын хувьсагч	Бодлогын хувьсагч	Үр дүнгийн хувьсагч
Иргэн	Татвар төлөлтийн орчин, үр ашиг Татварын зардал	Иргэний нийгмийн гүйцэтгэх үүргийн харилцааг бүрдүүлэх	Төрийн үйл ажиллагаанд иргэний оролцоо Өрх, гэр бүл өөрийнхөө хүчээр хөгжих
Аж ахуйн нэгж	Татвар төлөлтийн орчин, үр ашиг Татварын зардал	Бизнес эрхлэх орчинг бүрдүүлэх шийдвэрүүд	Бизнесийн хөгжил дэвшил
Төрийн бус байгууллага	Татварын эрх зүй Татвар төлөлтийн орчин	Татварын хуулиудын хэрэгжилтийг хангахад туслах эрх зүйн зохицуулалт	Татвар төлөгч үүргээ хэрэгжүүлэх боломж Татварын хуулийн хэрэгжих нөхцөл
Татварын алба	Татварын бодлого Татварын орлого Татварын эрх зүй	Хуулийн хэрэгжилтийг хангах, татвараа хураах механизм	Төсвийн татварын орлого, Татварын бүртгэл, мэдээлэл, хяналт, татварын өр

Баримт бичгийн бүтэц

Татвар хураах механизм сэдэвт бодлогын судалгааны ажлыг удиртгал, татвар хураалтын механизмын шударга, үр ашгийн шалгуур, татвар хураалтын механизмын өнөөгийн байдал, хамрах хүрээ, дүгнэлт, бодлогын хувилбарууд, зөвлөмж, хавсралт гэсэн бүтцээр боловсруулан толилуулж байна.

2. ТАТВАР ХУРААЛТЫН МЕХАНИЗМЫН ШУДАРГА, ҮР АШИГТАЙ БАЙХ ШАЛГУУР

Татварын хууль тогтоомжуудад тухайн улс орны нийгэм эдийн засгийн орчин бүхэлдээ хамрагддаг нь маш өргөн хүрээний харилцааг зохицуулдаг болохыг харуулдаг билээ. Иймээс хуулийн хэрэгжилтийг тэгш шударга байлгах үүднээс зах зээлийн харилцааны элемент бүрт тохирсон нарийн заалтуудыг хуульд тусгах шаардлага байнга гардаг. Зах зээлийн харилцаа улам боловсронгуй болж эдийн засгийн цар хүрээ өргөжих тусам татварын тооцоо, тайланд тусгах зүйлс нэмэгдэхийн зэрэгцээ татвар төлөгчдийн татвараас зугтах арга ч нарийсдаг ажээ.

Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тэгш шударга нөхцлийг хангах, татвараа үнэн зөвөөр ногдуулан төлөх харилцааг төлөвшүүлэхэд татварын үндсэн зарчмуудын агуулгыг судалж, татвар хураах механизмтай уялдуулах нь чухал юм.

2.1. ШУДАРГА БАЙХ

Татварын шударга байх зарчим нь нийгэмд нийт татвар төлөгчид нь ижил нөхцөл байдалд ижил үүрэг, хариуцлага хүлээхийг хэлэх бөгөөд адил хөрөнгө орлоготой л бол бүгд адил татвар төлөх эсвэл хөрөнгө олсон орлоготойгоо уялдуулан төлөх гэсэн үг юм. Өөрөөр хэлбэр орлого олж, хөрөнгө эзэмшиж, ажил үйлчилгээнд оролцож байгаа л бол нийгмээрээ бүгд татвар төлөх үүрэгтэй. Хэрэв төлөөгүй бол хуулийн дагуу бүгд ижил хариуцлага хүлээх гэсэн механизм үйлчлэх ёстой. Иймээс нийтээрээ татвараа төлдөг байх боломжийг бүрдүүлсэн татвар хураах механизм үйлчлэх ёстой бөгөөд нэг хэсэг нь төлдөг байхад нөгөө хэсэг нь ямар нэг арга замаар татвар төлөх үүргээ хэрэгжүүлэхгүй байх боломжтой нь тэгш шударга байдал алдагдаж байгаагийн илэрхийлэл болно.

Татварын шударга байх зарчим нь татварын ачааллыг татвар төлөгчдөд жигд тэгш хуваарилах, татвар төлөгч нь үүргээ шударгаар гүйцэтгэх утгыг илэрхийлнэ. Төрийн татвар ногдуулалтын бодлого татвар төлөгчдийн аль нэг хэсгийг ялгаварлахгүй байх, төлөгдөхүйц боломжит түвшинд байх, татвар төлөх,

тайлагнах арга зүй нь энгийн тодорхой байх зэрэг нь татварын тогтолцооны шударга байдлыг хэмжинэ.

Татварын тогтолцооны шударга байдал нь татварын харилцаанд оролцогч талуудын аль алины үйл ажиллагаанаас шууд хамааралтай. Төрийн татварын төв голч бодлого, татварын албадын зөв үйл ажиллагаа, татвар төлөгчдийн төрөө дээдлэх, үүргээ гүйцэтгэх хандлага, татвараа төлөх чадвар нь тухайн татварын тогтолцооны шударга байдлыг тодорхойлох шалгуур гэж үзнэ.

Төрийн татварын төв голч бодлого нь татварын харилцаанд оролцогч талуудын эрх ашгийг тэнцвэржүүлэх, нийгэм, эдийн засгийн тэнцвэрийг хангах түвшинд тодорхойлогдох бөгөөд татварын тогтолцооны шударга байдлыг хангах үндэс нь юм.

Татварын бодлого нь татварын хуулиудад тусаж амьдралд хэрэгжинэ. Ийнхүү бодлогын хэрэгжилт хэрхэн явагдаж буйг судалгааны ажлын объект болох ААНОАТ хуулийн зарим заалтуудаар авч үзье.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн харьцуулалт

Хүснэгт 1

Үзүүлэлт	Өмнөх хуулийн хувилбар	Шинэчлэгдсэн хуулийн хувилбар
Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт	Хөнгөлөлт, чөлөөлөлтийг нэг зүйлд хамруулсан 7-р зүйл нь 17 заалттай. 17.1-р зүйл нь 10 заалттай	Чөлөөлөлт, хөнгөлөлтийг зааглаж багасгасан, тодорхой болгосон Чөлөөлөлт 18-р зүйл нь 2 заалттай, 18.1 нь 3 заалттай Хөнгөлөлт 19-р зүйл нь 9 заалттай
Татварын хувь хэмжээ	100 сая хүртэл 15%, 100 саяаас дээш бол 15 сая + 100 саяаас дээш 30%	3 тэрбум хүртэл 10%, 3 тэрбумаас дээш бол 300 сая + 3 тэрбумаас дээш 25%
Татвар ногдох орлогоос хасах зардал	Хасахгүй зардал, хязгаарлалт бүхий зардлын хүрээ өргөн	Бизнесийн үйл ажиллагаа явуулахтай холбогдон гарсан зардлыг хасах
Ногдуулах, тайлагнах	Татвар ногдуулах орлогыг тодорхойлох суурь зарчим тодорхой бус	Татвар ногдох орлогыг аккурэль суурьд үндэслэн тодорхойлно

Өмнөх хуулийн хүрээнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт өргөн учир татвараас зайлсхийх боломж ихтэй, шатлалын босго ойр байгаа нь татвар төлөгчөө жижигрүүлсэн, бүртгэлтэй хэсэг нь татвараа төлдөг, төлөөгүй болон хугацаа хэтрүүлсэн, худал мэдээлсэн татвар төлөгчид хариуцлага хүлээлгэх механизм сул, татварын тайланг хэн ч хамаагүй үйлддэг, худлаа тайлан гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэдэг тогтолцоогүй, мэдээлэл бүртгэлийн тогтолцоо хөгжөөгүй нь тайлангийн үнэн зөвийг тогтоох боломжгүй зэргээс үүдэн төлдөг хэсэгтээ

дарамттай, төлөхгүй байх боломж ихтэй шударга бус татвар хураах тогтолцоо үйлчилж иржээ. Ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчид хэт давуу тал олгосон хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого үйлчилж байв.

Шинэчлэгдсэн хуулийн агуулгад өмнөх хуулиас нилээд ялгаатай бөгөөд хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүрээг хумисан, татварын хувь хэмжээг бууруулсан, шатлалын босгыг холдуулсан, зардлуудтай холбоотой заалтууд тодорхой болж нарийссан, бүртгэж тайлагнах арга зүйг зарим талаар тодорхой болгосон зэрэг нь татвар хураалтыг шударга болгоход эерэг нөлөө үзүүлэх олон давуу талуудыг тусгасан. Гэвч шинээр орсон заалтууд, зарим нарийсгасан ойлголтууд хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхой бус, зарим заалтууд үндсэн зарчмаасаа хазайсан зэрэг сайжруулж засах зүйл нилээд байгааг анхаарахгүй байх аргагүй. Тухайлбал: Төлөөний газар, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн авсан зардал, үндсэн хөрөнгөнөөс бусад импортын бараа материалд төлсөн гаалийн албан татвар, хөрөнгийг ашиглахаа зогсоовол уг хөрөнгийг үлдэгдэл өртөг, зах зээлийн үнийн аль их үнээр худалдан борлуулсан гэж үзэж албан татвар ногдуулна гэх мэтийн заалтуудыг хэрхэн хэрэгжүүлэх нь аргачлалд ч тодорхой бус байна.

Татварын харилцаа тэгш шударга явагдах нэг нөхцөл нь хуулийн заалт хоёрдмол утгагүй, яаж хэрэгжүүлэх нь маш тодорхой байхыг шаарддаг. Иймээс шинэчлэн найруулсан хуулийн хүрээнд тодорхой бус зүйл нилээд байгааг анхаарах нь зүйтэй юм.

2.2. ҮР АШИГТАЙ БАЙХ

Үр ашиг гэдэг нь татварын харилцаанд оролцогч талуудын аль алины ашиг сонирхолд нийцэх хамгийн үр ашигтайгаар хөрөнгийг байршуулах ухагдахуун юм. Төрийн санхүүгийн хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай арга хэлбэрээр хураах, зарцуулах, нийгэм эдийн засгийн зохицуулах асуудлыг шийдвэрлэх зэрэг нь татварын үр ашигт байдлыг илэрхийлнэ.

Татвар төлөгчийн эдийн засагт хүндрэл учруулахгүй байх, татвар төлөх, хураахад зардал хямд байх, энгийн байх, төсвийн зарцуулалт нь нийгмийн хүрээн дэх амин чухал хэрэгцээг шийдвэрлэж байгаа байдал, улс орны хөгжлийн түвшин зэрэг нь татварын харилцааны үр ашигт байдлыг тодорхойлно. Нийгмийн нийт бүтээгдэхүүн, татвар төлөгчийн үйл ажиллагаанд татварын бодлого сөрөг үр дагавар багатай байх, татвараа төлөх механизм нь энгийн хялбар, хураах зардал нь өмнөх үеэсээ буурч байх зэрэг нь татварын үр ашгийг хэмжих үзүүлэлт юм.

Татвар нь татвар төлөгчийн хуримтлалд сөргөөр нөлөөлдөг ч эцсийн дүндээ эдийн засгийн нөөцийг үр ашигтай байршуулах, эдийн засгийг өсгөх, нийгмийн

хэрэглээг нэмэгдүүлж, аж байдлыг дээшлүүлэхэд бага ч гэсэн эерэгээр нөлөөлж байх учиртай.

Татвар төлөгдөх дотоод нөөц, боломжийг илрүүлэн гаргахад татвараа төлөх нийгмийн сэтгэлгээний байдал, төрөөс явуулж байгаа бодлого, төрийн нэр хүнд зэрэг нь татвараа хураан авах механизмын үр ашигт байдалд шууд нөлөөлнө.


Татварын бодлого нь татварыг ногдуулах, хураах үйл ажиллагааг хэрэгжүүлэх энгийн хялбар системийг бүрдүүлэхэд чиглэнэ. Татвар төлөгчид татвараа төлөх, тайлагнах хамгийн энгийн, мөрдөхөд хялбар системийг татвараа өөрөө тодорхойлон төлөх гэдгийг дэлхий нийтээрээ шахуу хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж байна. Гэвч энэ систем үр дүнтэй хэрэгжих нь хууль эрх зүйн орчин, зохион байгуулалт бүтцийн оновчтой байдал, үр дүнтэй механизм, татвар төлөгчдийн татвараа төлөх сэтгэлгээний төлөвшил зэргээс ихээхэн хамаарна. Татвар төлөгчдөд ойлгомжгүй, тодорхой биш, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байвал татварын тэгш, шударга байх зарчим алдагдахад хүрэх бөгөөд ийм тогтолцоонд үр ашгийн асуудал ярихын ч хэрэггүй билээ.

Татварын тогтолцооны шалгуур болох шударга, үр ашигтай байх зарчим нь **татварын оновчтой бодлого, сайн стратеги бүхий удирдлага, боловсронгуй эрх зүйн зохицуулалт, зөв зохион байгуулалт, үр дүнтэй бүртгэл, хяналт, мэдээлэл, татвар төлөгчийн татвараа төлөх сэтгэлгээний төлөвшил** зэргийн тусламжтайгаар татвараа хураан авах шударга механизм үйлчлэхэд оршино.

Монгол улсын төрийн санхүүгийн нөөцийг бүрдүүлэхэд Засгийн газрын агентлагуудын татварын орлогод гүйцэтгэх үүргийг авч үзье.

Улсын нэгдсэн төсвийн татварын орлогод эхлэх хувь

График 1



Улсын нэгдсэн төсвийн орлогод 2004, 2005 онд НДЕГ 14, ГЕГ 34 орчим хувь, ҮТЕГ 50 гаруй хувийн орлогыг бүрдүүлж байсан бол 2006 онд ҮТЕГ-ын бүрдүүлдэг татварын орлого 64,6% болж өсчээ. Энэхүү өсөлт нь ААНБООТ, ашигт малтмалын болон ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлого нэмэгдсэн

нь зарим нэг шинэ татварын объект сонгож хууль хэрэгжүүлсэнтэй холбоотойн зэрэгцээ татварын албадын татвар хураах үйл ажиллагаанд нэг цэгийн үйлчилгээ, сурталчилгааг хэрэгжүүлсэнээр ахиц дэвшил гарч буйг ч дурьдах нь зүйтэй юм.

2.3. ТАТВАР ХУРААЛТЫН ЗАРДАЛ

Татварын албаны зардал

Татварын албаны зардал нь чиг үүргээ гүйцэтгэхтэй холбогдох бөгөөд татварын албадын нийт зардлын дүнг цуглуулсан нийт татварын орлоготой харьцуулан нэг төгрөгний татварын орлогыг цуглуулахад ямар хэмжээний зардал гарч байна гэдгээр хэмжинэ.

ҮТЕГ⁶-ын зөвхөн урсгал зардлын хэмжээгээр татвар хураалтын зардлыг тодорхойлоход 2005 онд 0,012; 2006 онд 0,007 гэсэн тоон үзүүлэлт гарч байна. Энэ нь нэг төгрөгний татварыг хураахад ийм хэмжээний урсгал мөнгөн зардал (хөрөнгийн болон материалын зардал ороогүй) гарсан гэсэн үг. Энэ тоон үзүүлэлт буурч байгаа харагдавч татвар хураалтын чанарын талаас үр ашгийн үзүүлэлт бол татвар төлөгчдөд үзүүлж буй төрийн үйлчилгээний дүр төрхөөр хэмжигдэнэ.

ҮТЕГ-ын зардлын бүтэц


Үзүүлэлт	Хүснэгт 2 /хувиар/	
	2005	2006
Цалин хөлс	59.6	60.8
Нийгмийн даатгалын шимтгэл	15.8	15.9
Бичиг хэргийн зардал	2.1	2.4
Ашиглалтын зардал	5.7	4.9
Түрээсийн зардал	2.9	2.5
Шатахууны зардал	2.4	2.3
Холбооны зардал	3.9	3.4
Томилолтын зардал	1.0	1.7
Урсгал засварын зардал	0.4	1.4
Сургалт, семинарын, ном хэвлэх	2.4	2.8
Нормын хувцас	0.2	0.7
Бусад	3.6	1.2
Үйл ажиллагааны зардлын дүн	100	100

⁶ ҮТЕГ-ын 2005, 2006 оны санхүүгийн тайланд үндэслэн тооцов.

Татварын албаны урсгал зардлын 60 орчим хувь нь цалин хөлсөнд, 16% нь нийгмийн даатгалын зардалд, бусад зардлууд нь 6-аас доош хувийг эзэлж байна. Татварын алба чиг үүргээ хэрэгжүүлэхэд зарцуулж буй зардлын 70 гаруй хувь нь хүний нөөцийн хөдөлмөрийн зарцуулалт байна. Татварын алба 2007 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар нийт 1517 ажиллагсадтай, үүний 1296 нь татварын улсын байцаагчтай бөгөөд татвар хураалт, хяналт шалгалтад 90 гаруй хувь нь ажилладаг. Татварын албаны хүний нөөцийн бүтцэд төсвийн татварын орлогыг цуглуулахад биечлэн үүрэг гүйцэтгэдэг татвар хураалт, хяналт шалгалтад ажилладаг байцаагчдын нийт ажиллагсад, татварын улсын байцаагчдын дүнд эзлэх хувь хэмжээг дараах графикаас харья.

Татварын хураалт, хяналт шалгалтын байцаагч

График 2



Эх сурвалж: УТЕГ-ын мэдээ

Татварын албанд ажиллаж буй нийт ажиллагсдын 63%, нийт байцаагчдын 74 хувь нь татвар хураалт, хяналт шалгалтад ажилладаг байцаагчдын 78% нь татвар хураалтын үйл ажиллагаанд ажиллаж байна. Өөрөөр хэлбэл татварын албаны хүний нөөцтэй холбоотой гарч буй зардлын 80 орчим хувь нь татвар хураалтад зарцуулагдаж байгаа нь татварын албаны үйл ажиллагаа татвар төлөгчтэй харьцаж тайлан авах ажилд ихээхэн хүч хөдөлмөр зарцуулдаг гэж үзэхээр байна. Татварын алба үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нь Татварын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих явдал билээ. Үр ашиг бүхий татвар хураалтын тогтолцоо нь татвараа ногдуулах, төлөх нь татвар төлөгчийн үүрэг тул түүнийгээ цаг хугацаанд нь хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлж, хэрэгжүүлж буйг нь хянахад оршино. Иймд татварын албаны байцаагчдын дийлэнх нь хяналт шалгалтад ажиллаж хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэх учиртай.

Татвар төлөгчийн татварын зардал

Татвар төлөгчийн татварын зардалд шууд болон шууд бус замаар төлж буй албан татвар, төлбөр, хураамжийн хэмжээ, татварыг ногдуулж төлөх ажиллах

хүчний болон материалын зарцуулалтууд хамрагдана. Татвар төлөгчид хуулийн дагуу татвар төлөх үүргээ хэрэгжүүлэх нь татварын хууль тогтоомж, түүнтэй холбоотой заавар, аргачлал, журмыг мэдэх, тайлан гаргах арга зүйд суралцах, харилцагч татварын албандаа татвараа төлөх, тайлагнах, хяналт шалгалтад хамрагдах зэргээр олон зүйлүүдэд суралцах эсвэл мэргэжлийн хүмүүсийн туслалцаа авахад тодорхой хэмжээний мөнгөн болон мөнгөн бус зардлууд гарна.

Татвар төлөгчдийн шууд зардлыг татвар ногдуулах орлогоос болон эзэмшиж буй татвар ногдох зүйлсээс татварын хувь хэмжээгээр тодорхойлон хэмжих боломжтой. Гэвч орлого бүрийн хувьд татвар ногдуулах орлого, татвараа тооцох хувь хэмжээ яг адил байдаггүй. Иймээс татварын бодит хувь хэмжээг тооцоход татвар төлөгчийн бодит татварын зардлын түвшинг тодорхойлно. Аж ахуйн нэгжүүдийн татварын бодит хувь хэмжээг ҮТЕГ-ын МБАХ-ын 2005 оны ААНБОУАТ-ын тайлангийн нэгтгэлийн мэдээлэлд тулгуурлан тооцоход 22% гарч байна. Энэ хувь хэмжээ нь ААНОАТ-ыг төсөвт төлж буй байгууллагуудын татварын зардлын бодит түвшинг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл татвар төлөгчдийн олсон орлогоосоо хэдийг төсөвт төлж буйг илэрхийлнэ. Өнөөдөр аж ахуйн нэгжийн дийлэнх нь хуулийн 1-р шатлалд хамрагдан татвар төлдөг ч орлогын албан татварын орлогыг цөөн тооны татвар төлөгчид төлдөг болохыг дээрх тоон үзүүлэлт нотолж байна.

Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой татвар төлөгчид татварын албанд түгээмэл гаргадаг 15 тайлангаас нэг байгууллага жилд дунджаар 5-аас дээш тайлан гаргаж тушаадаг, тодорхой хэмжээний цаг хугацаа зарцуулдаг, татварын тайлан тооцоог гаргах ажилд ихэнх байгууллагад 1-ээс дээш хүн ажилладаг, тайлан гаргах хугацааг 24% нь хожимдуулдаг ч төдийлөн хариуцлага хүлээж байгаагүй зэргээр судалгааны ажлын хүрээнд татвар төлөгчдөөс авсан санал асуулгад хариулсан байна.

- Татварын тооцоолол хийж, тайлан гаргахад ямар хэмжээний цаг хугацаа шаардагддаг гэж Та бодож байна вэ?

а. Их цаг шаардана 21%	б. Тийм их биш 22%,
в. Ерөнхийдөө гайгүй 52%	г. Мэдэхгүй 5%
- Татварын албанд татварын тайлангуудыг гаргаж тушаахад хэдэн хүн оролцдог вэ?

а. 1 – 49%	б. 2 – 39%
в. 3–5 – 11%	г. 5-аас дээш – 4%
- Татварын бүх тайлангуудыг хуулийн хугацаанд нь гаргаж тушаадаг уу?

а. Тийм 74%	б. Заримдаа хожимдуулдаг 24%
в. Ер нь үгүйдээ 2%	

Татвар төлөгчийн зүгээс татварын хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой үүсэх татварын зардалд татварын хяналт шалгалтад шалгуулахад цаг хугацааны, сэтгэлзүйн зэрэг мөнгөн бус болон мөнгөн зарцуулалтууд гарна. Мөнгөн бус зардал нь шууд хэмжих боломжгүй ч татварын харилцааны дүр төрхөөр тодорхойлох боломжтой юм. Манай улсын татварын харилцаанд зарим татварын байцаагчийн төрийн хүн гэсэн дүр зураг, зандарсан, ихэрхсэн байдал нь татвар төлөгчийн татварын албандаа итгэх итгэл алдрах, төвөгшөөх, займчсан байдал руу түлхдэг нь татвараас зайлсхийх арга замыг сонгоход хүргэдэг талаар судалгааны явцад хүмүүстэй хийсэн ярилцлагаас ажиглагдсан. Мөн түүнчлэн их хэмжээний дүн бүхий зөрчил илэрсэн гэж далайлган түүгээрээ наймаалцах оролдлого хийх байдлаар сэтгэл санааны дарамт шахалтад оруулдаг талаар ч нилээд түгээмэл ярьж байв. Төрийн нэр барин ёс бус зүйлээр татвар төлөгчид хандах нь татварын ногдуулалтын зардлыг өсгөх, төрийн үйлчилгээний чанарыг алдагдуулах, төрийн нэр хүндийг унагах, авилгал үүсэх зэргээр татвар хураалтад сөрөг нөлөө үзүүлнэ.

3. ТАТВАР ХУРААХ МЕХАНИЗМЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

3.1. ТАТВАРЫН ХАРИЛЦАА

Татварын харилцаа төр нь татвараа хураан авах, татвар төлөгч нь өөрт ногдох татвараа төлөхөөс гадна татварын зохицуулалт, хяналтын үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нийгэм эдийн засгийн бүхий л хүрээнд явагдана. Монгол улсын Үндсэн хуульд заасан иргэнийхээ өмнө төрийн хүлээх үүрэг⁷, иргэн нь төрийнхөө болон бусдын өмнө хүлээх үүрэг⁸-ийн нэг илрэл нь татварын харилцаагаар илрэх бөгөөд эцсийн хэмжүүр нь татварын тогтолцооны тэгш шударга, үр ашигтай байх зарчим юм.

Төр өөрийн албаараа дамжуулан татвар төлөгчтэйгээ харьцахын зэрэгцээ эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагын туслалцаа, хамтын үйл ажиллагааны үр дүнд татварын харилцаа хэрэгжих учиртай ч зөвхөн төр, татвар төлөгчийн хооронд үүсэх харилцаанд тулгуурлаж иржээ.

Төрийн сангийн бодлогод татварын бодлого гол үүрэгтэй бөгөөд төрийн санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, нийгэм, эдийн засгийн тэнцвэрийг хангах бодлого нь татварын механизмаар хэрэгжиж татварын харилцаанд биеллээ олдог байна. Иймээс төр бол татварын харилцааны гол субъект нь учир түүний тэгш, шударга байх нь төрийн бодлогоос шууд хамааралтай юм.

Татварын харилцааны нөгөө нэг гол субъект нь татвар төлөгч болох бөгөөд татварын хуулийг хэрэгжүүлэгч нь юм. Харин татварын алба нь төрийн гүйцэтгэх алба буюу татварын хуулийн хэрэгжилтийг хангах төсвийн татварын орлогыг бүрдүүлэгч нь билээ.

⁷ Үндсэн хуулийн 19-р зүйлийн 3-р заалт Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

⁸ Үндсэн хуулийн 17-р зүйл. Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараахь үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ:

3/ хуулиар ногдуулсан албан татвар төлөх;

Татварын харилцаанд зөвхөн төр, татвар төлөгчийн оролцоогоор зогсохгүй хууль, санхүүгийн зөвлөлгөө өгөх, татвар төлөгчдийн эрх ашгийг хамгаалах зэрэг төрийн бус буюу олон нийтийн, эрдэм шинжилгээ, их, дээд сургууль гэсэн субъектүүдийн оролцоо, тэдний идэвхтэй үйл ажиллагаа чухал юм.

Татварын харилцааны үр дүнд нийгэм эдийн засгийн хүрээнд аливаа тэнцвэрийг хангах, төсвийн татварын орлогыг цуглуулж нийгмийн зайлшгүй шаардлагатай үйлчилгээний хэвийн нөхцлийг бүрдүүлнэ. Иймээс татварын харилцаа нь татварын зохицуулалтын, хяналтын, санхүүгийн үүргийг хэрэгжүүлэгч талбар нь ажээ.

Зохицуулалт нь нийгэм эдийн засгийн объект, субъектийг харилцан уялдуулж төрийн өмнө тавигдсан зорилгодоо хүрэх нөхцлийг бүрдүүлдэг учир эдийн засгийн тэнцвэрийг хангах, нийгмийн хөгжилд сөрөг нөлөөллийг бууруулах, орлого хуваарилалтыг тэгшитгэх зэрэг үүрэгтэй.

Зохицуулах механизм нь эерэг, сөрөг урсгалыг бие биерүү нь татах, нийцүүлэхэд чухал үүрэгтэй бөгөөд хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, урамшуулах эсвэл үйл ажиллагааг нь хязгаарлах, хориг тавих зэргээр олон янзын арга замыг хэрэглэнэ.

Монгол Улсын татварын харилцаа зөвхөн төр татвар төлөгчийн хүрээнд явагдах гэдэг ойлголт давамгайлж төрийн алба нь олон нийтийн болон эрдэм шинжилгээний байгууллага, сургуулиудын үүрэг оролцоонд төдийлөн ач холбогдол өгдөггүйгээс энэ хүрээнд хийгдэх ажил зарим нь эхлэл төдий, зарим нь огт сураггүй байна. Татварын боловсрол, судалгааны асуудлын талаар төрийн бодлого үгүй байгаа нь татвараа өөрөө тодорхойлон төлөх тогтолцоо жинхэнэ утгаараа хэрэгжих суурь нөхцөл бүрдээгүй байгаагаар тайлбарлагдана.

3.2. ТАТВАР ХУРААЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Татвар хураах эрх зүйн орчин

Татварын ерөнхий хууль, Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль, тодорхой төрлийн татварын хуулиуд болон эдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан дүрэм, заавар, журам, аргачлал нь татвар хураах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

Татварын алба үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ ҮТЕГ-ын даргын 2002 оны 231-р тушаалаар батлагдсан “Татвар хураах үйл ажиллагааны дүрэм”-ийг мөрдөн ажиллаж байна. Энэ дүрмээр татвар хураах үйл ажиллагаа нь:

- Татвар төлөгчийн бүртгэл хөтлөх, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

- Татвар төлөгчдөд зөвлөгөө өгөх;
- Татварын орлогын төлөвлөгөөний төсөл бэлтгэх;
- Татварын тайланг хүлээн авах;
- Ногдсон татварыг хураах;
- Татварын өр барагдуулах;
- Татварын хууль тогтоомж зөрчигчдөд хариуцлага тооцох гэсэн чиг үүргээр тус тусын эрх зүйн зохицуулалтуудаар хэрэгжиж байна.

Татвар хураах үйл ажиллагааны зорилго нь төсвийн татварын орлогыг бүрдүүлэхэд орших тул татвар төлөгчдөөс цаг хугацаанд нь тайланг нь үнэн зөв гаргуулж, татварыг төлүүлснээр үр дүн нь хэмжигдэнэ.

Татвар төлөгчийн бүртгэл хөтлөх, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах

ҮТЕГ-ын даргын 2001 оны 119-р тушаалаар батлагдсан “Татвар төлөгчийн бүртгэлийн журам”-ыг шинэчилж 2006 оны 258-р тушаалаар батлан 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөж эхэлсэн. Аж ахуйн нэгж, байгууллагыг үүсгэн байгуулахдаа Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж хуулийн этгээд болохын зэрэгцээ татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлж татварын харилцаанд оролцох үүрэгтэй.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг татвар төлөгчөөр бүртгэхдээ хувь хүн, хуулийн этгээдийн хэлбэрээр бүртгэхээс гадна татварын зүйл тус бүрээр нарийвчлан бүртгэж улсын бүртгэлийн гэрчилгээний регистрийн дугаараар татвар төлөгчийн дугаар олгоно.

Татварын албад татвар төлөгчийн бүртгэлийг /байгууллагын оршин байгаа болон эзний оршин байгаа хаягийн аль нэгнээр/ байршилд нь тулгуурлан харьяалуулан бүртгэх бөгөөд 500 саяаас дээш дүрмийн сантай бол ҮТЕГ-ын дэргэдэх Улсын төсвийн орлого, хяналтын газарт, 250.0–500.0 сая төгрөгийн дүрмийн сантай аж ахуйн нэгжүүд Нийслэлийн татварын газарт бүртгүүлэх журамтай. Мөн үйл ажиллагааны чиглэл, цар хүрээг харгалзан харьяаллыг тогтоосон бөгөөд татварын алба бүрийн хувьд баримтлавал зохих зарчим, хүрээг журамд заажээ.

Татварын албаны нэг үүрэг нь татвар төлөгчид татвар төлөх үүргээ хэрэгжүүлж байгааг, нөгөө талаас татварын алба нь татварын хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс татвар төлөгчдөө бүртгэлжүүлэхийн тулд татвар төлөгчийн дугаар бүхий мэдээллийн баазыг бүрдүүлэх нь татвараа хураан авах механизмын үндэс юм.

Энэ үйл ажиллагааны үр дүн нь татвар төлөгч бүр татвараа хэрхэн ногдуулж, төлж буйг мэдэх мэдээллийн бааз болох бөгөөд үүнийг ҮТЕГ-ын тоо мэдээлэлд үндэслэн авч үзье.

Татвар төлөгчийн бүртгэл

Хүснэгт 3

Төрөл	Хариуцлагын хэлбэр	2004.12.31	2005.12.31	2006.12.31
ААН	ХК	389	382	384
	ХХК	24793	29709	35165
	ББН	2051	2007	1916
	ЗБН	1481	1500	1423
	Хоршоо	2370	2197	2088
	Хад.зээлийн хоршоо	556	835	838
	ТӨҮГ	208	199	200
	ОНӨҮГ	146	152	151
	Салбар	1299	1356	1606
	Төлөөлөгчийн газар	18	24	32
	Дүн:	33311	38361	43803
Төсөвт болон ТТБ	Төсөвт байгууллага	4170	4219	4219
	Төрийн бус байгууллага	805	1189	1688
	Шашны байгууллага	182	211	245
	Сан	117	135	153
	Олон нийтийн байгууллага	1352	1392	1378
	Дүн:	6626	7146	7683
Нийт дүн:		39937	45507	51483

Эх сурвалж: УТЕГ, Мэдээлэл боловсруулалт, автоматжуулалтын хэлтсийн мэдээ. 2007 он

Монгол Улсад аж ахуйн нэгж байгууллага гэдэгт хуулийн этгээдийн бүх төрөл хамрагдаж байв. Иймээс хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх Татварын албаны Улсын бүртгэлийн алба, Хууль Зүй Дотоод Хэргийн Яаманд бүртгүүлсэн этгээд нь Монгол Улсын хуулийн дагуу албан татвар төлөгчөөр бүртгүүлж татварын албатай харьцан татвар төлөгчийн үүргээ гүйцэтгэх учиртай.

Татвар төлөгч аж ахуйн нэгжийн тоо жилд дунджаар 5000 гаруйгаар нэмэгдэж байгаа нь шинээр бизнесийн нэгж үүсэхээс илүүтэйгээр хуучнаа салгах, жижиглэх замаар аж ахуйн нэгж үүсгэх хандлага илүү байдагтай холбоотой ажээ.

Шинэчилсэн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль нь ашиг олох зорилготой үйл ажиллагааг хамруулах агуулгаар батлагдсан тул төрийн болон ашгийн бус хуулийн этгээдүүд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөгчөөр бүртгүүлэхгүй. Харин бусад татварыг төлөх тул тухайн татварын төрлөөр татварын албандаа бүртгүүлнэ. Өмнө нь бүх хуулийн этгээд татварын албанд бүртгүүлэх агуулгатай байсан ч улсын бүртгэлтэй мөртлөө татварын албанд бүртгэлгүй олон

аж ахуйн нэгж байгаа нь ХЗДХЯ–нд бүртгэлтэй төрийн бус байгууллагаас мянга гаруй нь татварын албанд бүртгүүлсэн байгаагаас тодорхой болно.

Татвар төлөгчийн бүртгэлд бүртгэгдсэн этгээд нь татварын албанд татвар төлөх үүргээ хэрхэн хэрэгжүүлж буйгаа тайлагнах тул уг бүртгэл нь тайлан хүлээн авах үйл ажиллагааны үндэс болох учир үнэн зөв байх шаардлагатай. Гэтэл татвар төлөгчийн тоо яг хэд вэ? гэдгийг тодорхойлох аргагүй байгааг дараах тоонуудаас харья.

	2005 оны татвар төлөгчийн тоо	Зөрүү
• ААНБОАТ–ын тайлангийн ирцийн мэдээ	30411	
• Татвар төлөгчийн бүртгэлийн хөдөлгөөний мэдээ	45774	+15363
• Татвар төлөгч хуулийн этгээдийн тоо	42853	-2921
• Аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн товчоо	45991	+3138
• Татвар төлөгчийн бүртгэл	45507	-484

Дээрх статистик тоо нь ҮТЕГ–ын мэдээлэл боловсруулалт автоматжуулалтын хэлтсийн мэдээ бөгөөд ҮСГ–ын мэдээгээр Хуулийн этгээд, аж ахуйн нэгж байгууллагын тоог 39677 гэж тайлагнажээ. Эндээс татвар төлөгчийн тоо яг хэд вэ? гэдгийг хэрхэн тодорхойлох вэ?

Татвараа хураах үйл ажиллагааны эхний шат болох татвар төлөгчийн бүртгэл нь хэрхэн явагдаж буйг судалгааны ажлын явцад авсан санал асуулгын дүнгээс харья.

Татвар төлөгчдийн хариулт:

- Танай байгууллагын улсын бүртгэлийн дугаар, татвар төлөгчийн дугаар адил байдаг уу?
 - а. Тийм 50,5%
 - б. Үгүй 49,5%
- Танай байгууллагын хуулийн этгээдийн эрхгүй салбар, төлөөлөгчийн газар нь татварын албанд бүртгүүлж татвар төлөгчийн дугаар бүхий салбарын гэрчилгээтэй авсан уу?
 - а. Тийм 48,8%
 - б. Үгүй 51,2%
- Үгүй бол яагаад?
 - а. Шаардлагагүй 63,5%
 - б. Шаардлагатай эсэхийг мэдэхгүй 23,6%
 - в. Шаардлагатай гэдгийг мэднэ, гэхдээ хэрхэн бүртгүүлэхийг мэдэхгүй 5,5%
 - г. Шаардлагатай гэдгийг мэднэ, гэхдээ төвөгтэй асуудлаас зайлсхийхийг хүсдэг 7,4%

- Татвар төлөгчийн бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулаагүйгээс Та ямар хариуцлага хүлээсэн вэ?
 - а. хариуцлага хүлээгээгүй 72,5%
 - б. торгууль 20%
 - в. сануулга 7,5%
- Танай байгууллага татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлэхдээ аль хаягийг сонгосон вэ?
 - а. Аж ахуйн нэгжийн оршин байгаа хаяг 74%,
 - б. Удирдлагын оршин байгаа гэрийн хаяг 26%
- Татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлсэн хаяг өөрчлөгдөх тохиолдол бүрт татварын албанд шилжих хөдөлгөөн хийлгэх шаардлагатай гэж Та үзэж байна уу?
 - а. Шаардлагагүй 25%
 - б. Шаардлагатай эсэхийг мэдэхгүй 15%
 - в. Шаардлагатай 47%
 - г. Шаардлагатай, гэхдээ төвөгтэй асуудал ихтэй 13%

гэж тус тус хариулсан.

Татварын байцаагч нарын хариулт

Татвар төлөгчийн бүртгэлийг хэрэгжүүлж буй өнөөгийн практикаас татвар хураалтад ямар нэг сөрөг нөлөө гардаг уу? гэсэн асуултад 54% нь тийм;

Татвар төлөгчийн татварын албанд харъяалагдах хаяг аль нь байвал илүү зохистой вэ? гэсэн асуултад 49% нь ажлын байрны, 21% нь эзний оршин байгаа, 22% нь Үл хөдлөх хөрөнгийн хаяг;

Татвар төлөгчийн шилжих хөдөлгөөний өнөөгийн практикийг асуусан асуултад журмын дагуу явагддаг 40%, татвар төлөгчийн хүсэлтээр 39%, ихэвчлэн танилын нөлөөгөөр хийгддэг 21%;

Шилжих хөдөлгөөнийг хэрхэн баталгаажуулдаг вэ? гэсэн асуултад 47% нь албаны даргын тушаалаар, 28% нь албаны даргын цохолтоор, 5% нь ам шийдвэрээр, 9% нь ямар нэг баталгаажуулалт шаардахгүй гэж тус тус хариулсан.

Татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой учирдаг бэрхшээлтэй асуудалд бүртгүүлсэн хаягандаа байдаггүй, хаягаа буруу бүртгүүлдэг, шилжиж хөдөлгөөнөө хийлгэдэггүй, хорооны бүртгэл буруу байдаг зэргийг дурьджээ.

Санал асуулгын дүнгээс харахад татвар хураалтын үйл ажиллагааны эхний шат болох татвар төлөгчдийг бүртгэх үйл ажиллагаа тодорхой цэгцэрч нэгдсэн

нэг агуулгаар хэрэглэгддэггүй, татварын албадын хоорондох шилжих хөдөлгөөн журмын дагуу хэрэгждэггүй нь татвар төлөгчийн тоо мэдээ үнэн зөв гарах боломжгүй болдог байна. Татварын албаны зохион байгуулалт хэдийгээр орон нутгийн хэлбэрээр зохион байгуулагдсан ч татвар төлөгч нь танил талаа дагах байдлаар харьяалагдахыг илүүд үзэх, хаягаа буруу бүртгүүлж татвараас зайлсхийх практик хэрэгждэг нь татвар хураалтад хүндрэл учруулдаг байна. Түүнчлэн татвар төлөгчийн харьяалал журмын дагуу хэрэгждэггүй татварын хэлтсийн дарга нарын хооронд наймаалцал маягаар явагддаг, албаны дарга өөр дүүрэг рүү шилжихдээ өөрийн гэсэн газруудаа аваад шилждэг практикийг ч дурьдаж байгаагаас харахад татвар төлөгчийн харьяаллаар журам гаргах шаардлага байна уу, хэрэв байвал түүний хэрхэн дагаж мөрдөх вэ гэдгийг ч бодох цаг болжээ.

Өөрчлөгдсөн журам нь татвар төлөгчийн дугаар олгох, бүртгүүлэх хугацаа, харьяаллыг тогтоох, бүртгэх үйл ажиллагаа, нэмэлт өөрчлөлт, шилжих хөдөлгөөн, бүртгэлээс хасалт хийх, татварын албадад харьяалуулах шалгуурыг хаяг, үйл ажиллагааны хүрээгээр зааглах агуулгыг тусгасан. Гэвч татвар төлөгчийн харьяаллыг хаяг, бизнесийн үйл ажиллагааны чиглэлээр заагласан ч хэрхэн хэрэгжүүлэх болон энэ журам хэрэгжээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага, хяналт тавих талаар тодорхой зүйлгүй байгаа нь өмнөх практик цаашид үргэлжлэхээр байна.

Татвар төлөгчдөд зөвлөгөө өгөх

Татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх ажилд шинэчлэлт хийж, татварын алба, татвар төлөгчдийн хоорондын итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээний хүрээнд татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор УТЕГ-ын даргын 2002 оны 111-р тушаалаар “Асуулт, хариултын сан байгуулах, ашиглах журам” батлан мөрдөж байгаа бөгөөд татвар төлөгчийн өдрийг тэмдэглэх, гарын авлага материал бэлтгэж тараах, утас ажиллуулах зэргээр ажиллаж иржээ. Татвар төлөгчдийн хүсэж буй үйлчилгээний талаар санал асуулгад дараах байдлаар хариулсан байна.

Татвар төлөгчийн хариулт:

Татварын албанаас ямар үйлчилгээ бий болоосой гэж Та хүсч байна вэ? гэсэн асуултад хүнд сурталгүй шударга нээлттэй үйлчилгээг бий болгох, сургалт, семинар тогтмол явуулах, мэдээллээр хангах, онлайн, интернетээр тайлан авах, гарын авлага, маягтаар хангах, нягтлан бодогчийг урамшуулах зэргээр саналаа гаргаснаас сургалт, семинар тогтмол явуулах гэж нийт оролцогчдын 64% нь хариулжээ.

Татварын байцаагчийн хариулт:

Татвар төлөгчид татварын байцаагчаас ямар зөвлөлгөө хүсдэг вэ? гэсэн асуултад татварын хуулийн талаар, орлого зардлын ангиллын талаар, татварын тайлан гаргуулах, холбогдох маягт бөглөх гэх зэргээр хариулжээ

Татварын алба “Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлал гаргах, сургалт, сурталчилгаа явуулах”⁹ гэсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой журам, заавар, аргачлал боловсруулан баталж мөрдүүлдэг бөгөөд өнөөгийн байдлаар татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой ҮТЕГ-аас 180 гаруй журам, заавар, аргачлал, дүрмийг батлан мөрдөж байгаа. Түүнчлэн Улсын дээд шүүхийн тайлбар бүхий тогтоол, Засгийн газар болон Сангийн сайдын тогтоолууд ч нилээд байгаа билээ.

Сургалт, сурталчилгаа явуулах ажил нийт татвар төлөгчдөд хүртээмж муутай байдаг тул татвар төлөгчдөд энэ хэрэгцээ байдаг нь санал асуулгын хариултаас харагдаж байна. Татварын эрх зүйн хүрээнд татвартай холбоотой бүх хууль, тогтоол, журам, аргачлал, дүрмийг татвар төлөгчид хүргэх нь зөвхөн төсвийн хөрөнгөөр, татварын албадаас хийгээд хүчрэхгүй нь тодорхой тул өөрөө удирдах ёсны байгууллагын оролцоо зайлшгүй гэдгийг хүлээн зөвшөөрч ажиллах боломжийг нь олгох шаардлага байгааг ойлгож хэрэгжүүлэх хэрэгтэй юм.

Татварын орлогын төлөвлөгөөний төсөл бэлтгэх

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн 21-ийн 3-р заалт, ҮТЕГ-ын даргын 2001 оны 148-р тушаалаар батлагдсан “Татварын орлогын бүртгэл хөтлөх журам” ҮТЕГ-ын даргын 2002 оны 17-р тушаалаар батлагдсан “Орон нутгийн татварын албадаас улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг бүртгэх, мэдээлэх журам”, ҮТЕГ-ын даргын 2002 оны 231-р тушаалаар батлагдсан “Татвар хураах үйл ажиллагааны дүрэм”-ийн 5-р заалт зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Төсвийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийн үзүүлэлт нь татварын алба болон байцаагчийн ажлыг дүгнэх нэг гол үзүүлэлт болох тул төсвийн татварын орлогын төлөвлөгөө биелүүлэх нь татвар хураалтын нэг механизм гэсэн агуулгаар ханддаг нь татвар төлөгчдийн өөрт ногдох татвараа өөрөө тодорхойлон төлөх зарчимтай зөрчилддөг ажээ. Энэ нь шинэчлэгдсэн хуулинд бүр тодорхой заалт болон орсон байгаа бөгөөд хэт төлөвлөгөөнд тулгуурлан хэлбийх нь олон талын гажуудал үүсгэдэг болохыг өмнөх практикаас бид мэднэ. Санал асуулгад оролцогчдын тодорхой хэсэг нь татварын орлогын төлөвлөгөө нь татвар хураах үйл

⁹ Татварын ерөнхий хуулийн 23-ын 2 дахь заалт

ажиллагаанд сөрөг нөлөөтэй, үүнийг цаашид өөрчлөх шаардлагатай гэж үзсэн нь дээрх үзлийг батална.

Татварын байцаагчийн хариулт

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төлөвлөгөө нь татвар төлөгч нараас татварын орлогыг цуглуулахад нэг механизм болж нөлөөлдөг гэж Та бодож байна уу? гэсэн асуултад 19% нь тийм, 72% нь татвар цуглуулахад төдийлөн хамааралгүй, 9% нь төлөвлөгөө нь татвар төлөгчийн татвараа төлөх сэтгэлгээнд сөрөг нөлөө үзүүлдэг;
- Татварын албадын үйл ажиллагааг төсөвт оруулах татварын орлогын төлөвлөгөөг биелүүлснээр хэмждэг нь хир зохистой удирдлагын арга барил гэж Та боддог вэ? гэсэн асуултад 16% нь зохистой, 23% нь зохисгүй, 15% нь өөр арга байхгүй, 46% нь цаашид өөрчлөх шаардлагатай;
- ААНБОАТ-ын төлөвлөгөөг биелүүлэхийн тулд Та хариуцсан байгууллагуудынхаа хэд орчим хувьтай нь харьцаж хуульд заасны дагуу татвараа өөрөөр нь тодорхойлуулан төлүүлж чаддаг вэ? гэсэн асуултад 18% нь 50-иас доош орчим, 50% нь 51–75 орчим, 23% нь 76–99 орчим гэж тус тус хариулжээ.

Татварын албаны ажлын гол үзүүлэлт нь ямар хэмжээний төлөвлөгөөг яаж биелүүлсэнд тулгуурлах бус ногдуулсан татварынхаа хэдэн хувийг хураан авч буй, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хэрхэн хяналт тавьж хуулийн хэрэгжилтийг хангахад татвар төлөгчдөд хэрхэн туслав гэдэг концепц баримтлах нь албаны үндсэн чиг үүрэгтэйгээ нийцэх юм. Учир нь ТЕХ-д татварын албаны чиг үүрэг нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хуулийн хэрэгжилтийг хангах нөхцлийг бүрдүүлэх, татвар төлөгчдөд тусалцаа үзүүлэх замаар төсвийн орлогыг бүрдүүлэхийг заасан байгаа.

Төсвийн татварын орлогын төлөвлөгөө бол улс орны хувьд төсвийн орлогын чиг баримжаа болгон холбогдох байгууллагууд үйл ажиллагаагаа төлөвлөх үндэслэл болохоос татвар төлөгчдийн заавал биелүүлэх даалгавар болох боломжгүй гэсэн татвар ногдуулалтын үндсэн зарчимтай нийцэх ойлголтыг төлөвшүүлэх нь чухал юм.

Татварын тайлан хүлээн авах

ҮТЕГ-ын даргын 2001 оны 134-р тушаалаар батлагдсан “Албан татварын тайлан хүлээн авах журам”-ыг мөрдөж байсан бол шинэчилсэн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ҮТЕГ-ын даргын 2006 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 267 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн маягт

нөхөх заавар”, ҮТЕГ–ын даргын 2006 оны 12 дугаар сарын 6–ны өдрийн 235 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийг хэрэгжүүлэх аргачлал”–ыг 2007 оны 1 дүгээр сар 1–нээс мөрдөж байна.

Татвар хураах үйл ажиллагааны гол ажил татвар төлөгчдөөс тайланг нь хүлээн авч ногдуулсан татварыг нь цаг хугацаанд нь төлүүлэх буюу хуулийг хэрхэн хэрэгжүүлж буйд нь хяналт тавих явдал юм. Татвар төлөгч бүр татвар ногдох орлоготой ч бай, орлогогүй ч бай татварын тайлангаа гарган татварын албанд тогтоосон хугацаанд тушаах үүрэгтэй. Иймээс татварын алба нь татвар төлөгчийн тайланг хүлээн авах хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлдэг төрийн үйлчилгээний нэгж юм.

Татвар төлөгчийн тайлан нь татварын хууль тогтоомжийг хэрхэн хэрэгжүүлсэнээ илэрхийлэх гол үзүүлэлт болох тул татварын алба хүлээн авсан тайландаа үндэслэн үнэлэлт дүгнэлт өгч татвар төлөгчийг ангилан, хяналт шалгалт хийх хүрээгээ тодотгон, татварын хууль тогтоомжуудыг шударгаар хэрэгжүүлэх нөхцөл боломжийг хангах асуудлуудыг шийдвэрлэх ажлыг гүйцэтгэнэ.

Татвар төлөгчийн үйлдсэн тайланг үнэн зөв гаргах нөхцлийг бүрдүүлэх нь татвар хураах механизмуудыг оновчтой хослуулан хэрэглэхэд мэдээлэл, бүртгэл, хяналт, хариуцлагын зүй зохистой уялдааг хангасан тогтолцоо хэрэгжих ёстой.

Татварын тайлан хүлээн авалтын өнөөгийн байдал, татварын албадын үйл ажиллагааг татварын байцаагчдаас авсан дараах санал асуулгын хариултаас харья.

- 2005 онд алдагдалтай болон Х тайлан гаргасан татвар төлөгчийн хэд орчим хувьд нь татварын ногдлыг шууд бус аргаар хийсэн вэ? гэсэн асуултад 1–20% гэж 60%;
- Татвар төлөгчийн татварын ногдол, тайланг хүлээн авч буй өнөөгийн зохион байгуулалтын талаар Та ямар бодолтой байдаг вэ? гэсэн асуултад ерөнхийдөө боломжийн гэж 37%, өөрчлөх шаардлагатай гэж 34%;
- 2005 онд алдагдалтай гэж татварын тайлан гаргасан байгууллагуудад урьдчилсан хяналт хийсэн үү? гэсэн асуултад үгүй гэж 13%, бараг үгүй гэж 32%, ихэнхэд нь хийсэн гэж 46%;
- Х тайлан гаргаж буй татвар төлөгчийн үйл ажиллагаанд бүрэн хяналт тавьж чаддаг уу? гэсэн асуултад үгүй гэж 25%, бараг үгүй 37%, ихэнхэд нь тавьдаг гэж 36%;
- Татварын тайланд тулгуурлан татварын хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой ямар нэг судалгаа шинжилгээ хийж ажилладаг уу? гэсэн асуултад 52% нь тийм, 48% нь үгүй гэж тус тус хариулсан байна.

Монгол Улсын татварын албадын татварын тайлан хүлээн авах үйл ажиллагаа нь “Х” болон алдагдалтай тайлан гаргагчдаа тэр бүр хяналт тавьж чаддаггүй, татварын тайланд үндэслэн үнэлэлт дүгнэлт өгч ажиллах үйл ажиллагаа төлөвшөөгүй байгаа нь өнөөгийн зохион байгуулалтыг ямар нэг хэмжээгээр өөрчлөх шаардлагатай байгааг харуулж байна.

Татварын алба нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлж татварын тайланг хүлээн авч байгаа нь төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай болгоход чиглэсэн сайн үйлчилгээ болсон гэдгийг санал асуулгад оролцогчид үнэлсэн. Гэвч татвар төлөгчдөөс тайлангаа бүрэн хүлээж авах, татварын тайлангийн үнэн зөв байдлыг хангах, татвараас зайлсхийгчдийн хүрээг хумих, татвараа цаг хугацаанд нь төлдөг болохтой холбоотой хоорондоо уялдаа бүхий механизм үгүйлэгдсээр байгаа болно.

Ногдсон татварыг хураах

Татвар төлөгч нь татвараа өөрөө тодорхойлон төлөх тул татварын албаны зорилго нь ҮТЕГ-ын даргын 2002 оны 231-р тушаалаар батлагдсан “Татварыг хураах үйл ажиллагааны дүрэм”-ийн дагуу ногдсон татварыг нь хураахад оршино. Ногдсон татварыг хураах үйл ажиллагаа нь тайлангийн хугацаанд төлсөн татварын гүйцэтгэл, илүү болон дутуу төлөлт, буцаан олголт, бусад татварын зүйл хоорондын суутгал зэрэг үйл ажиллагааг хянаж хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад чиглэнэ.

Татварын ногдлийг хийхдээ татварын алба:

- Өөрөө тодорхойлсон ногдлын үнэн зөвийг хянах
- Өөрөө тодорхойлох үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд татварын албанаас тодорхойлж төлүүлэх гэсэн хэлбэрээр хэрэгжүүлдэг.

Өөрөө тодорхойлсон татварын ногдлын үнэн зөвийг тайлан хүлээн авах явцад арифметик үйлдлийн хувьд нь шалган татварын дутуу төлөлтийг төлүүлэхэд голлон анхаарч байгаа нь татвар хураалтад гол хүчээ төвлөрүүлэхэд хүргэдэг. Харин энэ үүргийг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хэрэгжүүлж, татварын алба ногдсон татварыг хураах, татварын тайлангаа ирүүлээгүй, Х болон алдагдалтай тайлан гаргаж буй татвар төлөгчдөд хөндлөнгийн мэдээлэл ашиглах, жишгээр татвар ногдуулан төлүүлэх арга замуудыг хэрэгжүүлж хуулийн хэрэгжилтийг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэх нь үндсэн чиг үүрэгтэйгээ үйл ажиллагаагаа нийцүүлэх ач холбогдолтой юм.

Татварын байцаагчдын хариулт:

- 2005 онд татварын тайлангаар ногдуулж тайлагнасан татварын төлбөрийн хэд орчим хувь нь тайлангийн хугацаанд төлөгдсөн вэ? гэсэн асуултад 50-аас доош гэж 11%, 50–75 орчим гэж 40%, 75 орчим 46% нь гэж хариулжээ.

Дээрх санал асуулгын хариулт нь тайлангийн хугацаанд ногдсон татвараа ямар түвшинд хураан авч буйг харуулж байна. Мөн түүнчлэн татвараа өөрөө ногдуулан төлөх үүргийг нийт татвар төлөгч ямар түвшинд хэрэгжүүлж буй нь тайлан тушаалтын судалгаанаас тодорхой байгаа.

Ногдуулсан татвараа цаг хугацаандаа хураан аваагүй нь тухайн тайлант хугацаанд татварын өрийн үлдэгдэл болж байгаа болно. 2006 оны тайлангийн ногдуулалтаас 45894 сая төгрөг буюу нийт ногдуулалтын 7,2%-ийн татвар хугацаандаа төлөгдөөгүй бол хяналт шалгалтын ногдуулалтаас 6474,1 сая төгрөг буюу 28,9% нь хугацаандаа төлөгдөөгүй байна.

Татварын өрийн төлөлтийн байдал

	Хүснэгт 4 /Сая төгрөгөөр/			
	2005–12–31	Төлөлт	Эзлэх хувь	2006–12–31
Тайлангаар	92164,5	74169,8	95,3%	17994,7
Хяналт шалгалт	13634,5	3664,2	4,7%	9970,3
Дүн	105799,0	77834,0	73%	27965

Эх сурвалж: УТЕГ, Мэдээлэл боловсруулалт, автоматжуулалтын хэлтсийн мэдээ. 2007 он

2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2005 оны 12 дугаар сарын 31-ний өрийн үлдэгдлээс 26,4% нь төлөгдөөгүй байгаагийн 65 хувь нь тайлангийн ногдуулалтаарх татварын өр байна. Татвар төлөгч өөрөө татвараа тодорхойлон төлж буй тогтолцоонд татварын төлбөр хугацаандаа төлөгдөх эрх зүй үйлчилдэг. Хэрэв хугацаандаа төлөгдөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсний хүүг хуулийн дагуу ногдуулах ёстой. Гэтэл 28 орчим тэрбум төгрөгний татварын төлбөр бүтэн нэг жил төлөгдөөгүй байна гэсэн үг.

Ногдсон татварыг цаг хугацаанд нь хураан авч дуусгах нь татварын албаны үндсэн үүрэг бөгөөд хэрэв цаг хугацаандаа төлөөгүй бол хүү тооцож хариуцлага хүлээлгэдэг механизм ямарч татварын албаны ажилтнаас хамааралгүй хэрэгждэг байх нь өнөөгийн татварын албаны тогтолцоонд үгүйлэгдэж байна.

Татварын өрийн судалгаа

Татварын өрийг барагдуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд УТЕГ-ын даргын 2001 оны 142-р тушаалаар батлагдсан “Татварын өр болон буцаан

олголтын бүртгэл хөтлөх, өр барагдуулах журам”; Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 272–р тушаалаар батлагдсан Татварын өрийг “Мэдэгдэх хуудас”–аар хураан барагдуулах тухай журам, Татварын өрийг татвар төлөгчийн банкиндахь хөрөнгөнөөс үл маргах журмаар гаргуулах тухай журам; Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, ҮТЕГ–ын даргын 2002 оны 134/192 –р тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэртэй татварын өр төлбөр барагдуулах тухай”; ҮТЕГ–ын даргын 2002 оны 219–р тушаалаар батлагдсан “Татварын өрийг татвар төлөгчийн эд хөрөнгө, цалин хөлс, бусад орлогоос гаргуулах тухай журам”, “Татварын өрөнд авсан эд хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах журам”, “Эд хөрөнгө битүүмжлэхэд баримтлах журам”, “Татвар төлөх хугацааг сунгахад баримтлах журам”, “Үзлэг хийхэд баримтлах журам” зэрэг олон эрх зүйн актууд батлагджээ.

Төлөгдөөгүй татвар нь татварын албанд татварын авлага болон хуримтлагдах бөгөөд татвар төлөгчдийн хувьд хуримтлагдсан өр төлбөр болно. Татварын өр хэдий их хуримтлагдана тухайн татварын тогтолцоо татвар хураах үйл ажиллагаагаа зүй зохистойгоор хэрэгжүүлж чадахгүй байгааг илэрхийлнэ. Иймээс татвар хураах үйл ажиллагаа нь ногдсон татварыг хураах, татварын өрийг хураан барагдуулахад чиглэдэг. Татварын өрийг хураан барагдуулах нь тухайн татварын албаны хүрээнд хууль тогтоомжийн дагуу албадлагын аргыг хэрэглэхийг шаардах тул түүний хүрээнд дагаж мөрдвөл зохих эрх зүйн актууд өргөнтэй билээ.

Татварын өр

Үзүүлэлт	Хүснэгт 5 /Сая төгрөгөөр/		
	Тайлан	2004–12–31 Хяналт шалгалт	Дүн
Өрийн үлдэгдэл	61245,3	12711,4	73956,7
Эзлэх хувь	82,8	17,2	100

Үзүүлэлт	2005–12–31		
	Тайлан	Хяналт шалгалт	Дүн
Өрийн үлдэгдэл	92164,5	13634,5	105799,0
Эзлэх хувь	87,1	12,9	100

Үзүүлэлт	2006–12–31		
	Тайлан	Хяналт шалгалт	Дүн
Өрийн үлдэгдэл	58386,8	15175,6	73562,4
Эзлэх хувь	79,4	20,6	100

Эх сурвалж: ҮТЕГ–ын Татвар хураалт, үйлчилгээний хэлтсийн мэдээлэл. 2007 он

Татварын албаны татварын өрийн үлдэгдлийг сүүлийн 3 жилийн үзүүлэлтээр авч үзэхэд нийт өрийн 80 орчим хувийг тайлангийн үеийн татвар ногдуулалтаасаа төлөгдөөгүй үлдэгдэл эзэлж байна. Татвар төлөх, тайлагнах хугацаа адил тул тайлангийн тасалбар болгох хугацаагаар өрийн мэдээлэл гаргах нь тайланг тушаах хугацаа хүртэл төлөгдсөн татвар нь өр болж харагдаж байгаа нөлөөлөл бий. Тайлангийн өрийн үлдэгдлийг урьд оны болон тайлант үеийн гэдгээр салган үзэхэд 2006 оны 12 дугаар сарын 31-нд урьд оны (2006 оны 2 дугаар сарын 10 гэхэд төлөгдсөн байх ёстой) 17994,7 сая төгрөг, хяналт шалгалтаар ногдуулсан татвараас 9970,0 сая төгрөгний үлдэгдэлтэй гэж мэдээлэгдсэн нь нийт ногдуулалтаасаа хурааж авч чадаагүй өрийн хэмжээг харуулна.


Татварын төлбөр хугацаандаа төлөгдөөгүй тохиолдолд татварын алба хэрхэн ажилладаг талаар тодруулахад хугацаандаа төлөгдөөгүй татварт хүүг зөвхөн хяналтын байцаагч тооцож акт тавьдаг байна. Татварын алба ногдуулсан татвараа хугацаандаа хураах механизм үйлчилдэггүй, нөгөө л хяналтын байцаагчийн субъектив нөлөөлөл бүхий үйл ажиллагаа хэрэгждэг ажээ.

Татварын албадад хамаарах өрийн үлдэгдлийн хэмжээг судлан үзэхэд 30–50 орчим хувийг нь УТОХГ, 12–15 орчим хувийг НТГ, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг, Дархан–Уул, Сэлэнгэ аймгуудын татварын өр удаалж байгаа бөгөөд татварын алба бүр зохих хэмжээгээр өрийн үлдэгдэлтэй байна.

Татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, тогтоогдсон актны тодорхой хэсгийг татвар төлөгчид хүлээн зөвшөөрөлгүй маргаан үүсгэдэгээс шийдвэрлэвэл зохих өрийн асуудал цагдаагийн байгууллага, шүүхээр шийдвэрлэхэд хүргэдэг. 2006 онд 200 гаруй аж ахуй нэгж байгууллага маргаан үүсгэсний 30 гаруй нь шүүхийн шатанд, 10–аад нь цагдаагийн байгууллагад, үлдсэн нь татварын албанд хянагдаж байгаа бөгөөд нийт маргаантай өрийн байдлыг дараах графикаар харуулав.

2006 оны маргаантай өр /сая төгрөгөөр/

График 3




Татварын хууль зөрчигчдөд хүлээлгэж буй хариуцлага

- ҮТЕГ-ын даргын 2002 оны 168-р тушаалаар батлагдсан “Татварын хяналт шалгалтын ажлын дүрэм”-ийн дагуу татвар төлөгчийн үүргээ гүйцэтгэж буй байдалд хяналт шалгалт явуулах бөгөөд ихэвчлэн ТЕХ-ийн 13-р зүйлийн заалтуудын дагуу хариуцлага ногдуулна.
- Мөн “Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль”-ийн 3.5, 5.1, 5.2, 5.4, 5.5, 8.1, 8.3, 25.1.2, 25.1.3, 25.1.4, 31, 32, 33.2, 34 дүгээр зүйлийн заалтыг зөрчсөн татвар төлөгч болон холбогдох бусад этгээдэд татварын алба, татварын улсын байцаагч мөн хуулийн 42 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.
- Татварын хууль тогтоомжийг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 44 зүйлд заасан хариуцлагыг тус тус хүлээлгэнэ.
- Татварын хууль тогтоомжийг зөрчсөн зөрчил нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй бол “Эрүүгийн хууль”-ийн 166, 167-р зүйлийн заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Татварын хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж

График 4



Татварын албадын гол чиг үүрэг нь “Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих” билээ. Татварын албаны байцаагчдын 20 орчим хувь нь энэ чиг үүргийг хэрэгжүүлж байгаа бөгөөд тухайн тайлант хугацаанд нийт татвар төлөгчийн 20 гаруй хувийг хяналт шалгалтад хамруулдаг ажээ.

Хяналт шалгалтад хамруулах татвар төлөгчийг сонгох олон аргыг ашигладаг ч субъектив хүчин зүйлийн нөлөө их байдаг талаар татвар төлөгч, татварын алба аль аль нь хүлээн зөвшөөрдөг нь ажиглагдсан. Улс төрийн нөлөө, удирдлагын нөлөө, нэг нь нөгөөгийнхөө үйл ажиллагааг шалгуулах гэж мэдээлэх мэтийн үйл ажиллагаа татварын албаны хяналт шалгалтын үйл явцад гардаг нь нэг талыг барьсан шийд гаргахад хүргэх төдийгүй, татвар төлөх сэтгэлгээнд сөрөг үр дагавар үүсгэдэг байна. Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс илэрсэн зөрчлийн хэмжээг сүүлийн 3 жилээр судлан үзэхэд 2004 оноос 2005 онд 47,1%, 2006 онд 72,6%-ийн өсөлттэй байна.

	2004	2005	2006*
Зөрчлийн өсөлт	100	147.1	117.4
Хяналт шалгалтад хамрагдсан ААН-ийн өсөлт	100	115	117
Зөрчил илэрсэн ААН	100	114.6	125.2


Эх сурвалж: УТЕГ-ын МБАХ-ын мэдээ (* – урьдчилсан мэдээгээр тооцсон)

Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо өсөхийн зэрэгцээ зөрчил илэрсэн аж ахуйн нэгж, зөрчлийн хэмжээ ч өсч байгаа нь татварын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих албаны чиг үүргийн хэрэгжилтийг нэг талаас харуулах ч, нөгөө талаас татвар төлөгч татвараа өөрөө тодорхойлон үнэн зөв төлөх үүргээ хэрхэн хэрэгжүүлж буйг ч илэрхийлнэ.

Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн 80 орчим хувьд нь ямар нэг хэмжээгээр зөрчил илэрдэг бөгөөд, нийт зөрчлийн дүнгийн 10 гаруй хувьтай тэнцэх хэмжээний нөхөн төлбөр, хүү ногдуулдаг ажээ. Илэрсэн зөрчилд ногдох хариуцлагын хэмжээ тоон дүнгээр өссөн байгаа ч хувь хэмжээний хувьд ялихгүй өөрчлөлттэй болохыг дараах графикаас харъя.

Хяналт шалгалтын зөрчил, хариуцлага

График 5



Татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн дүнг татвар төлөгчийг хяналт шалгалтад хамруулсан үндэслэл буюу сонголтын үндэслэлээр авч үзвэл 80 орчим хувь нь графикт болон ээлжит шалгалтад хамрагдсан татвар төлөгчдөөс илэрчээ.

Татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил

Үзүүлэлт	Хүснэгт 6 /хувиар/		
	2004	2005	2006
Сонголтоор	0.24	0.03	0.001
Татвараа төлөөгүй	0.01	0.002	0.09
Тайлангаа ирүүлээгүй, Х тайлан	0.09	1.5	0.62
Тайланд хийсэн дүгнэлтээр	1.28	3.27	3.43
Бусад байгууллагын хүсэлтээр	2.02	2.09	7.92

Үзүүлэлт	Хүснэгт 6.Үргэлжлэл /хувиар		
	2004	2005	2006
<i>Мэдээлэл, өргөдөл, гомдлоор</i>	4.62	7.91	0.91
<i>Хөндлөнгийн мэдээллээр</i>	3.95	1.71	2.98
<i>Сэдэвчилсэн</i>	0.42	0.69	1.43
<i>Графикт</i>	79.02	81.30	79.39
<i>Бүртгэлээс хасагдах, татан буугдах</i>	1.93	1.27	1.2
<i>Бусад</i>	6.42	0.19	2.04

Эх сурвалж: УТЕГ-ын МБАХ-ын мэдээ

Татварын хяналт шалгалтаар илэрч буй зөрчлийн хэмжээ нь хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн тоотой уялдах бөгөөд нийт шалгагдсан аж ахуйн нэгжийн 68% нь графикт шалгалтаар шалгагдсан байна. Татварын өрийн хэмжээ өссөн, маргаантай өрийн шийдвэрлэлт төдийлөн буураагүй байгаа нь татварын хариуцлага тооцох тогтолцоо сул байгаагийн илэрхийлэл юм.

Татвар хураалтын өнөөгийн байдал

Монгол Улсын татвар хураах арга нь үүргийн буюу албадлагын гэсэн хэлбэрээр хэрэгждэг, үүргийн арга нь татвар төлөгч өөрөө татвараа тодорхойлон төлөх гэсэн үзэлд тулгуурладаг ч урьдчилан төлөх, суутган төлөх, цуглуулан төлөх хэлбэрүүдээр татвар нь төлөгдөнө. Харин татвар төлөгч үүргээ хэрэгжүүлээгүй болон буруу хэрэгжүүлсэн тохиолдолд төр албадлагын аргаа хэрэглэх буюу жишгээр эсвэл хяналт шалгалтаар нэмэлт төлбөр, хүү, торгууль ногдуулах хэлбэрүүдээр хэрэгжинэ. Татвар цуглуулах механизмын өнөөгийн мэдээлэл, бүртгэл, хяналт, хариуцлагын механизмууд боловсронгуй бус, тодорхой бус, хууль эрх зүйн болон татвар төлөх орчинг бүрдүүлэх механизм төлөвшөөгүй зэрэг нөхцөл байдлууд нь татвар төлөгчдөд үүргээ үнэн зөвөөр хэрэгжүүлэхгүй байх, хэрэгжүүлсэн ч татварт зориулан худал мэдээлэх боломжийг бүрдүүлдэг нь судалгаа болон санал асуулгын дүнгээс тодорхой байна.

Татвар төлөгчийн хариулт

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланг үнэн зөв мэдээлэлд тулгуурлан гаргаагүйгээс ямар нэг хуулийн хариуцлага хүлээж байсан уу? гэсэн асуултад 82% нь үгүй; Татварын албанд тайланг гаргаагүй болон хожимдуулсны төлөө хариуцлага хүлээсэн тохиолдол бий юу? гэсэн асуултад 79% үгүй гэж хариулсан бол Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланг гаргахдаа бизнесийн үйл ажиллагааныхаа үнэн зөв мэдээлэлд тулгуурлан бүх ажил гүйлгээгээ бодитоор нь хамруулан тайлагнадаг уу? гэсэн асуултад 65% нь тийм, 28% нь боломжгүй зүйл, 4% нь тэгэх шаардлагагүй, 3% нь үгүй гэж хариулжээ.

Санал асуулгад хариулсан татвар төлөгчдийн 35 хувь нь татварын албанд үнэн зөв мэдээлэл өгөх боломжгүй бөгөөд шаардлагагүй, тайлангаа үнэн зөв гаргаагүй, хожимдуулсны төлөө хариуцлага хүлээж байгаагүй гэж 80 орчим хувь нь хариулсан нь татварын алба нь тэр бүр хариуцлага тооцож, татвар төлөгчдөө хүрч чаддаггүй болохын илэрхийлэл юм. Энэ нь татвараа өөрөө үнэн зөв тодорхойлон төлөх механизм хэрэгжих чадваргүй тогтолцоо үйлчилж байгаагийн илрэл юм. Мөн татвар төлөхгүй байх боломжтой гэдэг тогтолцоо үйлчилж буйг ч баталж байна.

ААНБОАТ-ын тайлан тушаалтын байдал


Хүснэгт 7

Он	Татварын албанд тайлан ирүүлбэл зохих	Тайлан ирүүлсэн	Үүнээс				Эзлэх хувь			
			Х тайлан	Алдагдалтай	Татвар төлөхөөр	Тайлан ирүүлсэн	Үүнээс			
							Х тайлан	Алдагдалтай	Татвар төлөх орлоготой	Тайлан ирүүлээгүй
2002	21096	19794	5183	3079	11532	93,8	26,2	15,6	52	6,2
2003	22414	21291	4795	3423	13092	95	22,5	16,1	56,4	5
2004	26431	24990	6286	3957	14747	94,5	25,2	15,8	50,5	5,5
2005	30401	27746	7593	4582	15571	91,3	27,4	16,5	47,4	8,7

Эх сурвалж: УТЕГ-ын МБАХ-ийн мэдээлэл

ААНБОАТ-ын тайлан тушаалтын байдал

График 6




Татвар хураах механизмын хэрэгжилт нь татвар төлөгчдийн татварын тайлангаа гарган тушааж буйгаар хэмжигдэнэ. Энэ талаар гарсан тоо баримтаас харахад нийт аж ахуйн нэгжийн 90,0 гаруй хувь нь татварын албанд тайлангаа

ирүүлдэг үүний 30,0 орчим хувь нь Х тайлан гаргадаг, 20 орчим хувь нь алдагдалтай ажилласан гэж тайлагнадаг, 10 орчим хувь нь тайлан ирүүлдэггүй байна.

Энэ үзүүлэлт нь татвараа өөрөө үнэн зөв тодорхойлон төлөх үүргийн хэрэгжилт ямар түвшинд хэрэгжиж буйг илэрхийлж байгаа бөгөөд бүртгэгдсэн аж ахуйн нэгж байгууллагын 40 гаруй хувь нь татвар ногдуулах орлоготой ажиллаж ямар нэг хэмжээгээр аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг төлдөг байхад үлдсэн хэсэг нь ямар нэг байдлаар орлогын албан татвар төлөх үүргээсээ өөрийгөө чөлөөлдөг гэдгийг харуулж байна.

Татварын ачаалал

График 7



ААНБОАТ-ын татварын түвшин

Хүснэгт 8

	2001	2002	2003	2004	2005
1 Татварын түвшин	29,4	28,9	28,6	30,3	27,7
2 Орлогын албан татварын түвшин	5,8	5,8	6,6	7,5	7,1
Татварын нийт түвшинд эзлэх хувь	19	20	23	25	25,6
3 ААНБОАТ-ын түвшин	3,9	3,7	4,7	5,1	4,8
Орлогын албан татварт эзлэх хувь	67	64	71	68	67

Эх сурвалж: МУСТГ-ын эмтгэл УБ, 2005.

Дээрх хүснэгт нь Монгол улсын татварын нийт ачаалал, түүн дотроос орлогын албан татварын болон ААНБОАТ-ын ачаалал, түүнд эзлэх хувийн жинг тодорхойлбол нийт татварын орлогын 20 орчим хувийг орлогын албан татвар, үүний 70 орчим хувийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар бүрдүүлж байгаа нь шууд татвар түүн дотроо аж ахуйн нэгжийн орлогын албан татварын үүрэг бага байгааг илэрхийлэх бөгөөд нийт татварын орлогод шууд бус татварын үүрэг давамгайлж буйг илэрхийлж байна.

Аж ахуйн нэгж байгууллагын эдийн засгийн чадавч,
татвар ногдуулалтын байдал /2005 оны мэдээлэл/

№	Хариуцлагын хэлбэр	Борлуулалтын орлого					Татвар ногдуулах орлого					Ногдуулсан татвар			
		10 сая	10-50 сая	50-100 сая	100-аас дээш сая	Нийт	100 саяаас доош	100 саяаас дээш	Нийт	100 саяаас доош	100 саяаас дээш	Нийт	100 саяаас доош	100 саяаас дээш	Нийт
1	Хувьцаат компани	56,6	33,3	6,1	5,8	100	83,2	16,8	100	2,75	97,25	100	2,75	97,25	100
		1,1	3,3	3,3	1,1		0,72	9,32		3,2	4,4		3,2	4,4	
2	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	71,9	14,3	3,9	9,9	100	98,3	1,7	100	3,4	96,6	100	84,2	91,1	
		75,8	80	78,5	97,6		72,25	83,05							
3	ББНөхөрлөл	81,8	17,4	0,6	0,2	100	99,9	0,1	100	50,4	49,6	100	1,6	0,06	
		6,3	7,2	0,8	0,1		6,83	0,42		100	100		1,0		
4	ЗНБНөхөрлөл	90	9,7	0,3		100	100		100	100		100			
		4,7	2,7	0,4			5,27								
5	Хоршоо	94,4	4,2	1,4		100	100		100	100		100			
		7,6	1,8	2,2			6,91								
6	Хадгаламж зээлийн хоршоо	78,1	11,9	8,8	1,2	100	98,8	1,2	100	48,7	51,3	100	2,6	0,1	
		2,4	1,9	5,0	0,3		2,67	2,12							
7	Төрийн өмчтэй үйлдвэрийн газар	23,5	12,5	56,6	7,4	100	89,2	10,8	100	1,9	98,1	100	2,1	4,1	
		0,2	0,4	8,1	0,5		0,38	2,96							
8	Олон нийтийн өмчтэй үйлдвэрийн газар	46,5	27,3	21,9	4,4	100	96	4	100	47,8	52,2	100	0,6	0,02	
		0,3	0,8	2,3	0,2		0,32	0,84							

Үргэлжлэл Хүснэгт 9

№	Хариуцлагын хэлбэр	Борлуулалтын орлого					Татвар ногдуулах орлого					Ногдуулсан татвар			
		10 сая	10-50 сая	50-100 сая	100-аас дээш сая	Нийт	100 саяаас доош	100 саяаас дээш	Нийт	100 саяаас доош	100 саяаас дээш	Нийт	100 саяаас доош	100 саяаас дээш	Нийт
9	Салбар	67,2	23,0	9,8	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
		0,2	0,4	0,6			0,19					2,3			
10	Төсөвт байгууллага	45,5	27,3	9,1	18,1	100	50	50	100	0,3	99,7	100			
		0,02	0,08	0,1	0,1		0,01	0,84				0,02	0,22		
11	Төрийн бус байгууллага	77	19	4	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
		0,4	0,5	0,6			0,27					0,32			
12	Шашны байгууллага	75,5	20,8	2,5	1,2	100	98,9	1,1	100	65,7	34,3	100			
		0,6	0,8	0,4	0,1		0,62	0,42				0,67	0,01		
13	Сан	100			100	100	100	100	100	100	100	100	100	100	100
		0,02					0,02					0,02			
14	Олон нийтийн байгууллага	100			100	100	100	100	100	100	100	100	100	100	100
		0,32					0,44					0,32			
15	Давхар нэгж	100			100	100	100	100	100	100	100	100	100	100	100
		0,04					0,04					0,001			
Нийт дүн	Тоогоор	20597	3872	1089	2213	27771	14970	236	15206	14970	236	14970	236	14970	236
	Хувиар	74,2	13,9	3,9	8,0	100	98,4	1,6	3,7	96,3	100	3,7	96,3	100	100

Эх сурвалж: УТЕГ-ын МБАХ-ийн 2005 оны мэдээлэл.

Жич: хариуцлагын хэлбэр бүрт 2 мөр байгаа. Дээд мөр нь тухайн хариуцлагын хэлбэрт эзлэх хувийг харуулж байгаа бол доод мөр нь (бичмэл) татвар төлөгчдийн нийт дүнд эзлэх хувь болно.

Дээрх хүснэгт нь татвар төлөгчдийн эдийн засгийн чадавхийг хариуцлагын хэлбэр бүрээр борлуулалтын орлого, татвар ногдуулах орлогоор харуулав. Татвар төлөгчдийн 74% нь 10 сая хүртэл борлуулалтын орлоготой, 98,4% нь 100 сая хүртэл татвар ногдуулах орлоготой, нийт ногдуулсан татварын 3,8%-ийг энэ хүрээний татвар төлөгчид төлдөг бол 100 саяаас дээш төгрөгний татвар ногдох орлоготой татвар төлөгч 236 буюу нийт татвар төлөгчийн 1,6%-ийг, нийт ногдуулсан татварын 96,2%-ийг төсөвт төлдөг байна. Монгол улсын орлогын албан татвар төлөгч аж ахуйн нэгжийн эдийн засгийн чадамж харилцан адилгүй, тооны талаасаа бол хэт жижиг аж ахуйн нэгж зонхилдог, төсвийн орлогын албан татварын орлогыг бүртгэлтэй нийт татвар төлөгчдийн 1,6% нь үүрч байгаа нь татварын тэгш шударга байх зарчимтай нийцэхгүй билээ. Татварын албанд бүртгэлтэй нийт аж ахуйн нэгжийн 74% нь 10 саяас доош борлуулалтын орлоготой, нийт аж ахуйн нэгжийн 40 орчим хувь нь татвар ногдох орлоготойгоор тайлангаа гаргадаг нь НӨАТ-ын босго давахгүй байх сонирхолтой байдгийг батлахын зэрэгцээ татвар төлөх үүргээсээ зайлсхийх хүрээ өргөн байгаа гэдгийг ч харуулж байна.

**2005 онд Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хуулийн дагуу
үзүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлт /мянган төгрөгөөр/**

Хүснэгт 10

Татвар ногдох орлогоос чөлөөлөгдөх орлого			Орлогын албан татвараар эдэлсэн хөнгөлөлтийн дүн		
Үзүүлэлт	т/т тоо	Дүн	Үзүүлэлт	т/т тоо	Дүн
Засгийн газрын зээллэгийн хүү	12	1826107	Газрын тосны салбарт борлуулалтаас олсон орлогод	5	2919898,7
Төрийн бус байгууллагын гишүүд дэмжигчдийн татвар хандив	20	545566,6	Газрын тосны салбарт гадаадад гуйвуулах үед	1	10871,2
Донорын цус, цусан бүтээгдэхүүн, эд эрхтэнийг эмчилгээнд хэрэглэснээс олох орлого	1	8678	Үр тариа, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл	141	1963603,3
Нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангийн орлого	6	488596,4	Эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ	30	28573851,7
Монгол банкны орлого	1	398,3	Цахилгаан, дулааны станц	5	600667,5

Татвар ногдох орлогоос чөлөөлөгдөх орлого			Орлогын албан татвараар эдэлсэн хөнгөлөлтийн дүн		
Үзүүлэлт	т/т тоо	Дүн	Үзүүлэлт	т/т тоо	Дүн
Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын орлого	50	736432,1	Нефть, хатуу түлш, төмөрлөг, металбург	1	4629480,9
Гадаадын хөрөнгө оруулагч	4	3151560,8	Гадаадын хөрөнгө оруулалт – экспорт	16	7369739,8
Дүн	94	6757339,2	Дүн	199	46067413,1

Эх сурвалж: УТЕГ-ын МБАХ-ийн 2005 оны мэдээлэл.

2005 онд нийт 293 аж ахуйн нэгжид 52824752,3 төгрөгний хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн нь нийт татвар төлөгчийн нэг орчим хувь буюу тухайн жилд ногдуулсан татварын 8 хувьтай тэнцэх хэмжээний чөлөөлөлт, 25,8 хувьтай тэнцэх хэмжээний хөнгөлөлт эдэлсэн байна. Хөнгөлөлт, чөлөөлөлт хэдий чинээ өргөн байна татварын бааз суурь багасах, ялгаварлал үүсэх сөрөг нөлөөтэй.

Татвар хураах үйл ажиллагаа

“Төвлөрсөн төсвийн орлого, хяналтын газар, аймаг, нийслэл, дүүргийн татварын хэлтэс (газар)-ийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн стандарт” нь татварын албадын үйл ажиллагааг дүгнэхэд баримтлах эрх зүйн баримт юм. Татварын алба нь татвар төлөгчдийг татварын тайлан тушаалт, татвар төлөлт, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаар нь А, В, С, D, E, F¹⁰ гэж ангилан, ангилал тус бүрт хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагатай хэрхэн ажиллах чиглэлээ тогтоон ажилладаг. Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх орлогын албан татварын хуваарийг татвар төлөгчийн үйлдвэрлэл, үйлчилгээтэй нь уялдуулах, төлөх татварыг хуулиар тогтоосон хугацаанд төлөхийг татвар төлөгчид сануулах бөгөөд татварын төлөлтөд нь хяналт тавин ажилладаг.

Татварын тайлан хүлээн авах үед татварын урьд оны өр, тайлант жилийн ногдуулалтын тооцоог нягтлан бодох бүртгэлийн баримт, бичгүүдтэй тулган шалгах, өмнөх тайлан тушаалтын үед татвар төлөлт, барагдуулалтын талаар өгөгдсөн үүрэг, даалгавар, хэлэлцэн тохиролцсон арга хэмжээний биелэлтийг гаргах, хэрэв дутуу хийгдсэн ажил, татварын төлбөр байвал шалтгааныг нь тогтоох, шийдвэрлэх болон тайлант жилийн тайлангаар гарсан татварын ногдлын дутууг хуулийн хугацаанд

¹⁰ Төвлөрсөн төсвийн орлого, хяналтын газар, аймаг, нийслэл, дүүргийн татварын хэлтэс (газар)-ийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн стандарт

хэрхэн барагдуулах талаар тохиролцох, шаардлагатай гэж үзвэл татварын дутуу төлөлтийг төлж барагдуулах график гарган төлүүлэх зэргээр ажилладаг.

Алдагдалтай тайлан гаргасан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд судалгаа, дүгнэлт хийх, ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй татвар төлөгчийн үйл ажиллагаа, үр ашигтай нь харьцуулан судлах, алдагдалтай ажиллахад нөлөөлсөн хүчин зүйлийг судлан тогтоох үүрэгтэй.

Үйл ажиллагаа явуулаагүй буюу «Х» тайлан гаргасан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаагаа явуулаагүй шалтгааныг тогтоох, уг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны талаар хөндлөнгийн мэдээлэл цуглуулах замаар тэдэнтэй ажиллах чиг баримталдаг байна.

Татвар төлөгчийн бүртгэлд байгаа боловч бүртгүүлсэн байршил, хаягтаа байдаггүй, татварын тайлангаа тушаадаггүй аж ахуйн нэгжүүдийг эрэн сурвалжилж олох, хаягаа сольсон, тайлан тушаахгүй байгаа нөхцөл, шалтгааныг нь тогтоож, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг удирдлагаас чиглүүлдэг ажээ.

Аж ахуйн нэгжийн орлого, зарлагыг үнэн зөв, бодитой болгох, эцсийн эцэст татварыг шударгаар ногдуулан төлүүлэх үндсэн нөхцөл болсон нягтлан бодох бүртгэлийн анхан шатны бүртгэлийг хөтөлдөг болгох, бэлэн мөнгөөр худалдаа, үйлчилгээ хийж байгаа аж ахуйн нэгжүүдэд кассын машин нэвтрүүлэн ашиглуулах зэрэг янз бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлж иржээ. Ер нь татвараа өөрөө тодорхойлон төлөх үүргийн хэрэгжилтийг хангахад дараах нөхцлүүдийг бүрдүүлэхийг шаарддаг байна. Үүнд:

- Хууль тогтоомжийн заалтууд ойлгомжтой, тодорхой байх;
- Татварын алба нь татвар төлөгчдөдөө үйлчилгээ үзүүлдэг алба байх;
- Татвар төлөгчийг бүртгэх, тайлан авах, буцаан олголт хийх үйл ажиллагаа хөнгөн шуурхай зохион байгуулагдсан байх;
- Татвар төлөгч үүргээ хэрэгжүүлэхээс өөр гарцгүй байх хураалтын хүчтэй механизм үйлчлэх;
- Хариуцлага хүлээхээс өөр аргагүй хяналтын тогтолцоотой байх;
- Төр, татвар төлөгчдөд туслалцаа үзүүлдэг үйлчилгээний тогтолцоотой байх зэрэг.

3.3. ТАТВАРЫН МЕХАНИЗМЫН ОЙЛГОЛТУУД

Татварын удирдлагын үйл ажиллагаанд татварын механизмын үүргийг хүчтэй болгох замаар нийгэм эдийн засгийг эрүүлжүүлж байж сая түүний хөрсөн дээр төсвийн санхүүгийн тогтвортой, найдвартай эх үүсвэрийг бүрдүүлэх нөхцлийг хангаж чадна.

Механизм гэдэг үгийг машин, багаж хэрэгсэл, аппарат зэрэг юмсыг хөдөлгөж чадах оньс¹¹ гэж тайлбарлажээ. Тэгвэл татварын механизм нь татварын объектод удирдлагын субьектээс үйлчлэх хэрэгсэл, татварын удирдлагыг практикт хэрэгжүүлэх оньс болох тул **татварын системийн хүрээнд татварын бодлогыг хэрэгжүүлэх зорилгыг хангах үүднээс төрийн зүгээс авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны цогц** гэж тодорхойлж болно. Татварын механизм нь арга зүйн болон аргачлалын шинж чанартай ойлголт бөгөөд үндэсний орлогын нэг хэсгийг нийгэмчлэх, дахин хуваарилалтын харилцааг удирдах бодит үйл явц болдог тул зохион байгуулалт, зохицуулалтын талаас илүү үүрэгтэй.

Татварын механизмын үйлчилгээ нь үйл ажиллагааны хувьд татвар хураах, зохицуулах гэсэн хоёр дэд системээс бүрдэнэ. Тэдгээрийн хооронд зохистой харьцааг бүрдүүлэх нь татварын оновчтой механизм бүрдсэний илрэл болно. Татварын механизм нь өөр хоорондоо харилцан шүтэлцээ бүхий удирдлагын үндсэн чиг үүргээр хэрэгжинэ. Татварын удирдлага нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгмийн харилцааг нэгтгэх үйл ажиллагаа гэвэл түүний механизм нь татварын тогтолцооны объектод удирдлагын субьектээс үйлчлэх хэрэгсэл, татварын үүргийг амьдралд хэрэгжүүлэх зохион байгуулалт, зохицуулалт, төлөвлөлт, хяналтын чиг үүрэг юм.

Татварын зохион байгуулалтын механизм нь татварын орлогоо яаж хураах, татвар төлөгчдөд татвараа төлөх энгийн тогтолцоог бүрдүүлэх, татварын төрөл, зүйлийн сонголт, албадуудын ажил үүргийн хуваарилалт зэргийг эмхлэн цэгцлэх үүрэгтэй.

Татварын төлөвлөлтийн механизм нь стратеги, тактик, үйл ажиллагааны бодлогыг тодорхойлно. Иймд татварын орлогыг аль төрөлд тулгуурлан, ямар хувь хэмжээгээр, ямар арга замаар хураан улс, орон нутгийн төсвийн орлогоо бүрдүүлэх вэ гэдэгт төлөвлөлтийн үүрэг их юм.

Татварын зохицуулалтын механизм нь нийгэм эдийн засгийн аливаа хүрээний тэнцвэрийг хангахад чиглэдэг тул татварын урамшуулал, хязгаарлалтын хөшүүргийг илүү хэрэглэнэ. Гэхдээ хяналтын механизмтай нэгдмэл байдлаар хэрэгжих нь түгээмэл байдаг тул татварын бүхэл хүрээнд энэ хоёр механизмын үүрэг ихээр илэрнэ.

¹¹ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. 336х

Татвар хураах механизмын чиг үүрэг

Хүснэгт 11

Үзүүлэлт	Зохион байгуулалт	Төлөвлөлт	Зохицуулалт	Хяналт
Төсвийн орлого	Татварын зүйлээр	Төсвийн төлөвлөгөө	Төсвийн санхүүжилт	Төсвийн зарцуулалт
Татварын алба	Улсын төсөв болон орон нутгийн төсөв	Алба бүрээр, татварын зүйл бүрийн төлөвлөгөө	Татвар хураах нэгжүүд	Хуулийн хэрэгжилт
Татвар төлөгч татвараа төлөх	– Өөрөө тодор– хойлон төлөх – Суутган авч төлөх – Цуглуулан төлөх	Татварын албадаас төлөвлөгөө өгөх	Мэдээлэл Бүртгэл Хөнгөлөлт Чөлөөлөлт	Үйл ажил– лагааны үр дүн Татварын зардал

Татвар хураах механизмын чиг үүргийн ерөнхий дүр төрхийг дээрх хүснэгтээр харуулав. Татвар хураах үйл ажиллагаа нь татвар төлөгчөөс хуулийн хэрэгжилтэд нь хяналт тавих замаар ногдуулсан татварыг нь цуглуулахад татвар төлөгч, татварын албанд үр ашиг бүхий, хоорондоо уялдаа холбоотой механизмуудыг хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн хүрээн дэх татварын механизмын чиг үүрэг

Хүснэгт 12

Үзүүлэлт		
1	Зохион байгуулалт	Хэн энэ татварыг төлөх вэ? Юунд татвар ногдуулах вэ? Яаж татвар ногдуулах орлого, татвараа тооцох вэ? Ямар хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх вэ? Ямар хувь хэмжээгээр ногдуулах вэ? Хэзээ, хэрхэн төлж тайлагнах вэ? гэдэгт хариулт өгөх
2	Төлөвлөлт	Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хуваарийг үндэслэн харъяалах татварын алба тухайн татварын жилд төлөх албан татварын сар, улирлын хуваарийг албан татвар төлөгчид хүргүүлнэ
3	Зохицуулалт	Албан татвараас чөлөөлөх 3 нөхцөл, хөнгөлөх 3 нөхцөл, алдагдлыг шилжүүлэх, зардлын хязгаарлалт, татвараа өөрөө тодорхойлох болон суутгалаар төлөх
4	Хяналт	Татвар төлөгчийн ангилал, орлогын ангилал, хасах зардал, элэгдлийн зардал, зээлийн хүүгийн зардал, харилцан хамаарал бүхий этгээд, суутган төлөлт

Шинэчлэн найруулсан аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль нь татварын механизмын үүргийг нарийсган тусгаж, нилээд тодорхой болгосноороо өмнөх хуулиасаа давуу талтай ч цаашид механизмын хүрээг боловсронгуй болгох зүйл нилээд байгаа болно.

3.4. ТАТВАР ХУРААЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төсвийн орлого бүрдүүлэлтээр татварыг Улсын болон орон нутгийн татвар гэж ангилна. Татварын алба улсын татварыг төвлөрсөн төсвийн дансанд, орон нутгийн татварыг орон нутгийн төсвийн дансанд цуглуулах бөгөөд Монгол Улсын татварын албаны зохион байгуулалт Үндэсний Татварын Ерөнхий Газар, Нийслэлийн Татварын Газар, Дүүргийн татварын хэлтэс, Аймгийн татварын хэлтэс, Сумын татварын байцаагч гэсэн нэгжтэй. Татвар төлөгч нь татварын албандаа аж ахуйн нэгжийн болон нутаг дэвсгэрийн холимог хэлбэрээр харъяалагддаг.

Манай улс татвараа цуглуулахдаа татвар төлөгч нь өөрөө татвараа тодорхойлон төлөх, суутган авч төлөх, цуглуулан төлөх хэлбэрүүдээр хэрэгжиж байна. Татвараа өөрөө тодорхойлон төлөх системийг дэлхийн ихэнх орнууд хэрэглэдэг нь татварын албаны үйл ажиллагаа үр ашигтай байх зарчимтай уялдана. Энэ үүрэг нь татвар төлөгчдөөс:

- татвар ногдуулах орлогоо зөв тооцож, тодорхойлох
- тайлангаа тогтоосон хугацаанд нь гаргаж тушаах
- татвараа хугацаанд нь бүрэн төлөхийг шаардана.

Энэ систем нь татвар төлөгчид нь төрөө дээдлэх, төр нь татвар төлөгчдөө хүндлэх зарчимд тулгуурлан хэрэгжих бөгөөд татвар төлөх нь нэр төрийн хэрэг буюу иргэнийхээ үүргийг хэрэгжүүлж буй хэлбэр юм гэдэг үзэлд үндэслэдэг ажээ.

Татвар төлөгч нь өөрийн явуулж байгаа үйл ажиллагаанаас ямар хэмжээний орлого олж байгаа, түүнийг олохтой холбогдуулан ямар хэмжээний зардал гарч байгааг баримтжуулан бүртгэж татварын албанд тайлагнах үүрэгтэй. Орлого зарлагаа бүртгэснээр бизнесийнхээ үйл ажиллагааны үр дүнгээ хир хэмжээний ашигтай байгаа цаашид өргөтгөх боломжтой эсэх, үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөх үү гэдгээ бизнес эрхлэгч нар мэдэх боломжтой болно. Гэвч татвар төлөгчдийн дийлэнх нь энэ үүргээ хэрэгжүүлэхийг мэддэггүй, тайлан бүртгэлийн ач холбогдлыг төдийлөн ойшоодоггүй байдлаас татварын хяналт шалгалтаар ямар нэг зөрчил илэрдэг байна.

Татварын харилцаа явагдах үндэс нь татвар төлөгч орлого, татвараа өөрөө үнэн зөв тодорхойлон төлөх тул татварын талаар зөрчил гаргахгүй байх, хэрэв гарвал түүнийгээ өөрөө хариуцах үүрэгтэй ажээ.

Татвар хураах ерөнхий зохион байгуулалт нь үүргийн болон албадлагын аргаар өөрөө үнэн зөв тодорхойлон төлөх, суутган авч төсөвт төлөх, цуглуулан төлөх, хяналт шалгалтаар ногдуулж төлөх гэсэн хэлбэрүүдээр хэрэгжиж байна. Өнөөдөр мөрдөгдөж буй татварын 20 гаруй хууль, тэдгээртэй холбоотой тогтоол, дүрэм, аргачлалын талаар татвар төлөгч ойлголт сайнгүй, татвараа тодорхойлж төлөх арга зүй эзэмшээгүй байдаг нь татвар хураалтад бэрхшээл учруулдаг ажээ.

Татвар ногдуулалт нь шууд болон шууд бус арга замаар хэрэгждэг. Шууд татварууд нь татвар төлөгч нь өөрөө тодорхойлон төлөхийн зэрэгцээ бусдад орлого шилжүүлэх үедээ суутган аван төсөвт төлнө. Шууд бус татваруудыг ажил үйлчилгээ эрхэлж буй татвар төлөгч цуглуулан төсөвт төлнө. Татварын хуулийн хэрэгжилтийг шалгасан үр дүнгээр татвар төлөгч нь хүү, торгууль, нэмэлт төлбөр байдлаар төлөх болдог. Энэ нь татварын албаны шалгалтаар акт тогтоон авдаг тул албадлагын зохион байгуулалтын хэлбэр юм.

Татварын эрх зүйн зохион байгуулалт нь татварын алба, татвар хураалт, татвар ногдуулалт, татвар хураах механизмын чиглэлээр бүрдсэн. Татвар төлөгчдийн эрх үүрэг, хариуцлага, татварыг хураах зэрэг нь тус тусын хэм хэмжээний дагуу зохион байгуулагдсан бөгөөд хуулиар ногдох татвараа төсөвт төлөх, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх харилцаанд үндэслэнэ.

Татвар хураалтад улс, орон нутгийн татварын хуваарилалт, төсвийн орлого бүрдүүлэх зохион байгуулалт, татварын албадын зохион байгуулалтыг боловсронгуй болгох замаар олон зүйлийг шийдэж болох бөгөөд үүнийг дангаар судалж шийдвэрлэх шаардлагатай юм. Монгол Улсын хөгжлийн нэг бодлого нь орон нутгийн бие даасан байдлыг хангах гэж тунхагласан нь татварын төрөл зүйлээр эсвэл орон нутгийн аль нэг зохион байгуулалтаар улс, орон нутгийн төсвийг бүрдүүлэх, татварын алба хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зохион байгуулалтад шилжих зэргээр олон хувилбаруудыг гаргаж Монгол Улсад нийцэх зохион байгуулалтыг сонгох замаар санхүүгийн тогтолцоогоо шинэчлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа нь судалгааны ажлын явцад ажиглагдлаа.

3.5. ТАТВАРЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ТАТВАР ХУРААЛТЫН УЯЛДАА

Татварын албадууд татвар төлөгчдийн тухайн жилийн төсөвт төлсөн орлогын албан татварын гүйцэтгэлд тулгуурлан татварын орлогын төсөв бэлтгэн харьяа газрынхаа санхүүгийн албанд явуулах бөгөөд санхүүгийн алба цааш нь төсөв бэлтгэн хэлэлцүүлж батлуулсанаар уг төсвийг татварын албадуудад хуваарилж гүйцэтгэвэл зохих ажлын төлөвлөгөө болгон хэрэгжүүлэх буюу түүний биелэлтээр татварын алба болон татварын байцаагчийн ажлыг үнэлэх нэг үзүүлэлт болгон хэрэглэдэг. Энэ тогтолцоо нь татвар төлөгчдийн үйл ажиллагааны өөрчлөлтийг тусгадаггүй тул төлөвлөлт үндэслэл муутай байх талтай төдийгүй татварын албанаас төлөвлөгөө биелүүлэхийн тулд татвар төлөгчөөр татвар төлүүлэх нэг хэрэгсэл болгон ашигладаг нь татвар хураалтад сөргөөр нөлөөлдөг ажээ.

Төлөвлөлт нь зорилгоо тодорхойлох, түүндээ хүрэхийн тулд юу хийх, нөөцөө хэрхэн оновчтой ашиглах, яаж хамгийн хэмнэлттэйгээр, ямар арга замаар хүрэх вэ? гэдгийг урьдчилан тодорхойлоход чиглэх удирдлагын арга хэрэгсэл юм.

Улсын төсвийн татварын нийт орлогод ААНБОАТ-ын гүйцэтгэх үүрэг

Хүснэгт 13

	2001	2002	2003	2004	2005
1 Улсын төсвийн орлого	100	100	100	100	100
Татварын орлогын эзлэх хувь	74,7	75,3	76	81,8	82,8
2 Татварын орлого	100	100	100	100	100
Орлогын албан татвар	19,6	20,2	23,2	24,7	25,7
ААНБОАТ	13,3	12,9	16,3	16,9	17,2
Хүн амын орлогын АТ	6,3	7,3	6,9	7,8	8,5
Нийгмийн даатгалын шимтгэл	16,4	15,2	15,5	14,1	13,5
Хөрөнгийн АТ	0,6	0,9	1,0	1,0	0,9
Хэрэглээний АТ	58,9	56,6	52,9	49,6	47,5
Төлбөр, хураамж	4,5	7,1	7,3	10,6	12,4

Эх сургалж: МҮСГ-ын эмтгэл 2005 он

Монгол Улсын төсвийн орлогод татварын орлогын эзлэх хувь сүүлийн жилүүдэд нэмэгдэхийн зэрэгцээ татварын орлогод эзлэх ААНБОАТ-ын хувь хэмжээ нэмэгдэж байна.

ААНБОАТ–ын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 14

	2000	2001	2002	2003	2004	2005
1 Татварын орлог–ын нийт дүн	158495,7	188281,5	143524,1	160892,6	296979,7	355538,6
ААНБОАТ–ын дүн	49091,2	46017,8	46521,5	51860,7	102326,5	111117,0
Эзлэх хувь	31,0	24,4	32,4	32,2	34,4	31,2
2 ААНБОАТ–ын төлөвлөгөө	48284,9	51330,8	45383,6	44000,0	52252,6	87213,7
ААНБОАТ–ын гүйцэтгэл	49091,2	46017,8	46521,5	51860,7	102326,5	111117,0
Төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь	101,7	89,6	102,5	117,8	195,8	127,4

Эх сурвалж: МҮСГ–ын эмхтгэл 2005 он

ААНБОАТ –ын төлөвлөгөөний биелэлт 2001 онд 89%, 2004 онд 196%, бусад онуудад 100–аас дээш хувиар биелж байсан нь төлөвлөгөө хир үндэслэлтэй вэ гэдэгт эргэлзээ төрүүлж байна.

Татварын алба, байцаагч ажлынхаа үр дүнгийн гол үзүүлэлтийг төлөвлөгөө болгодог нь зөвхөн төсвийн орлогын төлөвлөгөө биелүүлэх зорилгоор ажиллаж байгаа мэт ойлголтыг татвар төлөгчид төрүүлэхээр татвар хураалтын харилцаа явагддаг. Энэ нь эргээд татвар төлөгчдийн төрөө дээдлэх сэтгэлгээнд сөрөг нөлөөлдөг практик байгааг фокус ярилцлагад оролцсон нэгэн татвар төлөгчийн ярианаас харья.

Татварын байцаагчтай байнга маргалддаг нэг зүйл байдаг. Энэ сард манай орлогын төлөвлөгөө биелэхгүй нь, Та ямар ч гэсэн төдийг төл гэнэ. Би НӨАТ–д төлөх ёстой байдаг. Гэтэл НӨАТ–т битгий төл, орлогын албан татварт төл, эсвэл орлогын татварт битгий төл, онцгой татварт төл гэдэг. Яаж байгаа юм бэ гэж асуухаар манай төлөвлөгөө тасраад байна гэдэг.

Төлөвлөгөө биелүүлнэ гэдэг ойлголт эргээд татварын харилцаанд олон сөрөг үр дагавар гардаг нь судалгааны ажлын явцад харагдлаа. Үүнд.

- Татвар төлөгчдөд татварын төлөвлөгөө тасарлаа гэдгээр заавал төлөх албан даалгавар болгодог;
- Татвар төлөгч хуулиар ногдох татвараа тооцох төлөх гэсэн үүргийг нь гажуудуулдаг;
- Татварын төрөл, зүйлийн хоорондын харьцааг алдагдуулах;

- Ямар ч аргаар хамаагүй төлөвлөгөө биелүүлэх хандлагаар үндсэн ажил үүргээ умартах зэрэг.

Иймд татварын албаны болон татвар төлөгчийн ажлыг үнэлэхдээ татварын төлөвлөгөөг бус, харин хэдэн татвар төлөгчөөс тайлангаа хугацаанд нь авч ногдуулсан татварынхаа хэдэн хувийг хурааж чадаж байна гэдгийг гол үзүүлэлт болгох замаар төрийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх шаардлагатай байна.

3.6. ТАТВАР ХУРААЛТАД ХЯНАЛТЫН ҮҮРЭГ

Татварын хяналтын механизм нь улс орны хэмжээнд өмчийн өөрчлөлт, хөрөнгийн хөдөлгөөн, ашиглалт, санхүүгийн нөөцийн хуваарилалт, ажил үйлчилгээний хүрээ, хүн амын бүтэц, татвар төлөгчдийн үйл ажиллагаа эрхлэлт зэрэг өргөн хүрээнд бусад механизмтай нягт хамааралтайгаар үүргээ гүйцэтгэдэг.

Улс орны аюулгүй байдалд гаалийн бодлогоор татварын хяналтын үүрэг хэрэгжих бөгөөд гаалийн татвар төлөх мэдүүлэг нь оруулсан болон гаргасан барааны тоо хэмжээ, чанарыг тодорхойлох тул хяналт тавих үндэс нь болно. Нийгэм, эдийн засаг болон байгаль экологийн тэнцвэрт байдалд ч татварын хяналтын механизм чухал үүрэгтэй.

Орлогын төрлийн албан татвар нь нийгмийн хүрээнд орлого шилжилт, хуваарилалтад хяналт тавих агуулгатай бөгөөд учир нь олсон орлогоо тодорхойлох нь уг татвар төлөгчийг ямар хүрээний ажил үйлчилгээ эрхэлж буйг илтгэнэ.

Хөрөнгийн албан татвар нь улс орны хэмжээнд байгаа хөрөнгийг бүртгэх, түүнд хяналт тавих үүрэгтэй тул хөрөнгийн хөдөлгөөн, байрлал, ашиглалтын байдалд хяналт тавих боломжийг татварын механизмыг ашиглан бий болгож байна.

Хэрэглээний албан татварууд нь төсвийн орлогыг бүрдүүлэх зорилготой ч хэрэглээнд хяналт тавих, үйл ажиллагаандаа баримт бүрдүүлдэг нь хяналт тавих боломжийг бүрдүүлдгээрээ давуу талтай болно.

Хэрэглэгчийн төлбөр, хураамжуудад бүхэлдээ төрийн хяналтын үйл ажиллагаа шингэсэн болно. Тэмдэгтийн хураамж нь хүн амын хөдөлгөөн, шүүхээр асуудлаа шийдүүлэх, бичиг баримтаа бүрдүүлэх, түүний үнэн болохыг гэрчлүүлэх, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авах зэрэг төрийн үйлчилгээг авах явцад бүртгэх боломжийг бий болгох бөгөөд статистик мэдээ, мэдээллийг бүрдүүлэхэд ач холбогдолтой. Төр өөрийн өмчидөө хяналт тавихдаа төлбөр ногдуулах бөгөөд ашигт малтмал, ан амьтан, ой мод, ус рашаан ашигласан тухай мэдээллийн баазыг бүрдүүлж хянах зорилготой.

Татварын хяналтын механизм нь улс орны хэмжээнд дээрх үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ татварын хуулийн хэрэгжилтийг хянахад гол үүрэгтэй

билээ. Татварын харилцаанд оролцогч талууд хуулиа хэрхэн хэрэгжүүлж буйг аль аль талаас нь хянахад хяналтын механизм үйлчилнэ. Татвар төлөгч татвар төлөх үүргээ хэрэгжүүлж буйг төрийн зүгээс хянадаг механизм татварын албадын үйл ажиллагаагаар хэрэгждэг бол татвар төлөгчийн төлсөн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж буйг татвар төлөгчид буюу олон нийтийн байгууллагын үйл ажиллагаагаар хянадаг механизм нийгэмд төлөвшиж үр дүнгээ өгдөг.

Татварын хяналтын механизмын үүргийг ард иргэд, олон нийтийн оролцоотойгоор хэрэгжүүлэлтийг төлөвшүүлэх нь нийгэм эрүүлжих үндэс болох төдийгүй шударга ёсыг тогтоох хөшүүрэг бөгөөд татвар хураалтад эерэг нөлөөтэй.

Хууль зүйт төрт ёсны ардчилсан нийгэмд татвар төлөх нь шударга ёсны асуудал, нэр төрийн хэрэг тул төрийн удирдлагаас эхлэн орлогоо үнэн зөв тодорхойлон татвараа төлсөн нь улс төр, нийгэмд эзлэх байр суурийг нь илэрхийлэх гол шалгуур юм. Иймээс татвар төлөгчийн үүргээ хэрэгжүүлсэн нь улс төр, төрийн удирдлагад дэвших хүмүүсийг таньж мэдэх нэг шалгуур үзүүлэлт тул сонгогч олондоо өөрийгөө энэ үзүүлэлт талаасаа танилцуулах, мөрийн хөтөлбөртөө татвар төлөгчдийн мөнгийг тэгж зарцуулна, ийм юм хийнэ гэж тусгадаг ажээ.

Хяналт шалгалтыг ямар үндэслэлээр хийдэг, татвар төлөгчдөд ямар нөлөөлөл үзүүлдэг талаар татвар төлөгчдөөс авсан санал асуулгын хариултаас харъя.

- Татварын албанаас хийдэг татварын хяналт шалгалт танай байгууллагад хамгийн сүүлд ямар үндэслэлээр хийгдсэн вэ?
 - а. Төлөвлөгөөний дагуу 78%, б. Автомат сонголтоор 3%,
 - в. Мэдээллийн дагуу 4% д. Мэдэхгүй 12%
- Мэдээллийн үндсэнд танай байгууллагад татварын хяналт шалгалт сүүлийн 3 жилд хийгдэж байсан уу?
 - а. Тийм гэж нийт санал асуулгад оролцсон байгууллагын 23% нь хариулсан бөгөөд 17% нь 1 удаа, бусад нь 2–5 удаа хамрагдсан байна.
- Энэ шалгалтын эцэст ямар үр дүн гарсан вэ?
 - а. Ямарч зөрчил илрээгүй 20%
 - б. Мэдээлийн хүрээнд зөрчил гараагүй гэхдээ байцаагч акт тавьсан 11%
 - в. Бага хэмжээний зөрчилд акт тавигдсан 59%
 - г. Ихээхэн хэмжээний акт тавигдсан 6%
 - д. Тавигдсан актыг хүлээн зөвшөөрөөгүй учир маргаан таслах шатанд байгаа 2%
 - е. Тавигдсан актыг хүлээн зөвшөөрөөгүй учир шүүхийн шатанд байгаа 1%
 - ё. Бизнесийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан 2%

- Танай байгууллага байгуулагдаж үйл ажиллагаа явуулж эхэлсэнээс хойш татварын хяналт шалгалтаар ямар нэг зөрчил илрээгүй тохиолдол бий юу?
 - а. Тийм 32%
 - б. Үгүй 68%
- Татварын албанаас хийгддэг хяналт шалгалтын үр дүнг Та хэрхэн үнэлэх вэ?
 - а. Хууль тогтоомжийн дагуу бизнесээ эрхэлж учирч болох эрсдлээс хамгаалахад маш их тустай байдаг 46%
 - б. Шалгалтын зорилго, хэрэгжүүлж буй арга зүй, татварын байцаагчийн чадвараас хамаараад янз бүр байдаг 34%
 - в. Татвар төлөгчийн бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэг 5%
 - г. Үр өгөөж нь тэр бүр мэдэгддэггүй 15%

Хяналт шалгалтыг голлон төлөвлөгөөний дагуу явуулдаг, гэхдээ мэдээллийн дагуу шалгалтад санал асуулгад оролцсон нийт татвар төлөгчийн 23% нь хамрагдсан, бага хэмжээний акт тавигдсан гэж 59% нь хариулсан, хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүнг янз бүрээр үнэлсэн байна. Шалгалтын үр дүн нь зорилго, хэрэгжүүлж буй арга зүй, байцаагчийн үр чадвараас хамаарна гэж 34%, үр өгөөж нь мэдэгддэггүй гэж 15% нь хариулсан болон судалгааны явцад хийгдсэн ярилцлагаас харахад татвар төлөгчдөд татвараа хэрхэн төлөхөд нь туслалцаа үзүүлэх, хуулиа хэрэгжүүлэх дадал суулгахад туслахад татварын байцаагчийн үр чадвараас ихээхэн хамаарахын зэрэгцээ бусад субъектив нөлөөлөл ихтэй болох нь тодорхой байна.

Татварын хяналт шалгалт хийсэн л бол заавал ямар нэг хэмжээний зөрчил илрүүлсэн болж акт тавих үзэл татварын байцаагчдын дунд түгээмэл байх, татвар төлөгч нь багахан хэмжээний төлбөр тавиулсан болж салах хүсэлтэй байдаг ажээ. Мөн хяналт шалгалтын байцаагч тэдийг нэхээд төдийг өгөөд гэдэг яриа түгээмэл байх төдийгүй бодит ажил ч явагддаг гэдгийг баталж ярьж байв. Энэ нь татварын хяналт шалгалтыг явуулах үндсэн нөхцлийг бүрдүүлэх мэдээлэл бүртгэлийн хүчтэй автоматжуулсан тогтолцоогүй тохиолдолд бодитоор оршин байхаас өөр аргагүй, мөн татвар төлөгчид өөрсдөө татвараа нуун дарагдуулсан буруутай үйл их байдгаас эдийн засгийн ашиг сонирхлоор нь шийдвэрлэхэд хүргэдэг нь ойлгомжтой юм.

Төрийн зүгээс татвар төлөгчийн үүргийн хэрэгжилт, татварын хяналтын механизмыг оновчтой ашиглах нь бодлогоо хэрэгжүүлэх гол түлхүүр болох юм гэдгийг удирдлага болгон татвар хураалтын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, уг тогтолцоог төлөвшүүлэхэд анхаарлаа хандуулах нь нийгэм эдийн засгийг эрүүлжүүлэхэд тустай билээ.

3.7. ТАТВАР ХУРААЛТАД МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН НӨЛӨӨ

Татварын мэдээллийн систем нь янз бүрийн мэдээллийг агуулах бөгөөд татварын удирдлагын шийдвэр зөв зохистой явагдах нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй.

Татварын мэдээлэлд:

- Татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэл
- Татварын орлогын мэдээлэл
- Татварын тайлан хүлээн авалтын мэдээлэл
- Татварын хяналт шалгалтын мэдээлэл
- Татварын өрийн мэдээлэл гэх мэт олон зүйлийн мэдээллүүд хамрагдана.

Хэрэглэгчдийг шийдвэр гаргахад нь шаардлагатай үнэн зөв мэдээллээр хангах нь аливаа шийдвэр зөв байх үндсэн нөхцөл нь байдаг. Шаардлагатай үнэн зөв мэдээллээр хангагдаагүйгээс шийдвэр учир дутагдалтай болох нь хуулийн хэрэгжилтэнд хүндрэл учрахаас гадна татвар хураалтад сөргөөр нөлөөлнө. Татвар хураах үйл ажиллагаанд учирдаг хүндрэлүүд нь:

1) Бизнесийн хүрээнд хамрагдаж байгаа ч татвар төлөгчөөр бүртгүүлээгүй эсвэл хууль бусаар үйл ажиллагаа эрхэлж байгаа, татвар төлөх үүргээ мэдэхгүй байх.

2) Татвар ногдох орлогоо үнэнээр тодорхойлохгүй байх. Татварын тайлангаа цаг хугацаанд нь өгөхгүй, өгсөн ч буруу мэдээлэл өгөх, татвар ногдох орлогыг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн давхар бичилтийн аргаар бүртгэж тайлагнахгүй байх.

3) Татвар төлөгч нь үнэн хэрэгтээ төлөх ёстой татвараа төлдөггүй, төлсөн ч хугацаандаа төлөхгүй байх зэрэг болно. Энэ бүхэн нь татвар хураалтын ажилд хүндрэл учруулж, хяналт шалгалтын ажлын хүрээг өргөжүүлэх, татвар хураалтын зардлыг ямагт нэмэгдүүлж байдаг.

Мэдээлэл, бүртгэл, хяналтын автоматжуулсан хүчтэй тогтолцоо төлөвшүүлээгүй тохиолдолд хуулийн хэрэгжилт зөрчигдөх, татвар төлөхөөс зайлсхийх нөхцөл ямагт нээлттэй байх тул татвар хураалтад төдийлөн эерэг үр дагавар гарахгүй. Иймээс татварын албаны удирдлага мэдээллийн системийн дээрх хүндрэлүүдийг арилгахад үйл ажиллагаагаа чиглүүлэх нь татвар хураалтын механизмаа сайжруулах шийдвэр гаргахад хүрнэ. Татварын тогтолцооны тэгш шударга байх нөхцлийг хангах нь татварын автоматжуулсан мэдээллийн тогтолцоонд тулгуурлан хариуцлагыг өндөржүүлэх явдал юм.

Татварын хуулийн хэрэгжилтийг сайжруулах, татвар хураалтыг боловсронгуй болгох арга зам нь мэдээ мэдээллийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, үнэн зөв байх нөхцлийг бүрдүүлэх, хөдөлшгүй үнэн зөв мэдээлэлд үндэслэдэг арга хэлбэрүүдийг

хэрэглэх, хөндлөнгийн мэдээллээр хянах хяналтын үүргийг өндөржүүлэх зэрэг олон ажлууд хийхийг шаардана. Татвар төлөгч бизнесийн болон нийгмийн хамгааллын аливаа харилцаанд орохдоо улс орны хэмжээнд тухайн татвар төлөгчийн дугаараар харьцдаг болох нь үүний эхлэл болох үндэстэй юм. Бизнесийн аливаа үйл ажиллагааны үнэлэмжтэй татвар төлөгчийн үүргийн хэрэгжилтийг холбох нь нягтлан бодох бүртгэлд үндэслэсэн мэдээ мэдээллийн үүргийг нэмэгдүүлэх, түүнийг хэрэглэх хэрэглээг төлөвшүүлэхэд татвар хураалтын механизмын үүрэг их билээ.

Мэдээ мэдээлэл шуурхай, үнэн зөв байх нь татварын системийн үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлэхээс гадна татварын ногдлыг хянан шалгах, татвар хураалтад гардаг хүндрэлийг багасгах боломж бий болно.

Монгол улсын татварын системийн өнөөгийн байдалд хүчтэй нарийн зохион байгуулагдсан мэдээллийн систем бүрдэж чадаагүйгээс татварын хууль тогтоомж зөрчигчдийг илрүүлэх, хариуцлага тооцох үйл ажиллагаа сул байгаа нь татвараас зайлсхийгчдэд таатай боломж бий болгосоор байгаа билээ.

Өнөөгийн татварын мэдээллийн системийн үндсэн үйл ажиллагаа нь дотоод мэдээллийг нэгтгэх замаар тоон үзүүлэлт талаас нь хийгдэж байгаа нь мэдээллийн тоонууд хоорондоо зөрүүтэй байх тал их байгаа бөгөөд зөвхөн нэгтгэл хийгдэх төдий шинжтэй байна. Татвар хураалтын эхний шатны үйл ажиллагаа болох татвар төлөгчийн тоон мэдээлэл ямар зөрүүтэй байгааг дээр өгүүлсэн. Татвар төлөгчдийн татвар ногдох (борлуулалтын орлого) орлогын талаарх мэдээллийг ҮТЕГ-ын 2005 статистик мэдээлэлд үндэслэн авч үзье.

1. ААНБ-ын борлуулалтын орлогын мэдээ	4154169,9 сая төгрөг
2. ААНБ-ын тайлангийн нэгтгэл	4150359,0 сая төгрөг
3. ААНБОАТ-ын тайлангийн хувь хэмжээний товчоо	627820,7 сая төгрөг

ҮТЕГ-ын Мэдээлэл боловсруулалт автоматжуулалтын хэлтсийн үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн тоо мэдээллүүд ийнхүү хоорондоо авцалдахгүй, зөвхөн нэгтгэл шинжтэй байгаа нь мэдээллээр хянах тогтолцоо үгүй, мэдээллийн тоо баримтыг дансны давхар бичилтын системээр хянадаггүй болохыг илэрхийлж байна.

Татварын албаны мэдээллийн баазаас гарч буй тоо бол албан ёсны мэдээлэл байх учир хэн ч аваад шийдвэр гаргах түвшинд хэрэглэхэд үнэн зөв байх төдийгүй татвараа хураах бааз суурийг өргөтгөх, татварын хуулийг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, хариуцлага тооцоход нотолгоо болох мэдээлэл байх ёстой билээ.

Татвар төлөгч хуулийн өмнө яагаад гэдгээ мэдэж байгаа тохиолдолд хариуцлага хүлээхээ мэдэрдэг шиг татварын байгууллага яагаад гэдэгт хариулт болохуйц нотолгоог бүрдүүлж чадсан мэдээллийн тогтолцоотой болсон үед татвар төлөгчийн хууль бус үйлдлийг илрүүлж, хариуцлага тооцох нөхцлөө бүрдүүлж чадах

тул энэ үндсэнд татвараа хураан авах болно. Иймд татварын албаны мэдээллийн тогтолцоо татвар төлөгчдөд хуулиа цаг тухайн үед нь хэрэгжүүлэх боломжоор хангасан байх төдийгүй хуулиа хэрэгжүүлэхгүй байх, хугацаа хожимдуулахад хариуцлага шууд хүлээдэг механизм үйлчлэх, мэдээллийн технологигоор дамжуулан хянах боломжийг бүрдүүлэх нь татвар хураалтын механизмын гол хөдөлгөгч хүч юм.

Татварын алба дотоод мэдээллийн үнэн зөвийг хангах, үнэ цэнийг нэмэгдүүлэх замаар шийдвэр гаргалтаа үндэслэлтэй болгох төдийгүй гадаад мэдээллийн хөнгөн шуурхай, ил тод байдлыг хангах замаар татвар хураалтыг автоматжуулах цаг нь болжээ. Татварын бүх тайланг компьютерээр боловсруулах програмтай болох, тайланг онлайнаар авч мэдээлэл шууд тэндээсээ дамжин боловсрогдог байх нь нийгмийн хэрэгцээ болжээ.

3.8. ТАТВАР БҮРТГЭЛИЙН ҮҮРЭГ

Хаана нягтлан бодох бүртгэл, тооцоо сул байна тэнд салан задгай, үрэлгэн, эмх замбараагүй байдал ноёлж удирдлагын шийдвэр үр дүнгүй болох үр дагавартай гэдгийг хэн бүхэн мэднэ. Тоо мэдээллийн үнэн зөвийг хангаж чадах бүртгэл тооцооны тогтолцоонд төр татвараа цуглуулж авах нөхцлөө бүрдүүлэх бөгөөд үнэн зөв мэдээллийн баазтай байж татвар хураалтыг сайжруулна гэдэг нь ойлгомжтой.

Бүртгэл нь үйл ажиллагаагаа үр ашиг, үр дүнтэй хөтлөн удирдах нэг механизм бөгөөд татварын тогтолцооны үйл ажиллагаа сайжрах нэг үндэс юм. Ер нь мэдээлэл, бүртгэл, хяналтын нягт уялдаа бүхий механизмгүйгээр аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, дутагдлыг арилгах, зардлыг хамгийн бага хэмжээнд байлгах шийдвэрийг хэрэгжүүлж чадахгүй билээ.

Татварын бүртгэл татварын албанд ч, татвар төлөгчийн хувьд ч төлөвшлөө олж хөгжиж чадахгүй байна. Татварын албаны санхүүгийн тайлан зөвхөн төсвийн хөрөнгийн зарцуулалтыг тайлагнах төдий байгаа, орлогын албан татварыг бүртгэх тайлагнах ажил төдийлөн цэгцрээгүй, мэдээ тайлангийн тоонууд зөрүүтэй байгаа зэрэг нь аль ч түвшинд бүртгэлийн асуудал шийдлээ олоогүй байгааг илэрхийлэх ч нийгмийн хэрэгцээ байна гэдэг нь татвар төлөгчдөөс авсан санал асуулгын хариултаас тодорхой байна.

Татварын алба, татвар төлөгчийн үйл ажиллагааг хөнгөвчлөхөд ямар тогтолцоог бүрдүүлэх нь ач холбогдолтой вэ? гэсэн асуултад татварын бүртгэлийн тогтолцоог хөгжүүлэх гэж 45% нь, татвар төлөгчийн талаар мэдээллийн баазтай болох гэж 44% нь татвар төлөгчдөд үзүүлэх урамшуулын систем бий болгох гэж 10% нь хариулжээ.

Татварын бүртгэлийг татвартай холбоотой аливаа үйл ажиллагааг бүртгэх тайлагнах арга зүй гэж үзвэл татвар төлөгчийн хүрээнд ч, татварын албаны хүрээнд ч хууль хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагаа хамрагдана. Өөрөөр хэлбэл татварын аливаа үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх замаар мэдээ мэдээллийн үнэн зөвийг хангах, гарах шийдвэр үндэслэлтэй болох, ажиллагсдын хөдөлмөрийн хөлсийг гүйцэтгэсэн ажлын үр дүн, бүтээлтэй нь холбон үнэлэх тогтолцоог хэрэгжүүлэх боломж бий болгох билээ.

Татварын албаны хэмжээнд бүтээж буй бүтээгдэхүүн нь юу болох түүнийг батлагдсан нэгдсэн нэг загвараар нэгж бүрээр гаргаж санхүүгийн тайлан мэт албан ёсны баталгаа бүхий баримт болгон хэрэгжүүлэх нь “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах зарчимтай нийцнэ.

Татварын алба татвар төлөгчийн төлж буй албан татвар, төлбөр, хураамжуудыг зүйл бүрээр, татвар төлөгч бүрээр бүртгэж мэдээлэх нь татвар төлөгчийн татвараа төлөх үүргээ хэрэгжүүлж буйг илэрхийлэх мэдээлэл юм. Энэ мэдээлэл үнэн зөв, ямар нэг алдаа мадаггүй гэдгийг яаж батлах вэ?, Татварын өрийн мэдээлэл засагдахгүй байх магадлал бий юу?, Татвар төлөгч татвар ногдох зүйлсээ үнэн зөв тодорхойлж буйг хэрхэн хянах вэ? гэх мэтээр олон асуудал татварын мэдээллийг автоматжуулахыг шаардаж байна.

Татвар албаны байцаагчдын ёс зүйн асуудлуудыг мөрдүүлэх, авилгалаас урьдчилан сэргийлэхэд дотоод мэдээллийн үнэн зөв байдлыг хангах сайн бүртгэл, хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь татвараа шударгаар хураах механизмын нэг нөхцөл билээ. Мэдээлэл, бүртгэл, хяналтын нягт уялдаа бүхий механизмыг хэрэгжүүлэх нь аливаа харилцаанд эерэг үр дагавар авчрах бөгөөд татвар төлөгч татвараа төлөхөөс өөр аргагүй, татварын албаны ажилтан хуулийн хэрэгжилтийг хуулийн дагуу хангахаас өөр гарцгүй байх механизмыг хэрэгжүүлнэ гэсэн үг.

Өнөөгийн татварын бүртгэлийн тогтолцоо нь мэдээ мэдээлэл зохих хэмжээнд байгаа ч бүртгэл, хяналттай уялдаагүй байгаа нь тоо мэдээний үнэн зөв байдлын баталгаа үгүй, бүртгэлээр тавигдах хяналтын тогтолцоогүй явагдаж байна. Мэдээ мэдээллийн үнэн зөвийг хангах гол арга нь нягтлан бодох бүртгэлийн давхар бичилтийн аргыг ашиглаж нэгийг нь нөгөөгөөр нь баталгаажуулах бүртгэлийн тогтолцоог хэрэгжүүлэх юм. Тухайлбал: Төсвийн орлогын харилцах дансыг төвлөрсөн болон орон нутгийн харилцах дансдуудаар татварын зүйл бүрээр, татвар төлөгч бүрээр мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн дансны давхар бичилтээр нарийвчлан боловсруулах замаар татвар төлөгчийн төсөвт төлсөн гэж тайлагнаж буй дүнг баталгаажуулах мэдээллийн тогтолцоог хэрэгжүүлэх явдал юм. Иймээс тайлан хүлээн авсан байцаагчийн тайлангийн нэгтгэлийн төлөгдсөн татварын дүн нь төсвийн орлогын харилцах дансны орлогын дүн болно. Олон татвар төлөгчийн мэдээлэл олон зүйлийн татварын төлбөр төлөгддөг учир энд боловсрогддог мэдээлэл нягтлан бодох

бүртгэлийн зарчим, тогтолцоогоор хэрэгжиж алба бүрийн хувьд санхүүгийн тайланд үндсэн бүтээгдэхүүн болон тайлагнаж баталгаажих байх учиртай.

Иймээс татварын алба “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хууль”-ийн дагуу өөрийн бүтээгдэхүүнээ нэгж бүрээр гаргаж, түүнийг үнэлэх шалгуур үзүүлэлтээ тогтоож, хийсэн үйл ажиллагаагаа төсвийн санхүүжилттэй уялдуулан бүртгэж тайлагнах замаар дотоод хяналтаа сайжруулах нь татвар хураалтын үйл ажиллагааны орчинг бүрдүүлэх юм.

Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн бараг бүгдэд нь ямар нэг хэмжээгээр зөрчил гардаг нь татвар төлөгчид татварын тайлангаа үнэн зөв хийх бүртгэлийн тогтолцоо бүрдээгүй байгааг нотолно.

Татварын хяналт шалгалтад хамрагдсан татвар төлөгчдийн 80 орчим хувьд нь ямар нэг байдлаар зөрчил илэрч байгаа нь татвартай холбоотой ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгах, бүртгэх тайлагнах асуудлыг санхүүгийн тайлантай хэрхэн уялдуулах, зааг ялгааг нь гаргах, татварын үүднээс бүртгэл тайланг хэрхэн гаргахыг нэг мөр шийдвэрлэж, тодорхой болгоогүйтэй холбоотой юм.

Татвар төлөгчийн үйл ажиллагаанд төсөвт төлж буй татвараа хэрхэн нягтлан бодох бүртгэлдээ тусгах нь тодорхой цэгцрээгүй байгаа, энэ талаар төрөөс тодорхой бодлого хэрэгжихгүй байгаа нь шинэчилсэн хуулийг хэрэгжүүлэх аргачлалд татвар ногдуулалт, төлөлтийг хэрхэн бүртгэж тайлагнах талаар тодорхой зүйл тусаагүй байгаагаас харагдаж байна. Энэ нь татварын алба татварын тайлангуудаа нөгөө л мэдээлэл шинжээр гаргасан нь бүртгэлийн талаар төдийлөн ойлголтоггүй, ач холбогдол өгөхгүй байгаагийн илэрхийлэл юм.

Татварын бүртгэлийн тогтолцооны хөгжилд төдийлөн ахиц гарахгүй байгаа нь татварын албанд татвартай холбоотой үйл ажиллагааны мэдээ, тайланг үнэн зөв мэдээлэлд тулгуурлан гаргах, энэ нь ийм мэдээлэлтэй ингэж уялдаж нотлогдох тул үйл ажиллагаагаа нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандартын дагуу бүртгэж тайлагнах гэсэн ойлголт, бүртгэлээр тавих хяналтын арга зүйг төлөвшүүлэхэд татварын албаны зүгээс дорвитой арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна. Татварын тайлан нь татвараа үнэн зөв өөрөө тодорхойлон төлж буйг илтгэх баримт учир түүнд туссан тоо баримт нь нягтлан бодох бүртгэлийн арга зүйгээр хийгдэж, нэг нь нөгөөгөөрөө баталгаажсан байх учиртай.

3.9. ТАТВАРААС ЗАЙЛСХИЙХ ХАНДЛАГА, ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ

Татвар төлөгчид хуулийг дагаж мөрдөх, хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлэх нь өөрийн бүтээсэн баялгийнхаа тодорхой хэсгийг төрийн санхүү рүү шилжүүлэх болдог. Иймд төдийлөн дуртай байдаггүй тул хуулийн сиймхийгээр

зайлсхийх, болвол төлөхгүй байхыг хичээдэг хэсэгт хуулийн дагуу хариуцлага ногдуулахад хүрдэг. Мөн санаатайгаар зугтах арга замыг ч сонгодог болох нь тодорхой. Татвар төлөхөөс зайлсхийх гэдэг нь хуулийн хүрээнд татварын ачааллаа ямар нэг хэмжээгээр багасгах болон татвар төлөх үүргээ санаатайгаар хэрэгжүүлээгүй үйлдлүүдийг хэлнэ. Татвар ногдох их хэмжээний орлого, эд хөрөнгө, ажил, үйлчилгээ, бусад зүйлийг нуух, тэдгээрийн тоо хэмжээг зориуд бууруулан мэдээлэх, байнга оршин суугаа газар, хаягаа өөрчлөх зэргээр албан татвар төлөхөөс санаатай зайлсхийх үйлдлүүд орно.

Татвараас зайлсхийхдээ бүртгэлгүйгээр бизнесийн үйл ажиллагаа эрхлэх, орлогоо бууруулах, зардлаа нэмэгдүүлэх, хуулийн тодорхой бус зүйл заалтыг ашиглах зэргээр төлөх татвараа бууруулахад чиглэх бөгөөд энэ нь албан бус эдийн засгийн хүрээг өргөжүүлэх сөрөг талтай. Иймээс өөрийн үйл ажиллагааны үр дүнгээ худал мэдээлэх, татварт зориулан тайлан гаргахад хүргэх тул татвар төлөгчийн үйл ажиллагааг бүртгэл, мэдээллийн тогтолцоогоор хянах, хариуцлага хүлээлгэдэг хүчтэй механизм үйлчлэх учиртай.

Татвар төлөхөөс зайлсхийх алхам нь бизнесийн үйл ажиллагаагаа бүртгэлгүйгээр эрхлэх, бүртгэсэн ч худал мэдээлэх явдал Монгол Улсын татвар хураалтад сөргөөр нөлөөлж татварын тогтолцоог шударга бус болгож буйг нийгмээрээ хүлээн зөвшөөрсөн нь татварын хуулиудын шинэчлэлийн хэлэлцүүлгийн явцад илэрсэн. Иймээс албан бус эдийн засгийг татварт хамруулах, татварын тайлан мэдээг үнэн зөв гаргах механизм үгүйлэгдэж байгааг хүлээн зөвшөөрсөн гэж үзэж болно. Татварын шинэчлэгдсэн хуулиар татварын ачааллыг бууруулсан нь татвар төлөгч татвараа үнэн зөв тайлагнах нэг таатай орчин бүрдсэн гэж үзэх үндэстэй ч түүнийг нь хянах, хариуцлага тооцох тогтолцоог хамтад нь шийдвэрлэн хэрэгжүүлэхгүй л бол төдийлөн үр дүн харагдахгүй.

Татварын алба хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж буй байдлыг дараах хүснэгтээс харья.

Татварын хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо

Хүснэгт 15

	ХШ-д хамруулах үндэслэл	2004	2005	2006
1	Сонголтоор	74	110	133
2	Татвараа төлөөгүй	118	161	148
3	Тайлангаа ирүүлээгүй, Х тайлан	661	1434	2044
4	Тайланд хийсэн дүгнэлтээр	85	456	349
5	Бусад байгууллагын хүсэлтээр	89	62	85

Хүснэгт 15 /үргэлжлэл/

ХШ–д хамруулах үндэслэл		2004	2005	2006
6	Мэдээлэл, өргөдөл, гомдол	63	76	178
7	Хөндлөнгийн мэдээллээр	51	133	195
8	Сэдэвчилсэн	171	91	180
9	Графикт	6823	6942	8315
10	Бүртгэлээс хасагдсан, татан буугдсан	148	126	169
11	Бусад	596	599	1077
	Дүн	8879	10190	12873
	Татвар төлөгчдийн тоо	39951	42853	51486
		22%	24%	25%

Эх сургалж: УТЕГ–ын МБАХ–ийн мэдээлэл

Татварын алба хуулийн хэрэгжилтэд хяналт тавихдаа татвар төлөгчдийг олон үндэслэлээр сонгож хамруулах бөгөөд нийт татвар төлөгчийнхөө 20 гаруй хувьд нь хүрч ажилладаг ажээ. Эдгээр хяналт шалгалтад хамрагдсан татвар төлөгчид ямар нэг байдлаар хариуцлага хүлээдэг байна. Тухайлбал; УТЕГ–ын МБАХ–ийн 2004 оны Хяналт шалгалтын өөр нэг мэдээлэлд Хяналт шалгалтад нийт 15882 татвар төлөгч шалгагдсанаас 9847 акт үйлдсэн, 2 шүүхийн шийдвэр гарсан, 2959 торгууль шийдвэрийн хуудас, 3712 илтгэх хуудас бичигдсэн гэжээ.

Хариуцлага гэдэг нь нийгмийн харилцаанд оролцож буй субъект бүрийн өөрийн үүргээ эрхийн хэм хэмжээнд гүйцэтгэж буй ёс зүй, эрхийн категори юм. Хариуцлагад хүн бүрийн өмнөө тавьсан зорилт, тодорхой шаардлагыг биелүүлэх үйлдэлд оролцох арга чадвар, боллоцоо, ёс зүйн сонголт, сайшаах, муушаах, шагнах, шийтгэх зэрэг тодорхой асуудлууд багтана.

Иргэний нийгэмд иргэн, байгууллагын гүйцэтгэж буй үүргийг нь татвар төлөгчийн үүргийн хэрэгжилтээр хэмждэг нь тогтсон хэвшил ажээ. Тухайлбал; Оны шилдэг байгууллагыг шалгаруулах, том аж ахуйн нэгжийг шалгаруулах, шилдэг бизнес эрхлэгчийг шалгаруулах зэрэг аливаа шагнах, сайшаах хэлбэр нь үүргээ хэрэгжүүлж буйг урамшуулах хариуцлагын эерэг үзүүлэлт юм. Шалгаруулах, сайшаах, магтахад татвар төлөгчийн үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа нь нэг шалгуур үзүүлэлт болдог нь иргэний нийгэмд татвар төлөх нь нэр төрийн хэрэг гэдэгтэй утга нэг байна. Иймээс нэр төрөө эрхэмлэдэг хэн ч татвараа төлөх ёс зүй, ухамсрыг эзэмшсэн байдаг нь амжилт олох нэг гараа нь болдог ажээ.

Татвар нь нэгэнт хуулиар баталгаажин заавал төлөх үүрэг болж Үндсэн хуулиар зөвшөөрөгдсөн нөхцөлд хүссэн хүсээгүй уг төлбөрийг барагдуулах ёстой

болдог бөгөөд хэрэв төлөхгүй бол хуулийн хүрээнд зохих хариуцлагыг хүлээх болно.

Хариуцлага нь:

- орлогыг нь хураах (тэнцэх хэмжээний торгууль ногдуулах)
- хүү ногдуулах
- татварыг нь нөхөн төлүүлэх зэргээр хууль тогтоомжинд заасан бусад хариуцлага хүлээлгэнэ.

Татварын ногдлыг тодорхойлох, хяналт шалгалтын үйл ажиллагааны явцад хууль тогтоомж ноцтой зөрчсөн нь тогтоогдвол татвар төлөгчийн үйлдвэрлэл, үйлчилгээг татварын алба уг зөрчил болон түүнд нөлөөлсөн шалтгаан, нөхцлийг арилган шийдвэрлэх хүртэл түр зогсоох ч арга хэмжээ авна. Татварын ногдуулалт, төлөлтөнд хяналт тавих, татварыг хураах талаар хууль зөрчсөн нь иргэн, албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал захиргааны шийтгэл ногдуулна.

Хэрэв татвар төлөгч нь татвараа төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн, татварын төлбөрт эд хөрөнгө гаргах үйл ажиллагааг саатуулсан, татгалзсан бол татварын алба татварын хэрэг бүртгэх ажиллагаа явуулж, хэргийг зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

Албан бус эдийн засгийн хүрээг татварт хамруулахын тулд татвар төлөх орчинг сайжруулах, татвар төлөгчдөд татвар нуухын хор нөлөөллийг ойлгуулах, татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх орчин бий болгох, татвар төлөгчдийн талаар хөндлөнгийн мэдээллийн бааз үүсгэж татварын тайлантай тулгадаг нэгдсэн системтэй болох, хяналт шалгалт, мэдээлэл, бүртгэлийн уялдаа холбоо бүхий механизм бий болгох нь зүйтэй юм.

4. Дүгнэлт

Нэгдүгээрт. Татвар хураах ажил нь зөвхөн татварын алба, татвар төлөгчийн хооронд явагдах харилцаа мэт ойлголт давамгайлсан, нийт татвар төлөгчдөд хүрч ажиллах боломжгүй учир бүртгэлтэй төлдөг хэсэгтээ дарамттай, татвар төлөгч нь татвараа шударгаар төлөх механизм бүрдээгүй учир татварт зориулан тайлан гаргах эсвэл орлогын албан татвар төлөхгүй байх боломжид нийцүүлэн тайлагнах сэтгэлгээ бүрдсэн, нийт аж ахуйн нэгжийн 40 орчим хувь нь орлогын албан татварыг их бага хэмжээгээр төлдөг, нийт төлөгдөж буй орлогын албан татварын 96,2%-ийг нийт татвар төлөгчдийн 1,6% нь төлж буй шударга бус татвар хураах механизм үйлчилж байна.

Хоёрдугаарт. Татварын хууль тогтоомжийн боловсронгуй бус, тодорхой бус байдал нь татвар төлөгчдийн үйл ажиллагааг жижигрүүлсэн, нийт бүртгэгдсэн татвар төлөгчийн дийлэнх нь татвар төлөх үүргээсээ ямар нэг арга замаар зайлсхийж буй, татварын алба нь хураавал зохих татварынхаа зохих хувийг хугацаанд нь хурааж чаддаггүй, шийдвэрлэвэл зохих маргаантай өрийн үлдэгдэл ихтэй тогтолцоо үйлчилж байна. Энэ нь улс орны эдийн засагт албан бус эдийн засгийг нэмэгдүүлэх сөрөг үр дагавартай ажээ. Гэвч татварын хуулиудад хийгдсэн шинэчлэл нь 2007 оноос татварын тогтолцоонд үүссэн гажуудлыг залруулахад эерэгээр нөлөөлнө гэж үзэж байгаа ч татвараа зайлшгүй төлдөг байх механизм үйлчлэх учиртай.

Гуравдугаарт. Татвар хураалтын үйл ажиллагаа нь зөвхөн татварын алба, татвар төлөгчийн хооронд явагдах нь субъектив нөлөөлөл ихтэй, тодорхой зарим татвар төлөгчдийг хаацайлах, хамгаалах, зарим хэсэгт нь шахалт дарамт үзүүлэх зэргээр ялгавартай хандах ёс бус үйлдлүүд гардаг нь төрийн үйлчилгээний үйл ажиллагааг гажуудуулах, төрийн албаны ажилчдын ёс зүйн хэм хэмжээ алдагдахад хүргэх төдийгүй татварын албанд авилга бий гэдэг хандлагыг нийгэмд бататгадаг ажээ.

Дөрөвдүгээрт. Татвар хураах үйл ажиллагааны өнөөгийн зохион байгуулалт нь зөвхөн татварын албаны үйл ажиллагаагаар хэрэгжих түвшинд явагдаж байгаа нь нийт татвар төлөгчдөө татварын алба хүрч ажиллах шаардлагаас нийт байцаагчдын 80 орчим хувийг татвар хураалтын үйл ажиллагаанд ажиллахад

хүргэсэн нь татварын албанд нөөцөө үр ашигтай ашиглах, тогтолцооны найдвартай ажиллагааны түвшинг дээшлүүлэх удирдлага зохицуулалтын нөөцийн хуулийг анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.

Тавдугаарт. Татварын албаны үндсэн чиг үүрэг татварын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, татвар төлөгчдөд үйлчлэх замаар төсвийн татварын орлогыг бүрдүүлэх байтал эсрэгээр төсвийн татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх нь нэн тэргүүний зорилт болж байгаа нь татварын санхүүгийн үүргийг нэн тэргүүнд тавьсан бодлогын үр дагавар үргэлжилсээр байна.

Зургадугаарт. Татвараа өөрөө тодорхойлон төлөх зарчимд нийцэх зүй зохистой механизм (Монгол Улсын татвар хураах үйл ажиллагаанд мэдээлэл, бүртгэл, хяналт, хариуцлагын зохистой автоматжуулсан механизмгүй) үйлчлэхгүй байгаа нь татвараас зайлсхийх арга замыг хайх, мэдээллийн үнэн зөв нь төдийлөн ач холбогдолгүй учир татварт зориулан тайлагнах, татвараа цаг хугацаанд нь төлөхгүй байх нөхцлийг бүрдүүлж байна.

Долдугаарт. Татварын албаны мэдээлэл нь олон янзын хүснэгт, хоорондоо уялдаа холбоо авцалдаагүй тоо материалаас бүрдэж байгаа нь удирдлагын үйл ажиллагаанд татвар хураалтын зөв зохистой механизм бүрдүүлэх шийдвэр гаргах боломжийг бүрхэгдүүлж байна. Татварын алба 14 жилийн хөгжлийн түүхийн хугацаанд мэдээ мэдээллийг үнэн зөв болгох, мэдээллийг нотлох, батлах нягтлан бодох бүртгэлийн тоо мэдээллээр хянагдах боломжтой байх, хуулиа хэрэгжүүлээгүй, зөрчсөн тохиолдолд хэн нэг хүнээс хамааралгүй шууд хариуцлага хүлээдэг автоматжуулсан мэдээллийн тогтолцоог бий болгох үндэс нь тавигдсан ч хэрэгжилт хангалтгүй байна.

Наймдугаарт. Хяналт шалгалтын ажил нь татварын албаны үндсэн чиг үүрэг гэдэг утгаараа татварын хуулийн хэрэгжилтийг хангахад туслалцаа үзүүлэх чиглэлээр бус тайлагнасан үзүүлэлт дээр нь төлөвлөгөөнд үндэслэн татвараа төлдөг хэсэгт чиглэдэг нь татвар төлөгчдөд татварын албаны дарамт гэсэн сэтгэлгээг төрүүлж, төвөгшөөх хандлагыг үүсгэдэг ажээ.

Есдүгээрт. Санхүүгийн тайлангийн татварын өмнөх ашиг, татварын тайлангийн татвар ногдуулах орлогын зөрүүг зохицуулах талаарх ойлголт, мэдлэг татварын алба, татвар төлөгчид хангалтгүй дутуу дулимаг байгаагаас тайлангуудын уялдааг хангах, зөрүүг зохицуулах хандлагад өөрчлөлт гарахгүй байна.

Аравдугаарт. Татвар хураалтын эрх зүйн орчинд холбогдох хууль тогтоомж, түүнийг дагалдан гарсан журам, заавар, аргачлал нь татвар хураах үйл явцын хүрээг хамарч

гүйцэтгэвэл зохих ажилбаруудад чиглэсэн байгаа ч үйл явцуудын уялдааг хангах механизмын хүрээ бүрэн тусаагүйгээс татвараа хуулийн дагуу шударгаар төлөхөөс илүү төлөхгүй байх, төлсөн ч бага төлөх арга зам ихтэй механизм үйлчилж байна.

Арваннэгдүгээрт. Татвар хураалтын эхний үйл ажиллагаа болох татвар төлөгчийг бүртгэх, татварын албадын хооронд шилжих хөдөлгөөн батлагдсан журмын дагуу хэрэгждэггүй, татвар төлөгчдийг татварын албадад харъяалуулах асуудлыг нэгдсэн журмаар мөрддөггүй, татвар төлөгчийн шилжих хөдөлгөөнд нэгдсэн шийдвэр гардаггүй зэрэг нь татвар хураах үйл ажиллагаа цэгцтэй явагдах боломжийг алдагдуулж байна.

5. Бодлогын хувилбар

5.1. БОДЛОГЫН ХУВИЛБАРЫН ШИНЖИЛГЭЭ

Аль ч улс орны төрийн бодлогын нэг хэсэг болох татварын бодлого нь нийгэм эдийн засагт шаардлагатай зохицуулалтыг хийх, хяналтыг хэрэгжүүлэх замаар төсвийн татварын орлогыг бүрдүүлэхэд чиглэнэ. Татвар төлөх нь татвар ногдох зүйлсийг эзэмшиж олж байгаа хэн бүхний үүрэг болох тул түүнийг хэрхэн хураан авч хуулийн хэрэгжилтэд нь хяналт тавих нь татварын албаны чиг үүрэг юм. Иймд татварын тэгш шударга, үр ашигтай байх зарчмыг хангах татвар хураах механизмын бодлогын хувилбар нь татвараа өөрөө тодорхойлон төлөх механизм юм. Татвараа өөрөө тодорхойлон төлөхөд татварын харилцаанд оролцогчдын эрх үүрэг, хариуцлагын хүрээ маш тодорхой байх нь татварын зарчмуудын хэрэгжилтийг хангахад чухал ач холбогдолтой.

Үндсэн хуулинд заасан үүргээ хэрхэн хэрэгжүүлэх нь татвар төлөгчдөөс ихээхэн хамааралтай ч, түүнийг хэрэгжүүлэхээс өөр аргагүй байх энгийн механизм үйлчлэх нь төрийн татварын бодлогоос шууд хамааралтай ажээ. Татвар хураан авах үйл ажиллагаа нь хэдийгээр төрийн үүрэг ч төр түүнийгээ хэрэгжүүлэх өөр хоорондоо уялдаа бүхий оновчтой механизмыг бүрдүүлж татварын харилцаанд оролцогч субъектүүдийг татаж оролцуулна тэр хэмжээгээр эерэг үр дагавар ирнэ. Иймээс татвар хураах бодлогын талбарын шинжилгээг хийе /Хүснэгт 16/.

Татвар хураах бодлогын талбарт төр, татвар төлөгчөөс гадна татварын хуулийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх бусад байгууллага, иргэний оролцоо чухал байдаг нь хөгжингүй улс орнуудад төлөвшин тогтжээ. Татвар хураах бодлогын зорилго нь нийт татвар төлөгчөөсөө ногдох татварыг нь хураах (тэгш шударга), татвар хураах нь татварын алба, татвар төлөгчдөө хүндрэлгүй байх (энгийн хялбар), татвар хураах зардал бага байх (үр ашиг) замаар татварын хуулиудын хэрэгжилтийг хангах, төсвийн татварын орлогыг нэмэгдүүлж нийт эдийн засагт үр өгөөж авчирч байх явдал юм. Гэвч бодит байдалд татварын хуулийг хэрэгжүүлэхэд татвар төлөгчийн зарим хэсэг нь үүргээ тэгш жигд гүйцэтгэхгүй байх, татвар төлөхөөс

Татвар хураах бодлогын талбар

Хүснэгт 16

Сонирхогч тал	Асуудлын тодорхойлолт	Гол учир шалтгаан	Шалгуур үзүүлэлт	Үзэл баримтлал	
Төр	Төрийн захиргааны албад	Татварын зохицуулалт, хяналт, санхүүгийн үүргийн тэнцвэр	Нийгэм эдийн засгийн оршин тогтнох нөхцлийг хангах	Тэгш болон шударга, үр ашигтай байх зарчим	Нийгэм эдийн засгийн тэнцвэрийг хангах, төсвийн татварын орлогыг нэмэгдүүлэх
	Татварын алба	Татвар төлөгч нь татвараа өөрөө тодорхойлон төлөх	Татвар төлөх нь бүх аж ахуйн нэгжийн үүрэг	Ногдуулсан татвараа хураан авч буй түвшин Татвар хураах зардал	Татварын хуулийн хэрэгжилтийг хангах
Татвар төлөгч	Аж ахуйн нэгж байгууллага	Бизнесийн хүрээгээ тэлэх, үр ашгаа нэмэгдүүлэх	Орлого, ашгаа нэмэгдүүлэх	Татварын зардал	Татварын зардлаа төлөвлөх
	Иргэн	Нийгэм дэх иргэний оролцоо	Өөрийн болон өрх гэрийн оршин тогтнох нөхцлөө хангах	Татварын зардал	Иргэний үүргийг нийгмийн үйлчилгээтэй уялдуулах
Төрийн бус байгууллага болон их, дээд сургууль, ЭШБ, бизнес эрхлэгч	Татварын хуулийг хэрэгжүүлэх	Татвар төлөх нь бүх нийтийн үүрэг	Тэгш болон шударга байх зарчим	Татварын хуулийн хэрэгжилтэд туслах	

зайлсхийх хандлага байнга гардаг нь татварын тогтолцоог тэгш шударга бус болгох бөгөөд үүнийг залруулах арга замыг бодлого боловсруулагчид байнга эрэлхийлж байдаг. Иймээс бодлого боловсруулагчид татварын бодлогын сонирхогч талуудын асуудалд хандах байр суурь, шалгуур, үзэл баримтлалыг авч үзэх нь татвар хураах механизмаа оновчтой сонгон хэрэгжүүлэхэд ач холбогдолтой билээ.

Татвар хураах үйл ажиллагаа нь нийгмийн бүхий л хүрээг хамрах учир түүний эцсийн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь татварын тогтолцооны зарчмууд болно.

Үр дүнгийн матрицийн загвар

Хүснэгт 17

Зорилго	Шалгуур	Өмнөх хуулиар /2005 оны байдлаар/	Шинэчилсэн хуулиар /таамаглал/	Боломжит хувилбар
Тэгш байх	Тайлан тушаалтын хувь	91,3	Өснө	95
	ААНОАТ-ын орлогод 1-р шатлалаар ногдуулсан татварын эзлэх хувь	3,7	Өснө	100
	ААНОАТ-ын орлогод 2-р шатлалаар ногдуулсан татварын эзлэх хувь	96,3	Багасна	-
Шударга байх	1-р шатлалаар татвар төлөх ААН-ийн эзлэх хувь	98,4	Өснө	100
	2-р шатлалаар татвар төлөх ААН-ийн эзлэх хувь	1,6	Багасна	-
	Алдагдалтай тайлан гаргадаг ААН-ийн эзлэх хувь	16,5%	Буурна	Буурах
	Х тайлан гаргадаг ААН-ийн эзлэх хувь	27,4%	Буурна	Буурах
	Хөнгөлөлтийн ногдуулсан татварт эзлэх хувь	25,8%	Буурна	Багасах
	Чөлөөлөлтийн ногдуулсан татварт эзлэх хувь	8%	Буурна	Багасах
Тодорхой байх	Татвар ногдох орлого Хасагдах зардал	Үйл ажиллагааны чиглэлээр Хасахгүй зардал	Орлогын төрлөөр Хасах зардал	Бүртгэх арга зүйг тодорхой болгох
	Орлого зардлыг хүлээн зөвшөөрөх зарчим	Тодорхой бус	Аккруэл суурь	Аккруэл суурь
Төлөгдөхүйц байх	ААН-ийн борлуулалтын орлого	10 сая – 74,2% 10–50 сая – 13,9% 50–100 сая – 3,9% 100–аас дээш 8%	ААН-үүдийн БО нэмэгдэх боломжтой ч НӨАТ- босго нөлөөлнө	НӨАТ-ыг нийтээр төлөх, хувь хэмжээг бууруулах
Үр ашигтай байх	Татварын албаны татвар хураах зардал (урсгал зардлаар)	0,012	Буурна	0,010
	Татвар төлөгчийн татварын зардал	22%	Буурна	10%

ААНОАТ–ын хуулиар татвар хураах механизмын хүрээг нь судалсан судалгаанд үндэслэн үр дүнгийн матриц хийхдээ өмнөх хуулийн үзүүлэлтүүдийг 2005 оны мэдээлэлд тулгуурлан тооцсон. Харин шинэчилсэн хуулийн хувьд хуульд орсон өөрчлөлттэй уялдуудан логик үүднээс таамаглал дэвшүүллээ. Учир нь хууль дөнгөж хэрэгжиж байгаа тул тоон мэдээлэл хараахан гараагүйгээс таамаглалаа батлах тооцоолол хийгээгүй болно. Боломжит хувилбарыг тодорхойлохдоо хувь хэмжээг нэг шатлалд шилжүүлэх, хөнгөлөлт, чөлөөлөлтийг нэмэх бус бууруулах, татварын тайлан гаргадаг хандлагыг судалгааны явцад авсан санал асуулгын хариултад үндэслэн тодорхойлсон болно. Цаашид татварын хуулийн энэ шинэчлэлээ хадгалах болон зарим зүйлийг боловсронгуй болгох, ногдуулсан татварыг нь цуглуулж чадах мэдээлэл, бүртгэл, хяналтын уялдаа бүхий механизмыг хэрэгжүүлснээр боломжит хувилбарт дөхөж очих боломжтой болно. Аж ахуйн нэгжийн эдийн засгийн чадамжийн хувьд татварын хувь хэмжээ, НӨАТ–ын босго их нөлөөтэй тул 10 саяаас дээш борлуулалтын орлоготой гаргахгүй байх хандлага их байгааг цаашид анхаарах нь зүйтэй юм.

Татвараа өөрөө тодорхойлон төлөх үүргийн хэрэгжилтийн өнөөгийн байдалд нөлөөлж буй шалтгаан, үр дагавар

Аливаа улс орны татварын систем нь нийт татвар төлөгчдөө ачаалал нь тэгш шударгаар хуваарилагдаж байх, нийт эдийн засагт үр ашиг авчирч байх бодлого баримтлах нь ард иргэдийнхээ дэмжлэгийг хүлээх төдийгүй татвар хураалтад учрах бэрхшээл, саад багатай байх үндэстэй билээ. Татварын бодлого хэдий сайн боловсрогдсон ч түүнийг хураан авах бүртгэл тооцоо, хяналт шалгалт, хариуцлагын хүчтэй механизмыг бүрдүүлэх зөв зүй зохистой удирдлагаар хангахгүй бол татварын тэгш бус, шударга бус, үр ашиггүй байдал, гажуудлыг залруулж чадахгүй гэдэг нь тодорхой юм.

Монгол улсын татвар хураалт тэгш шударга бус байгаад нөлөөлж буй шалтгаануудыг энэхүү судалгааны хүрээнд хийсэн ажилдаа үндэслэн дурдвал:

- Татварын хууль тогтоомж боловсронгуй бус (4 хууль шинэчлэгдэн мөрдөгдөж байгаа);
- Татварын хувь хэмжээний оновчтой бус байдал (Шинэчилсэн хуулиудаар буурсан);
- Татвар төлөгчийн татвараа өөрөө тодорхойлон төлөх сэтгэлгээ төлөвшөөгүй;
- Татварын албаны үйл ажиллагааны ёс бус үйлдэл (татварын албаны зарим удирдлагаас зарим нэг татвар төлөгчийг хаацайлах, шалгахгүй байхыг байцаагч нарт анхааруулах, татварын байцаагч татвар төлөгчийн тайлан

- гаргах, хяналт шалгалтын байцаагч их хэмжээний зөрчил илрүүлэх гэж оролдох, түүгээрээ шахалт дарамт үзүүлэх г.м);
- Татварын байцаагчдын мэдлэг ур чадвар муу байх;
 - Хариуцлага хүлээлгэхэд хуулийн хэрэгжилтийг хангах тогтолцоо сул тул хариуцлага хүлээхээс эмээх сэтгэлгээ төлөвшөөгүй;
 - Татварын мэдээллийн иж бүрэн систем бүрдээгүй;
 - Татварын алба татвараас зайлсхийгчдэд хүрч ажиллаж чадахгүй байгаа;
 - Татвар төлөгчдийн тодорхой хэсэгт нь татварын хуулийн мэдлэг хангалтгүй;
 - Компани байгуулах шалгуур сул байгаа нь цаасан дээрх компанийн тоо нэмэгдсэн, татвараас зайлсхийх үүднээс хуучнаа татан буулгалт хийлгэхгүй шинээр компани үүсгэн байгуулах;
 - Татвараа шударгаар төлсөн, төлөөгүйн ялгаа нийгэмд тэр бүр харагддаггүй;
 - Бүртгэлгүй үйл ажиллагаа явуулах, бэлэн мөнгөөр гүйлгээ хийх сонирхол давамгайл байдаг;
 - Төрийн байгууллагууд мэдээллээр татварын албыг хангах ажлын хэрэгжилт хангалттай бус;
 - Байгууллагын хаягжуулалт замбараагүй;
 - Гадаадын хөрөнгө оруулалттай компанид хяналт тавихад хүндрэлтэй /Хятад/ зэрэг олон шалтгаануудыг фокус ярилцлага болон ярилцлагад оролцсон хүмүүс дурьдаж байв.

Энэ бүх шалтгааныг нэгтгэн дүгнэвэл татвар хураалтын үйл ажиллагаанд мэдээлэл, бүртгэлээр тавих хяналт, хууль хэрэгжүүлээгүй л бол хариуцлага хүлээлгэдэг механизм үгүйлэгдэж буйг илэрхийлж байна. Мөн аж ахуйн нэгж үүсгэн байгуулах, татвар төлөгчөөр бүртгүүлэх, татан буулгах зэрэг үйл ажиллагаанд нэгдсэн уялдаа бүхий хяналтын механизм шаардлагатай байгааг ч илэрхийлж байна.

Татвар хураалтын механизмын нийгэм эдийн засагт үзүүлж буй сөрөг үр дагавар:

- Эдийн засаг албан ба албан бус гэж хуваагдахад хяналтгүй, хариуцлага хүлээлгэх механизмгүй татвар хураах тогтолцоо шууд нөлөөтэй. Албан бус эдийн засаг нь хуулийн дагуу, хууль бус үйл ажиллагаанд хуваагдах бөгөөд татвараас нуун дарагдуулах, бүртгэлгүйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх үйл явц юм. Хуулийн дагуу үйл ажиллагаа нь орлого болон татвар ногдох зүйлээ багасгах, зардал болон татвараас хасагдах зүйлээ нэмэгдүүлэх, бараа үйлчилгээгээр солилцох, хажуугийн орлого, үнэ шилжилт, электрон

худалдаа гэх мэт үйл ажиллагаагаар дамжин хэрэгждэг. Бүртгэлгүйгээр үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэх хандлага бэлэн мөнгөний гүйлгээг нэмэгдүүлэх бөгөөд энэ нь татвар хураалтад хүндрэл учруулдаг. Бүртгэлтэй ч худал тайлан мэдээ гаргаад өгөхөд түүнийг илрүүлэх механизм сул тул хариуцлага тооцож чаддаггүй тогтолцоо үйлчилж байна.

- Татварын тогтолцоо тэгш, шударга бус болсон. Татварыг төлдөг хэсгээс нь цуглуулдаг, цөөн тооны татвар төлөгч татварын ачааллыг үүрдэг, хөнгөлөлт чөлөөлөлтийн хүрээ өргөн, татвараас зайлсхийгчдэд хариуцлага хүлээлгэдэг механизм сул, хяналт шалгалтаар зөрчил илэрсэн татвар төлөгчийн нилээд хэсэг нь маргаан үүсгэж маргаан таслах зөвлөл, шүүхийн шатанд ялдаг зэрэг нь татварын тогтолцоо шударга бус болоход нөлөөлж байна.
- Аж ахуйн нэгж хэт жижгэрсэн үр ашиггүй тогтолцоо болсон. Бага татвар төлөх гэсэн хандлага нь доод шатлалд хамрагдах, босго хэтрүүлэхгүй байх сонирхлыг төрүүлэх тул аж ахуйн нэгжийн тоо хэт олширсон. Энэ нь татварын алба хэт олон аж ахуйн нэгжийг бүртгэх, түүний хойноос татвар төлүүлэх гэж хөөцөлдөх үргүй зардал гаргах болдог. Нийт бүртгэгдсэн аж ахуйн нэгжийн 40 орчим хувь буюу 10000 гаруй нь ямар нэг хэмжээгээр орлогын албан татвар төлж байгаа судалгаа нь татвар төлөхгүй байх боломж ихтэй тогтолцоо болохыг харуулж байна.
- Татвар төлөх нь зайлшгүй гэсэн сэтгэлгээний төлөвшилд сөргөөр нөлөөлж байна. Татвараас зайлсхийгчдийн хувьд хариуцлага хүлээхгүй буюу хүлээсэн ч татвар төлөх дүнгээс хамаагүй багаар төлөх тул татвараа төлөхгүй байх сэтгэлгээ татвар төлөгчдийн дийлэнх хэсэгт бий болжээ.
- Татвараас зайлсхийх хүрээ өргөжсөн. Татварын тооцоо тайланг үнэн зөв бүртгэх хэрхэн тайлагнах асуудал нэг мөр шийдэгдээгүй учир татварт зориулан тайлан гаргах, мөн хуулийн этгээдийг татан буулгахгүйгээр дахин аж ахуйн нэгж үүсгэх, үйл ажиллагаагаа жижиглэх, салбар нэгж үүсгэх зэргээр олон арга замыг хэрэглэдэг байна. Ер нь азгүй, танилгүй нь хяналт шалгалтад хамрагдаж хариуцлага хүлээх болдог гэсэн ойлголтын хандлага ч байгаа ажээ. Иймээс татварын албаны дарга, байцаагчийн ивээлд багтах үйлдэл ч бодитоор оршин байгааг судалгаанд оролцогчид ярьж байв.

Татвараа өөрөө тодорхойлон төлөх системийг хэрэгжүүлэхэд татварын хууль тогтоомжид татвар хураалтын механизм хэрхэн туссан, зөрчигдөж буй байдлыг авч үзье.

Татвар хураалтын механизмын бүрэлдэхүүн

Хүснэгт 18

Бүрэлдэхүүн хэсэг	Үйлчилж буй бодлого, эрх зүйн зохицуулалт	Зөрчигдөж буй болон сул талууд	
Зохион байгуулалт	Улс орон нутгийн төсөв	Монгол Улсын нэгдсэн төсвийн хуульд улсын татварт 6 албан татвар, 2 төлбөрийн хууль, орон нутгийн татварт 5 албан татвар, 6 төлбөр, 3 хураамжийн хууль ТЭХ-д 16,17-р зүйлд Улсын татварт 7 албан татвар, 1 төлбөрийн хууль, орон нутгийн татварт 6 албан татвар (3 хууль нь хэрэгжээгүй байгаа), 3 хураамж, 5 төлбөрийн хууль	2 хуулийн энэ заалт зөрүүтэй байгаа нь хуулиудын уялдаа алдагдсан Энэ ангилал нь татвар хураалтад татварын орлогын эх үүсвэрийг илрүүлэх, нэмэгдүүлэхэд мотиваци болдоггүй
	Татварын алба	ТЭХ-ийн 19-1-д Татварын ерөнхий хуульд Үндэсний татварын алба нь Үндэсний татварын ерөнхий газар, нийслэл, аймаг, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын улсын байцаагчаас бүрдэнэ.	Бодлогын, хяналтын, үйл ажиллагааны зааг ялгаа тодорхой бус
	Татвар төлөгчийн бүртгэл	ТЭХ-ийн 6.1-д Татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага татварын албанд бүртгүүлнэ. ТНТХТХТХ-ын 5.1-д... шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллага нь бүртгэх байгууллагаас гэрчилгээ авснаас хойш ажлын 3 хоногийн дотор харьяалагдах татварын албанд хувийн хэрэг нээлгэн бүртгүүлнэ. ҮТЕГ-ын даргын 2001 оны 119-р тушаал "Татвар төлөгчийн бүртгэлийн журам"-ыг өөрчлөн 2006 оны 258-р тушаалаар батлан 2007 оны 1-1-ээс мөрдөж байна. Энэ журмаар ААНБ-ын хувьд улсын бүртгэлийн гэрчилгээнд бичигдсэн регистрийн дугаар нь ТТД байна.	Татвар төлөгчийн бүртгэлийн баазын тоо мэдээ зөрүүтэй байх, татвар төлөгчийн бүртгэлийн асуудал бүхэлдээ цэгцрээгүй
	Татвар төлөгчийн харьяалал	ҮТЕГ-ын даргын 2001 оны 119-р тушаал "Татвар төлөгчийн бүртгэлийн журам"-ыг өөрчлөн 2006 оны 258-р тушаалаар батлан 2007 оны 1-1-ээс мөрдөж байгаа. ҮТЕГ-ын дэргэдэх Улсын төсвийн орлого, хяналтын газарт 5 шалгуур үзүүлэлтээр, НТГ-т 3 шалгуур үзүүлэлтээр, Аймаг, дүүргийн татварын хэлтэст өөрийн эзэмшлийн ажлын байр болон албан контортой тохиолдолд тухайн хуулийн этгээдийн албан конторын байршлын дагуу, өөрийн ажлын байргүй, түрээсийн болон өөрийн амьдран суудаг орон байранд үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд тухайн хуулийн этгээдийн захирал, эзний оршин суугаа нутаг дэвсгэрийн татварын алба татвар төлөгчөөр бүртгэнэ.	Татвар төлөгчийг татварын албанд харьяалуулж буй практик нь татвар төлөгчдөд татвараас зайлсхийх боломж бий болгодог байна. Харьяаллыг журмаар тогтоосон ч түүнийгээ хэрэгжүүлдэггүй, албадын даргаасаа эхлээд зөрчдөг, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэдэггүй

Хүснэгт 18 /үргэлжлэл/

	Бүрэлдэхүүн хэсэг	Үйлчилж буй бодлого, эрх зүйн зохицуулалт	Зөрчигдөж буй болон сул талууд
Төлөвлөлт	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн 21-ийн 3-д	Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хуваарийг үндэслэн харьяалах татварын алба тухайн татварын жилд төлөх албан татварын сар, улирлын хуваарийг албан татвар төлөгчид хүргүүлнэ.	Татвар төлөгч өөрөө татвараа тодорхойлон төлнө гэсэн зарчим бий. Татвар төлөгчдөд ийм татвар төлнө гэдэг төлөвлөгөө гаргаж өгөх болж байгаа
	ҮТЕГ-ын даргын 2002 оны 231-р тушаал “Татвар хураах үйл ажиллагааны дүрэм” 31-д	Үндэсний татварын албад өөрийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр харьяалуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирэх жилд төвлөрсөн болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөний төслийг татварын нэр төрөл бүрээр нь бэлтгэж, Санхүү, эдийн засгийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газар, аймаг, нийслэл, дүүргийн Санхүү, эдийн засгийн бодлогын хэлтэст тус тус хүргүүлэн, тэдгээртэй тохиролцож, төсвийн төлөвлөгөөний төслийн нэгтгэлд тусгуулна	Төлөвлөгөөний дагуу татвараа төл, төлөвлөгөө тасрах гэж байна.... төгрөгийг... татварт төл гэдэг нь татвар төлөгчдийг татварын албанд дургүйцэх нөлөөг нэмэгдүүлэх сөрөг талтай
Зохицуулалт	Татвараа өөрөө тодорхойлон төлөх	<p>Үндсэн хууль: 17-ын 3: хуулиар ногдуулсан албан татвараа төлөх</p> <p>ТЕХ 10-ын 1: татвар ногдох зүйл, татвараа үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх</p> <p>ТНТХТХТХ-ын 15-ын 1. Татвар төлөгч холбогдох баримт, бүртгэлд үндэслэн татварын ногдлоо өөрөө тодорхойлон татварын тайланд тусгана.</p> <p>ААНОАТХ-ийн 21.1. Албан татвар төлөгч нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар гаргасан улирал, жилийн татварын тайланг үндэслэн жилийн эхнээс өссөн дүнгээр орлого болон төлөх албан татвараа өөрөө үнэн зөв тодорхойлж төсөвт төлнө.</p>	<p>Татвараа өөрөө тодорхойлон төлөх нь хүчтэй хяналт, бүртгэл, мэдээллийн тогтолцоог бүрдүүлсэн татвар хураах механизмыг шаарддаг.</p> <p>Татвараас зайлсхийх, татварын мэдээ тайлангийн үнэн зөвийг шалгах хүчтэй хяналт, хариуцлагын тогтолцоо үгүй учир төлдөг хэсэгтээ дарамттай, төлөхгүй байх боломж ихтэй шударга бус тогтолцоо болсон.</p>
	Суутган авч төсөвт төлөх	Орлогыг бусдад шилжүүлэх явцад ногдох татварыг нь суутган авч төсөвт төлөхийг ААНОАТХ, ХХОАТ-ын хуулиудад заасан	Татвараа өөрөө тодорхойлон төлөх үүргийн хэрэгжилтийг сурлуулах талтай

Бүрэлдэхүүн хэсэг	Үйлчилж буй бодлого, эрх зүйн зохицуулалт	Зөрчигдөж буй болон сул талууд	
Зохицуулалт	Цуглуулан төсөвт төлөх	Хэрэглээний болон хэрэглэгчийн төлбөр хураамжийн хуулиудад ногдох татварыг ажил үйлчилгээг үзүүлж буй татвар төлөгч нь цуглуулан төсөвт төлөхийг үүрэг болгодог.	Татвар төлөгчийн татвар төлөх чадамжид үндэслэхгүй учир тогтолцоог шударга бус болгох сул талтай
	Ногдуулах төлөх тооцоо	ТЕХ-ийн 9.5-д Аж ахуйн нэгж, байгууллагын татвар ногдуулах, төлөх тооцоог татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч гүйцэтгэнэ.	Татварын итгэмжлэгдсэн этгээдийн үйл ажиллагаа эхлэлийн шатандаа байгаа.
Хяналт	Татварын хяналт шалгалт	ТНТХТТХТХ-ын 15-р зүйл татварын ногдлыг тодорхойлох, хянан шалгах. ... Татвар төлөгч татварын ногдлыг буруу тодорхойлсон гэж үзвэл татварын алба, татварын байцаагч шалган тогтооно. ҮТЕГ-ын даргын 2002 оны 168-р түшаалаар батлагдсан “Татварын хяналт шалгалтын ажлын дүрэм”	Татварын албаны хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэхэд нийт ажиллагсдын 20 орчим хувь нь ажиллаж байгаа.
Хяналт	Татварын мэдээлэл, бүртгэл	ТНТХТТХТХ-ын 9(татварын тайлан, орлого, татвар тодорхойлох хуудсыг бөглөх, түшаах), 10(Мэдээ, баримт цуглуулах)-р зүйлүүд	Үнэн зөв тоо мэдээнд тулгуурлан гаргаж буйг хянах механизм сул
		ТНТХТТХТХ-ын 16.1-д Татварын алба татварын ногдол, төлөлтийн бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн татвар төлөгч бүрээр хөтөлнө.	Зөвхөн статистик мэдээгээр хийгддэг
		ТНТХТТХТХ-ын 6-р бүлэг. Бусад этгээдийн үүрэг	Хэрэгжилтэд зөрчил гардаг

5.2. ТАТВАРАА ӨӨРӨӨ ТОДОРХОЙЛОН ТӨЛӨХ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ БОЛОМЖИТ БОДЛОГЫН ХУВИЛБАР

Зохион байгуулалт


Татвар хураах үйл ажиллагааны үр дүн төсөв бүрдүүлэлт болон татварын албаны зохион байгуулалтаас хамааралтай билээ. Татварын алба нь нутаг дэвсгэрээр зохион байгуулагдсан, төсвийн орлого бүрдүүлэлт нь татварын зүйлээр зохион байгуулагдаж хэрэгжиж байгаа нь татварын албад татвар төлөгчөө булаацалдах, орон нутагт татварын хуулийн хэрэгжилтийг хангах, орлогоо нэмэгдүүлэх сонирхолд мотиваци болж нөлөөлдөггүй сул талууд байна.

Татварын албанд дотоод нэгжүүдийн ажил үүргийн уялдааг хангах замаар татварын албаны “татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих” чиг үүргээ хэрэгжүүлдэг зохион байгуулалтад шилжих нь зүйтэй юм.

Татвараа өөрөө тодорхойлон төлөх үүргийн хэрэгжилтэд улс, орон нутгийн татвар, татварын алба, татвараа хураах, татвар төлөгчийн харьяаллын зохион байгуулалтыг оновчтой болгох замаар харилцаанд оролцогч этгээдүүд бие биенээсээ хамааралгүйгээр тус тусын үүргээ хэрэгжүүлдэг тогтолцоо үгүйлэгдэж байна. Үүний тулд татвар төлөгчийг төлөөлөх итгэмжлэгдсэн этгээдийн үйлчилгээ, компьютерийн програмчлал бүхий татварын мэдээлэл, бүртгэлийн тогтолцоо, хууль зөрчсөн, үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд татварын албаны ажилчдаас хамааралгүйгээр хариуцлага хүлээх болсныг мэдэгддэг автоматжуулсан хүү торгууль ногдуулдаг тогтолцоог бий болгохоор өнөөгийн татварын албаны зохион байгуулалтад өөрчлөлт оруулах хэрэгтэй юм.

Татвар хураалтын үйл ажиллагаа

Схем – 1




Дээрх схем нь татвар хураалтын үйл ажиллагааны ерөнхий дүр зургийг харуулж байгаа. Татвар төлөгч татвараа өөрөө тодорхойлон төлөх системд үндэслэн төлдөг учир татвараа төлөх механизмыг нь татварын удирдлага тодорхойлж татварын хуулийн хэрэгжилтийг хянах нөхцлөө бүрдүүлж ажиллах үүрэгтэй.

Татвар төлөгч татвараа өөрөө тодорхойлон төлөхөд ямар нэг хүндрэлгүйгээр хэрэгжүүлэх, татварын алба нь татвар төлөгчөө үүргээ хэрэгжүүлж буйг хянах боломжтой зохион байгуулалтай байх нь өнөөгийн шийдвэрлэвэл зохих асуудал бөгөөд татвар төлөгч нь үүргээ гүйцэтгэдэг, хэрэв хэрэгжүүлээгүй бол хариуцлага хүлээдэг тогтолцоог бий болгох механизм хэрэгтэй юм.

Татвар хураах механизмын зохион байгуулалт

Схем – 2



Татвар хураах үйл ажиллагааг зөв зохистой явуулахын үндэс нь мэдээлэл удирдлагын системийг автоматжуулж бүртгэлээр тавих хяналтыг эрчимжүүлэх явдал юм. Татварын өнөөгийн мэдээлэл нь олон янзын хүснэгт, хоорондоо авцалдаагүй тоо материалаас бүрдэж байгаа нь татвар хураах үйл ажиллагаанд зохицуулах зохих шийдвэрүүд гаргах боломжийг бүрдүүлэхгүй байна.

Оновчтой зохион байгуулалтын хуулиар бол зорилгоо хэрэгжүүлэхдээ ашиглаж буй нөөцөө хамгийн үр ашигтайгаар зарцуулах үүднээс системийн бүтцийг оновчтой болгоход оршино. Иймээс дээрх схемд татвар хураах механизмд үгүйлэгдэж буй 3 үндсэн санааг гаргасан болно.

- Итгэмжлэгдсэн үйлчилгээг ашиглах
- Татварын нягтлан бодох бүртгэлийг нэвтрүүлэх
- Татварын мэдээлэл, удирдлагын автоматжуулсан системийг нэвтрүүлэх

Системийг үр ашигтай болгох гол үндэс нь мэдээллийг бүрэн зөв, хугацаанд нь хүлээн авч автоматжуулалт, нягтлан бодох бүртгэлийн арга зүйгээр боловсруулж шаардлагатай шийдвэрийг тухайн цаг хугацаанд нь гаргахад оршино. Удирдлагын онолоор бол мэдээлэл бүрэн зөв, цаг хугацаандаа ирэхгүй тохиолдолд системийн

дотоодод тодорхой бус байдал үүсэх бөгөөд энэ нь тухайн системийн шинж төлвийг алдагдуулж үр ашиггүй болгодог гэдгийг татвар хураах үйл ажиллагаанд ямагт санаж, гаргах шийдвэртээ түүнийг хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлж ажиллах нь зүйтэй юм.

Татвараа өөрөө тодорхойлон төлөх дадлыг төлөвшүүлэх

Монгол улсын хөгжлийг хурдасгах нэг чухал зангилаа асуудал нь улс орны нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрээ бүрдүүлэхэд татвар төлөгч бүр үндсэн хуулиндаа заасан үүргээ шударгаар хэрэгжүүлэх болон төрийн үйл ажиллагаанд оролцох иргэдийн оролцоог нэмэгдүүлэх асуудал юм. Хэдийгээр татварын шинэчлэлд татвар төлөгчийн ачааллыг хөнгөлөх талаас өөрчлөлт хийгдсэн ч татвараа өөрөө тодорхойлон төлөх үүргийн хэрэгжилтэнд татвар төлөгчдийг дадлагажуулах, түүнийг төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах нь чухал бөгөөд энэ нь Монгол Улсын санхүүгийн тогтолцоонд үнэлж боломгүй үр өгөөж өгөх нь тодорхой билээ.

Манай ард түмэн социалист нийгмийн үед цалингийн ашиг орлогын татвараас өөрийг төлж байгаагүй учир татвараа өөрөө тодорхойлон төлөх талаар бүрэлдэн тогтсон нийгмийн сэтгэлгээ төдийлөн төлөвшөөгүй болох нь татвар төлөгчийн үүргээ хэрэгжүүлж буй байдлаас тодорхой байна. Зөвхөн татварын байгууллага татвараас зайлсхийгч, зугтагчийн эсрэг төрөл бүрийн арга хэмжээ авах, торгууль, шийтгэл ногдуулах, татварын хяналтыг чангатгах, хөндлөнгийн хяналтын систем нэвтрүүлэх, сургалт сурталчилгаа явуулах зэргээр нийт татвар төлөгчид үүргээ хэрэгжүүлэх сэтгэлгээг бүрдүүлэх боломжгүй билээ.

Татварын орлогыг бүрдүүлэх хамгийн сайн арга нь татвар төлөгчдийн татвараа төлөх нийгмийн зөв сэтгэлгээг төлөвшүүлэх замаар хуулийн хэрэгжилтийг хангах явдал гэдгийг хөгжингүй улс орнуудын туршлага харуулсан бөгөөд гадны зөвлөхүүд ч зөвлөдөг. Татвараа төлөх нийгмийн сэтгэлгээг төлөвшүүлэх ажилд татварын алба чармайх нь үр нөлөө багатай бөгөөд харин ч эсрэгээр олон нийтийн дургүйцлийг төрүүлэх магадлалтай байдаг байна. Монгол улсын бүх шатны татварын байгууллага татвар төлөхийг төрийн өмнөөс шахаж шаардахын зэрэгцээ олон нийтийг ухамсарлуулан ойлгуулах, сэнхрүүлэх ажлыг давхар гүйцэтгэх гэж чармайж байгаа нь эсрэг тэсрэг ажлыг нэг дор хийх гэсэн оролдлого болдог учир төдийлөн үр нөлөө багатай ажил болдог нь тодорхой. Иймээс энэ ажлыг олон нийтийн үүсгэл санаачлагаар үүссэн, өөрөө удирдах ёсны гадаад болон дотоодын байгууллагын оролцоо дэмжлэгтэй гүйцэтгэх нь илүү үр нөлөөтэй бөгөөд хуулийн дагуу үүргээ хэрэгжүүлдэг дадал төлөвших нь татвар хураалтын зардал багасах төдийгүй төрийн санхүүгийн чадавх дээшлэх, татвар төлөгчид ч нийгэмд гүйцэтгэх иргэний үүрэг, оролцоогоо хэрэгжүүлэх соёл төлөвших зэрэг олон эерэг үр дагавар авчрах учиртай.

Иймээс татвараа өөрөө тодорхойлон төлөх дадлыг төлөвшүүлэх ажил нь дараах хоёр хувилбар байж болно.

1–р хувилбар. Одоогийн байгаа түвшинд татварын албадаар дамжуулан зөвхөн хуулийг хэрэгжүүлэх, татвараа төл гэсэн сануулга, шаардлагын сэтгэлгээнд тулгуурласан хувилбар. Энэ нь татвар төлөх үүргийг шаардах, сануулах нь татварын албаны үүрэг гэсэн үзэл. Иймээс татвар төлөгчдөд хэдийгээр татвар төлөх нь таны үүрэг гэдгийг хэлсэн ч хэн нэгний төлөө төлж байгаа гэсэн сэтгэлгээг төрүүлдэг учир төдийлөн үр дүнтэй бус гэдэг нь тодорхой болсон.

2–р хувилбар. Татвар нь нийгэм эдийн засгийн бүхий л хүрээтэй хамарсан төрийн удирдлагын арга хэрэгсэл тул татварын хуулийг хэрэгжүүлэх нь нийгмээс хүртэж байгаа үр өгөөжийнхөө төлөө төлөх бүх нийтийн үүрэг гэсэн үзэлд тулгуурласан хувилбар. Ийм учир татвар хураах ажлыг иргэдийн нийгмээс хүртэж буй үр өгөөжтэй нь уялдуулах замаар хөнгөвчилж болох бөгөөд бүх нийтээр үүргээ хэрэгжүүлэх сэтгэлгээг төлөвшүүлэх боломж бүрдэнэ. Энэхүү хувилбарыг хэрэгжүүлэхэд татварын боловсролын тогтолцоог бий болгож хөгжүүлэх шаардлага гарна. Монгол улсад үндсэн хуулиндаа тодорхойлсон хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг байгуулах зорилтыг хэрэгжүүлэх болон үндэсний татварын тогтолцоог бэхжүүлэх, татвар хураалтыг сайжруулах, татварын хуулиудийн хэрэгжилтийг хангах, төсвийн татварын орлогыг нэмэгдүүлэх үндэс нь татварын боловсролын асуудал мөн.

Татварын үндсэн мэдлэгийг бүх нийтийн боловсролын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлэх хөтөлбөр хийж системтэйгээр олгох нь татварын харилцаа шударга явагдах үндэс болно. Энэ нь:

- Бага /ясли, цэцэрлэг, тоглоом зэрэг нь татвар төлөгчдийн мөнгөөр (Аав, ээжийн төлсөн татвараар) авсан зүйлийг хэрэглэж байгаа гэсэн сэтгэлгээг багаас нь хүүхдэд төрүүлэх/
- Дунд /зам талбай, цахилгаан, эмнэлэг, сургууль нь татвар төлөгчдийн мөнгөөр санхүүждэг, би татвар төлнө гэсэн сэтгэлгээг төрүүлэх/
- Дээд /мэргэжил эзэмших/
- Мэргэшүүлэх чиглэл, концепциор хэрэгжих юм.

Татвараа өөрөө тодорхойлон төлөх системийг хэрэгжүүлэх нь а) татвар төлөгч яаж татвараа төлөхөө тэр бүр мэдэхгүй байх, б) мэдсэн ч аль болох төлөхгүй байх, в) ер нь татвар төлөх шаардлагагүй гэж үздэг нийгмийн хандлага байдаг. Иймээс хууль хэрэгжүүлээгүйгээс үүдэх эрсдлийг ойлгуулах, бүртгэлгүй үйл ажиллагаа явуулах, худал мэдээлэхийн хор уршгийг мэдрүүлэх, хуулийг хэрхэн хэрэгжүүлэхийг зааж сургах шаардлага зайлшгүй гарна. Гэхдээ татвар төлөгчдөд хандсан сургалтад тэр бүр мөнгөө төлөөд суралцах хүсэл түгээмэл төрдөггүй нь татвар төлөх дуртай хүн байдаггүйтэй холбоотой юм.

Иймээс төрөөс татвар төлөгчдөд сургалт, семинар явуулахад тодорхой хэмжээний хөрөнгө төсөвлөж хэрэгжүүлэхдээ зөвхөн татварын албаар бус, харин өөрөө удирдах ёсны байгууллагын туслалцааг авах, төсөл хэрэгжүүлэх замаар нийт татвар төлөгчдөд татварын боловсрол олгох ажлыг хэрэгжүүлэх боломжтой билээ.

Татварын итгэмжлэгдсэн этгээдийн үйл ажиллагааг төлөвшүүлэх замаар татвар хураалтыг сайжруулах нь

Татварын механизм нь төр, татвар төлөгчийн эдийн засгийн сонирхлуудын хооронд харьцангуй тэнцвэрт байдлыг бий болгох замаар татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, татвараа хураахад чиглэнэ.

Татвар төлөгч татвараа өөрөө тодорхойлон төлөх систем нь тэднээс хуулийн дагуу татвараа тооцох, бүртгэх, тайлагнах ажилбаруудыг гүйцэтгэх хэрэгцээ гардаг бол татварын алба нь татварын хуулийг татвар төлөгч шударгаар хэрэгжүүлж буйг хянах хэрэгтэй болдог. Иймээс татвар хураах үйл ажиллагаа нь татварын албаны үүрэг, татвараа төлөх нь татвар төлөгчийн үүрэг байдаг ч энэ хоёр ашиг сонирхлын хооронд татвараа хэрхэн тооцож ногдуулах мэдлэг, арга зүй дутах, татвар төлөгчийн тайлан мэдээ үнэн зөв эсэхийг хянах, тогтоох боломжгүй байх зэргээс татварын харилцаанд гажуудал үүсдэг.

Иймээс татвар хураах нэг механизм нь төр, татвар төлөгчийн хооронд гүүр болон ажиллах татварын итгэмжлэгдсэн этгээдийн үйл ажиллагаа юм. “Татварын итгэмжлэгдсэн этгээдийн үйл ажиллагаа” гэж эрх бүхий байгууллагаас авсан зөвшөөрлийн үндсэн дээр шударга байр суурийг баримтлан татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар эрхлэх үйл ажиллагааг хэлэх бөгөөд энэхүү тогтолцоог 1919 онд Герман улс хэрэгжүүлж эхэлснээс хойш улс орнууд төрийн итгэмжлэгдсэн төлөөлөл гэдэг утгаар хэрэгжүүлж ирсэн туршлагатай билээ. Татварын итгэмжлэгдсэн үйл ажиллагаа хэрэгжсэнээр татварын албанд:

- Татварыг ногдуулах, төлөлтийн ажлуудыг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр гүйцэтгүүлэх боломжтой болох;
- Тайлан мэдээллийн үнэн зөвийг хариуцах эзэнтэй болох;
- Татвартай холбоотой аливаа маргаан, зөрчлийг итгэмжлэгдсэн төлөөлөгчийн оролцоотой шийдвэрлэх боломжтой болох;
- Татварын хууль тогтоомжийн мэдлэг эзэмшсэн хүмүүстэй харьцах нь татварын харилцаанд эерэг үр дагавар бий болох;
- Татварын албаны ажилчдын ирээдүйн нийгмийн баталгаа бүрдэх;
- Татвар ногдуулалт, төлөлтийн үйл ажиллагаа хуулийн дагуу зохих хэмжээнд хэрэгжих нь татвар хураах зардал хэмнэгдэх зэргээр татварын албаны үйл ажиллагаа нилээд хөнгөлөгдөх болно.

Татвар төлөгч нь энэ үүргээ хэрэгжүүлэхдээ нарийн мэргэшсэн мэргэжилтний туслалцаа авах, ингэснээр хууль хэрэгжүүлэхтэй холбоотой үүсч болох аливаа эрсдлээс өөрийгөө хамгаалах боломжтой болохоос гадна энэ ажилд зарцуулах цаг хугацаагаа өөр бусад зүйлдээ зарцуулах бүрэн боломж бүрдэнэ.

Татварын итгэмжлэгдсэн үйл ажиллагааны тогтолцоо нь манай улсад 2005 оноос эхэлсэн бөгөөд энэхүү тогтолцоог төлөвшүүлэн нийгмийн хэрэглээ болгон бүрдүүлэх нь улсын төрийн санхүү, нийгэм эдийн засгийн хүрээ, татварын албаны татвар хураах үйл ажиллагаанд олон талын эерэг үр дагавар авчрах юм.

**Татварын итгэмжлэгдсэн үйл ажиллагааны өнөөгийн байдалд хийсэн
SWOT шинжилгээ**

Давуу тал		Сул тал	
1.	Төрийн бус байгууллагаар зохион байгуулагдсан хуулийн этгээд	1.	Татварын итгэмжлэгдсэн үйл ажиллагааны эрх зүйн орчин
2.	Заавал болон сайн дурын гишүүд дэмжигчтэй	2.	Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа
3.	Татварын талаар эрдмийн зэрэг хамгаалсан болон хуулийн хэрэгжилтийг хангах мэдлэг чадвар бүхий хүмүүсийг нэгтгэсэн	3.	Техник хэрэгсэл, материаллаг бааз
4.	Олон улсын байгууллагуудтай харилцаа холбоо тогтоосон	4.	Шинэ тогтолцоог төлөвшүүлэх боловсон хүчний чадвар
5.	Олон нийтэд татварын талаар мэдээлэл хүргэх ажил хэвшсэн	5.	Сургалтын материал, ном сурах бичиг болон номын сан
		6.	Татварын маргаан, зөрчлийг мэргэшсэн хүний туслалцаатайгаар шийдвэрлэж хэвшээгүй
		7.	Татварын итгэмжлэгдсэн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан нягтлан бодогч цөөн
		8.	Татварын итгэмжлэгдсэн үйл ажиллагааны хуримтлуулсан туршлагагүй
		9.	Нийгэмд энэ талын нэгдсэн ойлголт төлөвшөөгүй
		10.	Мэдээллийн тогтолцоо
Боломж		Аюул	
1.	Төрийн байгууллагын дэмжлэг	1.	Мэдээлэл, сурталчилгааны санхүүжилт
2.	Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч бэлтгэх, шалгалт авах, эрх олгох ажлын суурь тавигдсан	2.	Эрх бүхий бус этгээдүүд энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэх
3.	Татварын итгэмжлэгдсэн үйл ажиллагаа эрхлэх байгууллага үүссэн		
4.	Төр, татвар төлөгчийн хооронд итгэмжлэгдсэн төлөөлөгч байх нийгмийн хэрэгцээ		
5.	Донор байгууллагын туслалцаа авах		

Татварын итгэмжлэгдсэн үйл ажиллагааны өнөөгийн тогтолцооны зорилго нь боломждоо тулгуурлан давуу талаа ашиглан сул талаа сайжруулах, аюулаа арилгах замаар Татварын ерөнхий хуулийн 9-ийн 5 дахь заалтын хэрэгжилтийг хангахад оршино.

Иймээс татварын итгэмжлэгдсэн үйл ажиллагааны туслалцаатайгаар татвар хураалтыг сайжруулах бодлогын хувилбар нь:

- Татварын итгэмжлэгдсэн үйл ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчдын сургалтыг хөдөө, орон нутагт явуулах, чадвартай татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчдыг бэлтгэх;
- Хуульчдын татварын хуулийн мэдлэгийг дээшлүүлэх;
- Татварын тооцоо, тайланг татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчдоор гаргуулдаг болохыг шат дараатайгаар хэрэгжүүлэх;
- Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчдыг “Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль”-ийн дагуу татвар хураах, маргаан, зөрчлийг шийдвэрлэхэд татан оролцуулах эрх зүйн зохицуулалт бий болгох;
- Татварын хуулийг сурталчлах, таниулах, татвараа төлөх дадлыг төлөвшүүлэх ажлуудыг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх

Энэхүү хувилбар нь төр, татвар төлөгчийн хэрэгцээг хангахуйц итгэмжлэгдсэн үйл ажиллагааг төлөвшүүлэх замаар татвар хураалтыг сайжруулах үндэс нь юм. Татварын тооцоо, тайланг татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчдоор гүйцэтгүүлэх нь тайлан мэдээний үнэн зөв байдлыг хангах, эргээд хариуцлага хүлээлгэх механизм бүрдэх ач холбогдолтой. Иймээс итгэмжлэгдсэн гэдэг нь төр, татвар төлөгчийн аль алины итгэлийг хүлээсэн төлөөлөгч гэдэг утгаар олон улсын түвшинд хэрэгждэг ажээ.

5.3. АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫГ БҮРТГЭХ, ТАЙЛАГНАХ ХУВИЛБАР

Нягтлан бодох бүртгэлийн зорилго, татварын зорилгын зөрүү, түүнийг уялдуулах нь

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу орлого зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэх нь нягтлан бодох бүртгэлийн зорилгоор бүртгэхээс зөрүүтэй байдаг тул санхүүгийн тайлангийн татвар төлөхийн өмнөх ашиг, татварын тайлангийн татвар ногдуулах орлого адил байдаггүй. Иймээс зөрүүтэй зүйлсийг тохируулах, санхүүгийн тайлангийн татварын зардал, татварын

тайланд тодорхойлсон татварын өглөгийг тохируулан бүртгэх шаардлага зүй ёсоор тавигддаг. Олон улсын практикт НББОУС-12-оор хэрхэн бүртгэхийг заасан байдаг ч улс орон бүрийн татварын хууль өөрийн онцлогтой тул яг нэг хэв загварын дагуу хэрэгжүүлэх нь туйлын бэрхшээлтэй билээ. Манай улсын хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын бүртгэл, тайланг нягтлан бодох бүртгэлтэй уялдуулах асуудал эцэслэн шийдвэрлэгдэхгүйгээр 15 жилийн түүхийг туулжээ.

Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын шинэчлэгдсэн хууль болон аргачлалд аккруэль сууриар орлого зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэхээр заасан нь суурь зарчмын сонголтоос зөрүү гаргахгүйгээр тооцсон болно. НББОУС-12 нь мөнгөн суурьт тулгуурлах тул манай нөхцөлд нийцэхгүй бөгөөд харин хуулийн нарийн заалтуудтай холбоотой үүсэх зөрүүг хэрхэн бүртгэж тайлагнах арга зүй шаардлагатай байгаа билээ.

Татварын бүртгэл нь санхүүгийн тайланд бүртгэгдсэн ажил гүйлгээний дүн нь татварын хуулийн дагуу татварыг тооцох суурь болох дүнгээс зөрж буй зөрүүний нөлөөллийг бүртгэж татвар төлөхийн өмнөх ашиг, татвар ногдуулах орлогын уялдааг хангах зорилготой юм. Иймээс татварын хууль тогтоомжийн дагуу татвартай холбоотой ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тулгуурлан тооцож, бүртгэж, тайлагнах ажлууд хийгдэнэ.

Манай улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн заалтуудын дагуу татвар ногдуулах орлогыг тодорхойлоход санхүүгийн бүртгэлийн татварын өмнөх ашгаас зөрөх үндсэн нөхцлүүдийг авч үзье.

НББ-ийн зорилго, татварын бүртгэлийн зорилгоос зөрүү үүсэх нөхцөл

Хүснэгт 19

№	Үзүүлэлт	Санхүүгийн бүртгэлийн зорилго	Татварын бүртгэлийн зорилго	Зөрүү үүсэх шалтгаан
1	Чөлөөлөгдөх орлого	Орлогоор бүртгэнэ	Татвар ногдох орлогоор бүртгэхгүй	Татвар ногдуулалтаас чөлөөлж байгаа
2	Тусгайлсан хувь хэмжээтэй орлого	Орлогоор бүртгэнэ	Татвар ногдох орлогоор бүртгэнэ, зарим татвар нь төлөгдсөн учир ТНО болохгүй	Тусгайлсан хувьтай учир татвар тооцох суурийг ялгана, зарим орлогоос татвар нь суутгаснаар төлөгдөнө
3	Хөдлөх хөрөнгө борлуулсан орлого	Олз, гарзыг тодорхойлж бүртгэнэ	Үлдэгдэл өртгийг хассан дүнг ТНО гэж бүртгэнэ	Борлуулахтай холбогдон гарсан зардлыг хасахгүй

Хүснэгт 19 /үргэлжлэл/

№	Үзүүлэлт	Санхүүгийн бүртгэлийн зорилго	Татварын бүртгэлийн зорилго	Зөрүү үүсэх шалтгаан
4	Хязгаарлалт бүхий зардал	Зардлаар бүртгэнэ	Хязгаараас хэтэрсэн дүнг зардал гэж бүртгэхгүй	Хязгаараас хэтэрсэн дүн нь ТНО болно
5	Зардалд тавигдах хязгаарлалт	Зардлаар бүртгэнэ	Хуульд заасан нөхцлийг хангахгүй бол зардлаар бүртгэхгүй	Зардалд хүлээн зөвшөөрөхгүй хэсэг нь ТНО болно
6	Үл хасагдах зардал	Орлого олохтой холбоотой бол зардал гэж бүртгэнэ	ТНО-оос хасагдах зардал гэж хүлээн зөвшөөрөхгүй	Энэ зардлын дүнгээр ТНО-ыг нэмэгдүүлнэ
7	Зээлийн хүүгийн зардал	Зардлаар бүртгэнэ	Зарим хэсгийг нь ТНО-оос хасах зардал гэж хүлээн зөвшөөрөхгүй	Хуулийн заалтын дагуу хүлээн зөвшөөрөгдөхгүй тул ТНО-ыг нэмэгдүүлнэ
8	Элэгдлийн зардал	Зардлаар бүртгэнэ	Хөрөнгийн ашиглалт, ТНО-той уялдуулна	Хуулийн заалтын дагуу хүлээн зөвшөөрөгдөхгүй тул ТНО-ыг нэмэгдүүлнэ
9	Хөнгөлөлт	Орлого, зардлыг бүртгэнэ	Орлого, зардлыг бүртгэнэ	Хөнгөлөгдөх татварыг тооцохын тулд тусад нь бүртгэх шаардлагатай
10	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	Хангамжийн зардал нэрээр зарцуулалтаар бүртгэнэ	Худалдан авсан дүнгээр зардлаар хүлээн зөвшөөрөх	Аккурель, мөнгөн суурьт зарчмын зөрүү
11	Үндсэн хөрөн-гөөс бусад импортын бараа, материал, түүхий эдийн гаалийн албан татвар	Тухайн бараа материалын өртгөөр бүртгэнэ	Тухайн тайлант үед нь төлсөн нийт дүнгээр хасна	Аккурель, мөнгөн суурьт зарчмын зөрүү

Зөрүүг үүсч буй шинж байдлаас нь байнгын шинжтэй болон түр шинжтэй гэж ангилах бөгөөд хууль тогтоомжийн заалт, арга аргачлалын сонголтоос хамаарна. Байнгын зөрүү нь ирээдүйн татвар ногдуулах орлогод нөлөөлөхгүй зөвхөн тухайн тайлант үеийн тооцоонд хамаарна. Харин түр шинжтэй зөрүү нь тухайн тайлант үе болон ирээдүйн тайлант үеийн аль алины тооцоонд нөлөөлнө. Өөрөөр хэлбэл тухайн тайлант үед үүссэн зөрүү нь ирээдүйн тайлангийн үеүдэд нөхөгдөх хойшлогдсон татварын өглөг, хөрөнгө дансуудаар зохицуулан бүртгэхийг олон улсын нягтлан бодох бүртгэлийн 12-р стандартад заасан. Хуулинд хэдийгээр аккурель суурьт зарчмыг хэрэглэхээр заасан ч зарим заалтуудын хувьд мөнгөн

суурьт зарчмаар хэрэгжихээр байгааг анхаарах төдийгүй зөрүүг зохицуулах арга зүйг тодорхой болгож тайлан мэдээний үнэн зөв байдлыг хангах нь төрийн зүгээс анхаарвал зохих асуудал юм.

НББ–ийн зорилго, татварын бүртгэлийн зорилгоос үүсэх зөрүүгийн шинж байдал, нөлөөлөл

Хүснэгт 20

№	Үзүүлэлт	Байнгын	Түр	
			Ирээдүйд татвар ногдох зөрүү	Ирээдүйд хасагдах зөрүү
1	Чөлөөлөгдөх орлого	Тухайн тайланд нөлөөлнө	Нөлөөлөхгүй	Нөлөөлөхгүй
2	Тусгайлсан хувь хэмжээтэй орлого	Тухайн тайланд нөлөөлнө	Нөлөөлөхгүй	Нөлөөлөхгүй
3	Хөдлөх хөрөнгө борлуулсан орлого	Тухайн тайланд нөлөөлнө	Нөлөөлөхгүй	Нөлөөлөхгүй
4	Хязгаарлалт бүхий зардал	Тухайн тайланд нөлөөлнө	Нөлөөлөхгүй	Нөлөөлөхгүй
5	Зардалд тавигдах хязгаарлалт	Тухайн тайланд нөлөөлнө	Нөлөөлөхгүй	Нөлөөлөхгүй
6	Үл хасагдах зардал	Тухайн тайланд нөлөөлнө	Нөлөөлөхгүй	Нөлөөлөхгүй
7	Зээлийн хүүгийн зардал	Тухайн тайланд нөлөөлнө	Нөлөөлөхгүй	Нөлөөлөхгүй
8	Элэгдлийн зардал	Тухайн тайланд нөлөөлнө Ирээдүйн тайланд ч нөлөөлнө	Нөлөөлнө Нөлөөлөхгүй	Нөлөөлнө Нөлөөлөхгүй
9	Хөнгөлөлт	Тухайн тайланд нөлөөлнө	Нөлөөлөхгүй	Нөлөөлөхгүй
10	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	Тухайн тайланд нөлөөлнө Ирээдүйн тайланд ч нөлөөлнө	Нөлөөлөхгүй	Нөлөөлнө
11	Үндсэн хөрөнгөөс бусад импортын бараа, материал, түүхий эдийн гаалийн албан татвар	Тухайн тайланд нөлөөлнө Ирээдүйн тайланд ч нөлөөлнө	Нөлөөлнө	Нөлөөлнө

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн заалттай холбогдон гарах ихэнх зөрүү нь тухайн тайлант үед хамаарах учир байнгын шинжтэй зөрүү үүсч байна. Харин элэгдлийн зардал нь аргын сонголтын зөрүүтэй байдлаас хамааран түр шинжтэй зөрүү үүсч болох юм. Элэгдлийн зардлыг тооцох шулуун шугамын аргаас өөр арга хэрэглэвэл түүнээс үүсэх зөрүү ирээдүйн тайлант үеүүдэд хэрхэн нөлөөлөхийг тооцож зөрүүг зохицуулах шаардлагатай болно. Татварын

зорилгоор элэгдлийн зардлыг шулуун шугамын аргад суурилж байгаа гэж үзэхээс гадна урсгал засварын зардлын хэтэрсэн хэсгийн нөлөөлөл гарах төдийгүй хөрөнгийн ашиглаж буй байдал ч зөрүү үүсэхэд нөлөөлнө гэж ойлгох болж байна.

Үүсч буй зөрүүгээс шалтгаалан ирээдүйд тооцох татварын өглөг ихсэх, багасах нөлөөллийг хөрөнгө, өр төлбөртэй нийцүүлэн бүртгэх нь “Татварын нөлөөлөл”-ийг нягтлан бодох бүртгэлд тусгах үзэл баримтлал юм. Бодит хөрөнгө, өр төлбөрийн дансны дүнд өөрчлөлт орохгүй боловч ирээдүйд төлөх татварын хэмжээнд гарах өөрчлөлтийг үнэн зөвөөр илэрхийлэхэд оршино.

Байнгын зөрүү нь аль ч тайлангийн үед оршин байдаг учир татварын нөлөөллийг бүртгэлд тусгах талаар НББОУС-12-д авч үздэггүй. Энэ зөрүү нь тайлангийн үе бүрд татвар төлөхийн өмнөх ашиг, татвар ногдуулах орлого зөрөх нөхцөл болдог учир түүнийг хэрхэн нийцүүлэн бүртгэх нь шийдвэрлэх асуудлын нэг юм.

Олон улсын практикт зөрүүг зохицуулан бүртгэх 3 аргыг хэрэглэдэг байна.

1. Хойшлуулах арга
2. Хөрөнгө, өр төлбөрийн арга
3. Цэвэр дүнгийн арга (Татвар тооцсоны дараах арга)

1,2-р арга нь Хойшлогдсон татварын хөрөнгө, хойшлогдсон татварын өглөгийн дансыг хэрэглэнэ. Хойшлуулах арга нь орлогын тайланд, Хөрөнгө, өр төлбөрийн арга нь балансад зөрүүг тусгахад тулгуурладаг бол 3-р арга нь татварын нөлөөллөөс үүсч буй зөрүүг нэг элемент болгон нэмэх, хасах үзүүлэлтээр тайлагнах үзэл баримтлал юм. Өөрөөр хэлбэл зөрүү үүсгээд байгаа нөлөөллийг нэмэх буюу хасах тохируулга болгон тайлагнаж эцсийн дүндээ зөрүү үүсгээд байгаа дүнг балансад хөрөнгө, эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хорогдуулах утгаар илэрхийлдэг байна.

Судлаачийн зүгээс Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу үүсч буй зөрүүг цэвэр дүнгийн аргаар бүртгэж тайлагнах хувилбарыг санал болгож байна. Нягтлан бодох бүртгэл, татварын хуулинд орлого, зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэх аккруэль суурьт зарчмыг хэрэглэж байгаа тохиолдолд үүсэх зөрүү ихэнх нь байнгын шинжтэй байгаа гэдэг нь ирээдүйн тайлант үеийн татварын хэмжээнд нөлөөлөхгүй болохоор хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн дансыг хэрэглэхгүйгээр зөрүүний нөлөөллийг татварын зардлаар зохицуулах нь бүртгэлийг илүү хялбар болгоно. Гэвч суурь зарчмын зөрүүгээр үүсэх зарим зүйлийг харгалзан бусад аргатай хослуулан хэрэглэх боломжтой билээ.

Зөрүүг зохицуулах хоёр хувилбар байна.

1 дэх хувилбар нь татварын өмнөх ашгаас тооцсон татварын зардал, төлбөл зохих татварын дүн 2-ын зөрүүг харах боломжтой бөгөөд санхүүгийн тайлангийн татварын өглөгт бодитоор төлөх дүн бүртгэгдэх боломжтой болно. Энэ арга нь татварын зардал, төлбөл зохих татварын өглөгөөс үүсэх зөрүүг өмчийн өөрчлөлтийн тайланд тайлангийн үеийн ашгийг зохицуулах байдлаар харуулна.

2 дахь хувилбар нь татварын тайлангийн төлбөл зохих татварын дүнгээр орлогын тайлангийн татварын зардлыг бүртгэж болно. Энэ хувилбар нь орлогын тайланд бодит татварын ачааллыг харуулахаараа давуу талтай төдийгүй тайлангуудын уялдааг хангаж чадах юм. Судлаачийн хувьд хоёр дахь хувилбарыг санал болгож байгаа бөгөөд НББ, татварын бүртгэлийн зорилгоос үүдэх зөрүүг татварын зардлаар шууд зохицуулах боломжтойгоороо давуу талтай болно. Хэрэв зөрүүг бодит дүнгээр нь балансад тусган харуулна гэвэл 1-р хувилбараар зохицуулалтыг хийж болно.

Зөрүүг зохицуулах 1-р хувилбар:

Тайлангуудын уялдаа

Хүснэгт 21

Орлогын тайлан		Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан	
Борлуулалт (үйлчилгээний) орлого – хөнгөлөлт, буцаалт Цэвэр борлуулалт – Борлуулсан бүтээгдэхүүний өртөг Нийт ашиг – Үйл ажиллагааны зардал • Захиргааны зардал • Борлуулалтын зардал Үйл ажиллагааны ашиг + Үйл ажиллагааны бус орлого – Үйл ажиллагааны бус зардал Ердийн үйл ажиллагааны орлого + Онцгой шинжтэй орлого – Онцгой шинжтэй зарлага Татварын өмнөх ашиг (алдагдал) Татварын зардал Тайлангийн үеийн ашиг		Татварын өмнөх ашиг (алдагдал) Хасах нь: • Чөлөөлөлт, хөнгөлөлт, тусгай хувь хэмжээтэй орлогууд Нэмэх нь: • Хязгаарлалт бүхий зардал, үл хасагдах зардал Татвар ногдуулах орлогын дүн + Сайн дурын даатгалын хураамжийн хэтэрсэн дүн Татвар ногдуулах орлогын дүн – Өмнөх жилийн тайлангийн алдагдал Эцсийн татвар ногдуулах орлогын дүн Ногдуулсан татвар – Хөнгөлөгдөх татварын дүн Шаталсан хувь хэмжээгээр ногдуулах албан татвар + Тусгайлсан хувь хэмжээгээр ногдуулах албан татвар Нийт төлбөл зохих албан татварын дүн	
Баланс		Өмчийн хөдөлгөөний тайлан	
Хөрөнгө	Өр төлбөр	Эхний үлдэгдэл	xx
Эргэлтийн хөрөнгө	Богино хугацаат	Нэмэх:	
Татварын авлага	Татварын өглөг	Тайлангийн үеийн ашиг	xx
		Хасах:	
Эргэлтийн бус хөрөнгө	Эзний өмч	Ногдол ашиг	xx
	Эцсийн үл	Орлогын албан татварын нөлөөлөл (+, -)	xx
Хөрөнгийн дүн xxx	ӨТ ба ЭӨ дүн xxx	Эцсийн үлдэгдэл	xx

Татварын зардал }
 Төлбөл зохих албан татвар } Зөрүү = Орлогын албан татварын нөлөөлөл (+,-)

Орлогын тайлангийн татварын зардлын дүн, татварын тайлангийн төлбөл зохих албан татварын(ТЗАТ) дүн тэнцүү бус байх тохиолдолд татварын өглөгийг

ТЗАТ–аар бүртгэвэл балансийн тэнцвэр хангагдахгүй. Иймээс энэ хоёр дүнгийн зөрүү нь орлогын албан татварын нөлөөллөөс үүсэх учир эзний өмчийн тайланд бүртгэх нь татварын тайлан, санхүүгийн тайлангийн уялдааг хангах үндсэн нөхцөл болно.

Тайлант хугацааны дундуур төлбөр төлөгдөөгүй бол нийт төлбөл зохих албан татварын дүн нь балансад татварын өглөгөөр бүртгэгдэх бөгөөд урьдчилан төлсөн тохиолдолд:

- Урьдчилж төлсөн албан татвар нь Төлбөл зохих албан татвараас их байвал татварын авлага болно.
- Урьдчилж төлсөн албан татвар нь Төлбөл зохих албан татвараас бага байвал татварын өглөг болно.

Зөрүүг зохицуулах 2–р хувилбар:

Тайлангуудын уялдаа

Хүснэгт 22

Орлогын тайлан		Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан	
Борлуулалт (үйлчилгээний) орлого – хөнгөлөлт, буцаалт Цэвэр борлуулалт – Борлуулсан бүтээгдэхүүний өртөг Нийт ашиг – Үйл ажиллагааны зардал • Захиргааны зардал • Борлуулалтын зардал Үйл ажиллагааны ашиг + Үйл ажиллагааны бус орлого – Үйл ажиллагааны бус зардал Ердийн үйл ажиллагааны орлого + Онцгой шинжтэй орлого – Онцгой шинжтэй зарлага Татварын өмнөх ашиг (алдагдал) Татварын зардал Тайлангийн үеийн ашиг		Татварын өмнөх ашиг (алдагдал) Хасах нь: • Чөлөөлөлт, хөнгөлөлт, тусгай хувь хэмжээтэй орлогууд Нэмэх нь: • Хязгаарлалт бүхий зардал, үл хасагдах зардал Татвар ногдуулах орлогын дүн + Сэйн дурын даатгалын хураамжийн хэтэрсэн дүн Татвар ногдуулах орлогын дүн – Өмнөх жилийн тайлангийн алдагдал Эцсийн татвар ногдуулах орлогын дүн Ногдуулсан татвар – Хөнгөлөгдөх татварын дүн Шаталсан хувь хэмжээгээр ногдуулах албан татвар + Тусгайлсан хувь хэмжээгээр ногдуулах албан татвар Нийт төлбөл зохих албан татварын дүн	
Баланс		Өмчийн хөдөлгөөний тайлан	
Хөрөнгө	Өр төлбөр	Эхний үлдэгдэл	xx
Эргэлтийн хөрөнгө	Богино хугацаат	Нэмэх:	
Татварын авлага	Татварын өглөг	Тайлангийн үеийн ашиг	xx
Эргэлтийн бус хөрөнгө	Эзний өмч	Хасах:	
	Эцсийн үл	Ногдол ашиг	xx
		Орлогын албан татварын нөлөөлөл (+, -)	xx
Хөрөнгийн дүн xxx	ӨТ ба ЭӨ дүн xxx	Эцсийн үлдэгдэл	xx

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль хэрэгжүүлэх аргачлалыг сайжруулах

ҮТЕГ-ын даргын 2006 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 235 тоот тушаалаар “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль хэрэгжүүлэх аргачлал”-ыг батлан 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөж байна. Аргачлал нь татварын хуулийн заалтуудыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, түүнд нь ямар нотлох баримт бүрдүүлэх, юунд үндэслэн хэрхэн тооцох зэргийг нарийвчлан тайлбарлаж хэрэгжилтэд учрах аливаа бэрхшээлтэй асуудлыг нэгдсэн нэг ойлголтоор шийдвэрлэх арга зүй болох учиртай.

ААНОАТ-ын хуулийн аргачлалд байгаа зарим нэг дутагдалтай талыг дурьдвал:

1. Хуулийн зүйл заалтыг тайлбарлахдаа нэгдсэн нэг бүтэц хэрэглээгүй нь зарим зүйлийг ойлгоход төвөгтэй байна. /Зарим хэсэгт нь хуулийн...-д заасны дагуу гэснээ, зарим газар нь хуулийн...-д заасан тийм тийм юм гээд тухайн заалтыг хуулсан, үг үсгийн алдаа зэрэг/
2. Шинээр орж буй ойлголтуудыг хэрэгжүүлэх арга зүй, хэрхэн бүртгэх, нотлох баримт бүрдүүлэх талаас тусгаагүй байна. /Байнга байрладаг, байрладаггүй татвар төлөгчийг ялгах шалгуур үзүүлэлт, үндсэн хөрөнгөөс бусад импортын бараа, материал, түүхий эдийн гаалийн албан татвар, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэргүүлэх ач холбогдол салбар гэх мэт./
3. Дансны харьцаа хийсэн нь сайшаалтай ч яг татвар ногдуулалт, төлөлттэй холбогдсон ажил гүйлгээнд хийгдэх хүрээг орхигдуулсан.
4. Холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэх талаар зарим нэг заалтад ашигласан боловч заримд нь ямар хууль тогтоомжийн дагуу гэдгээ дурьдалгүй тийм хувь хэмжээгээр гээд заасан байгаа нь хуульд байхгүй заалтуудыг аргачлалд тусгаж байгаа мэт харагдаж байна. /Мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 30 хувь хүртэл алдсан ажилтанд олгож байгаа 5 сар, 31-50 хувь алдсан ажилтанд олгож байгаа 7 сар, 51-70 хувь алдсан ажилтанд олгож байгаа 9 сар, 71 хувиас дээш алдсан ажилтанд олгож байгаа 18 сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний нэг ба түүнээс дээшхи удаагийн нөхөн төлбөр; Харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн албан татвар ногдуулах орлогын 2 хувьтай тэнцүү хэмжээгээр бүх нийтийн үүргийн санд төвлөрүүлсэн хөрөнгө гэх мэт./
5. Хуулинд байгаа ойлгомжтой заалтуудыг ямарч тайлбаргүй хуулж аргачлалд оруулсан нь төдийлөн ач холбогдолгүй байна.

6. Санхүүгийн бүртгэлтэй хэрхэн уялдуулах, зөрүүг хэрхэн тодорхойлох талаар тусгаагүй.
7. НББ-ийн зорилгоор зардал гэж хүлээн зөвшөөрч бүртгэдэг зарим зардлууд хуулинд тодорхой бус байгааг аргачлалаар тодруулж тайлбарлаагүй.
8. Хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх, ашиглахгүй байгаа тохиолдолд элэгдэл хорогдлын шимтгэл тооцохгүй гэсэн заалтуудыг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхой бус.

Татварын хуулиудыг хэрэгжүүлэх аргачлал боловсруулах ажил нь нэгдсэн арга зүйд суурилсан, хуулийн заалтуудын ойлголт, практикийн нэгдлийг хангах, тодорхой бус зүйлийг тодруулах, хуулийн хэрэгжилтэд туслах зорилгод чиглэх шаардлагатай билээ. ААНОАТ-ыг хэрэгжүүлэх аргачлал нь боловсруулалтын хувьд боловсронгуй бус байгаа нь дээрх жагсаалтаас тодорхой байна. Татварын хуулийн аргачлал нь хуулийг хэрэгжүүлэх орчинг бий болгоход эрх зүйн заалтуудыг тодорхой болгон тайлбарлаж, түүнийг хэрэгжүүлэх арга механизмуудыг зааж тодруулсан зүй зохистой менежментээр хангах баримт бичиг юм.

ААНОАТ-ын тайланг боловсронгуй болгох нь

Аж ахуйн нэгж нь хууль эрх зүйн хүрээнд ажил гүйлгээгээ баримтжуулан санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүргэлийн зарчим, арга аргачлалаар бүртгэж тайлагнан хэрэглэгчдийг мэдээллээр хангах үүрэгтэй. Мөн нягтлан бодох бүртгэлд суурилан төлөх татвараа өөрөө тодорхойлон төлж, тайлагнах бөгөөд энэхүү тайлан нь татварын албанд татвар төлөгчийн үүргээ хэрэгжүүлсний нотолгоо болно. Иймээс тайлан мэдээ гаргах, татвар төлөх, тайлагнах үүргийг хэрэгжүүлэх нь дараах эрх зүйн хүрээнд зохицуулагддаг. Үүнд.

- Компанийн тухай хуулийн 93,94-р зүйл
- Нягтлан бодох бүртгэлийн хууль
- Татварын ерөнхий хуулийн 9-р зүйл
- Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуулийн 8, 9, 10-р зүйл
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн 21-р зүйл

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд тайланг шинэчлэн ҮТЕГ-ын даргын 2006 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 267 тоот тушаалаар батлан 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөж байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт, татвар ногдуулах орлогыг тодорхойлох нь нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандарттай нийцэхгүй байх нөхцлүүд нилээд гардаг. Иймээс нягтлан бодох бүртгэлийн мэдээлэлд тулгуурлан татварын хууль тогтоомжийн дагуу татвар ногдуулах орлогыг тодорхойлох, татвартай холбоотой ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн арга зүйн дагуу бүртгэж тайлагнахад үнэлэлт өгч, шийдвэр гаргах нь эрх бүхий байгууллагын үүрэг билээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын шинэчилсэн тайлан нь өмнөх тайлангийн үндсэн агуулгаа хадгалсан бөгөөд хуулийн заалт, аргачлалд туссан зарим заалтууд нь зөрүүтэй туссан, санхүүгийн тайлантай уялдаагүй боловсронгуй бус мэдээлэл шинжтэй болсон төдийгүй тодорхой бус зүйл нилээд байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланг өөрчлөх шаардлага нь:

- Мэдээллийн үнэн зөв байдлыг хангах
- Санхүүгийн тайлантай нийцүүлэх (НББ–ээ үнэн зөв хөтлөх)
- Татвартай холбоотой ажил гүйлгээг давхар бичилтийн дүрмээр бүртгэх
- Хуулийн хэрэгжилтийг хянах боломжийг бүрдүүлэх
- Санхүүгийн бүртгэл, татварын бүртгэлийн зөрүүг зохицуулах зэргээс үүдэлтэй болно.

ААНОАТ–ын тайланг санхүүгийн тайлангийн татвар төлөхийн өмнөх ашгаас хөөн зохих зохицуулалтуудыг хийн татвар ногдуулах орлогыг тодорхойлоход чиглэх нь татварын зардал, татварын өглөгийг бодитоор тодорхойлж нягтлан бодох бүртгэлийн арга зүйгээр бүртгэж тайлагнах боломжтой болох юм. Ингэснээр татварын алба татвар төлөгчийн мэдээлэлд нягтлан бодох бүртгэлийн арга зүйгээр үнэлэлт, дүгнэлт өгөх, шийдвэр гаргах боломж бүрдэх бөгөөд мэдээллийн үнэн зөв байдлыг хангахад тустай юм. Тайланг өөрчлөх хувилбарыг хийн хавсралтаар харуулав.

ААНОАТ–ын тайлангийн бүтцийн харьцуулалт

Хүснэгт 23

Одоогийн мөрдөж тайлангийн хувилбар	Өөрчлөх хувилбар
I. Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулах татварын тооцоолол	I. Татвар ногдуулах орлого, татварын өглөгийн тооцоолол
1. Нийт борлуулалтын орлого	Санхүүгийн тайлангийн татварын өмнөх ашиг
1.1 Чөлөөлөгдөх орлого	Хасах нь:
1.2 Татвар ногдох орлого	1. Татвараас чөлөөлөгдөх орлогын дүн
2. Татвар ногдох орлогоос хасагдах зардлын дүн	2. Тусгайлсан хувь хэмжээтэй орлого
3. Татвар ногдуулах орлогын залруулга	3. Хөнгөлөгдөх орлого
4. Татвар ногдуулах орлогын дүн	Нэмэх нь:
5. Өмнөх тайлангийн алдагдал	1. Хязгаарлалт бүхий зардал
6. Эцсийн татвар ногдуулах орлогын дүн	2. Зардалд тавигдах хязгаарлалт, үл хасагдах зардал
7. Ногдуулсан татвар	3. Импортолсон үндсэн хөрөнгийн гаалийн албан татвар
8. Хөнгөлөгдөх татвар	4. Зээлийн хүүгийн зардал
9. Нийтлэг хувь хэмжээгээр төлбөл зохих татвар	5. Элэгдлийн зардал
II. Тусгайлсан хувь хэмжээгээр ногдуулах татварын тооцоолол	Татвар ногдуулах орлогын дүн
10. Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэг худалдсан буюу төлбөртэй ашиглуулсан, эротик тоглолт явуулсан үйлчилгээний орлогод ногдуулсан татвар	Нэмэх нь: Сайн дурын даатгалын хураамжийн хэтэрсэн дүн
11. Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогод ногдуулсан татвар	Татвар ногдуулах орлогын дүн – Өмнөх жилийн тайлангийн алдагдал
12. Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлогод ногдуулсан татвар	Эцсийн татвар ногдуулах орлогын дүн Ногдуулсан татвар
13. Тусгайлсан хувь хэмжээгээр төлбөл зохих татварын дүн	Хөнгөлөгдөх татварын дүн
14. Нийт төлбөл зохих татварын дүн	Шаталсан хувь хэмжээгээр ногдуулах албан татвар
III. Татварын тооцоолол	Тусгайлсан хувь хэмжээгээр ногдуулах албан татвар
	Нийт төлбөл зохих албан татварын дүн
	II. Татварын тооцоолол
	III. Өртөг зардлын дэлгэрэнгүй тайлан

Энэ хоёр тайлангийн эцсийн зорилго нь татвар ногдуулах орлогыг үнэн зөв тодорхойлоход оршино. Иймээс татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо нягтлан бодох бүртгэлийн мэдээлэлд тулгуурлан хоорондын уялдааг хангах нь тоон мэдээллийн үнэн зөвийг батлах нотолгоо болохоороо давуу талтай.

Өнөөгийн мөрдөж буй тайлангийн дутагдалтай тал нь:

- Татвар ногдуулах орлого тодорхойлохтой холбоотой орлого, зардлын мэдээлэл нь үнэн зөв болохыг тогтооход бэрхшээлтэй. Учир нь санхүүгийн тайланд туссан орлого, зардлын нилээд нь татвар ногдуулах орлогыг тооцохтой нийцдэггүй.
- Санхүүгийн тайланд туссан татварын өглөг, татварын тайлангийн төлбөл зохих татварын дүн нь зөрүүтэй байдаг.
- Энэ зөрүүнүүд юунаас хэрхэн үүсч буйг мэдэх боломж байхгүй.
- Тоо мэдээлэл нь бүртгэлээр хянагдах боломжгүй мэдээлэл шинжтэй хийгддэг учир татвар ногдуулах орлогыг буруу тодорхойлох магадлалтай.
- Хуулийн зарим нарийн заалтуудын мэдээлэл тусаагүй.
- ААНОАТ-ын хууль болон аргачлалд Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого, Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэг худалдсан буюу төлбөртэй ашиглуулсан, эротик тоглолт явуулсан үйлчилгээний орлогод тусгайлсан хэмжээгээр татварыг ногдуулан суутгагч нь авч төсөвт төлнө гэсэн байтал тайланд татвар төлөгч өөрөө тодорхойлон төлөхөөр туссан.
- Хасагдах зардал гэж нарийвчлан тайланд гаргасан ч элэгдлийн зардал, хүүгийн зардал, хасахгүй зардлуудтай холбоотой зарим зүйлүүд орхигдсон.
- Үл хөдлөх хөрөнгөөс бусад импортын бараа, материал, түүхий эдийн гаалийн албан татварыг хасна гэдэг нь НББ-д өртөгт нь шингээн хассан зүйлийг дахин хасах гэх мэт ойлгомжгүй, тодорхой бус зүйлүүд нилээд байна.

Өөрчлөхөөр санал болгож буй хувилбарын давуу тал нь:

- Санхүүгийн тайлангийн татвар төлөхийн өмнөх ашгаас хөөн татвар ногдуулах орлогыг тодорхойлох нь нягтлан бодох бүртгэл, татварын бүртгэлийн уялдааг харуулах боломжтой болно;
- Мэдээллийн үнэн зөв байдлыг нягтлан бодох бүртгэлийн тоон мэдээлэлтэй тулган шалгах боломжтой болно;
- Санхүүгийн тайлан, татварын тайлангийн зорилгоос хамааран үүсч буй зөрүүг зохицуулах боломж бүрдэнэ;
- Уг зөрүү юунаас үүсч буй нь тодорхой болно;
- Татвар ногдуулах орлогыг тодорхойлоход хамаарах орлого, зардлын зааг ялгаа тодорхой болно;
- Татвар ногдох орлогоос хасах өртөг зардлын үнэн зөв мэдээллээр хангагдана гэх мэт.

Тайлангийн тоон мэдээлэл үнэн зөв болохыг нотлох нотолгоо болохуйц болгохын тулд санхүүгийн тайлангийн тоон мэдээлэлтэй уялдсан баталгаа бүхий байхыг мэдээлэл хэрэглэгчдийн хэрэгцээ зүй ёсоор шаардаж байгаа билээ.

5.4. БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Үндсэн хуулинд “*ногдуулсан албан татвараа төлөх*”, Татварын ерөнхий хуулиар “*татвар ногдох зүйл, татвараа үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх*”-ийг хуульчлан баталгаажуулсан боловч түүнийг хэрэгжүүлэх механизм бодлогын хувьд бүрэн тодорхойлогдож татвар хураах үйл ажиллагаанд хэрэгжилт зохих ёсоор төлөвшөөгүй байгаагийн зэрэгцээ хөгжлийн шаардлагаар эрх зүйн орчинг боловсронгуй болгох, зохих зохицуулалтууд үг үйлэгдсээр байна.

1. Татвар хураалтын өнөөгийн байдлыг сайжруулахад дараах зөвлөмжүүдийг санал болгож байна. Үүнд:

- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн шалгуурыг өөрчлөх, татвар төлөгчийн бүртгэл, тэдний шилжих хөдөлгөөний талаар цэгцтэй мэдээллийн баазыг бий болгох, зөрчсөн үед хариуцлага хүлээлгэдэг механизм үйлчлэх;
- Алдагдалтай болон Х тайлан гаргагчийн үйл ажиллагааг хөндлөнгийн мэдээллээр хянах хүчтэй механизм бий болгох, татварын алба тайлан мэдээ үнэн зөв байх нөхцлийг бүрдүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлэх (автоматжуулсан тогтолцоог хөгжүүлэх);
- Татвар төлөгчийн харъяаллыг журмын дагуу хэрэгжүүлэх бүртгэлийн механизмыг бий болгох (хэн нэг албаны даргын болон ажилтны нөлөөгүйгээр зөвхөн журамд заасан харъяаллын зарчмаар татварын албадад харъяалагдах);
- Татвараа өөрөө ногдуулж төлөх үүргээ хэрэгжүүлэхэд татварын мэргэжилтний туслалцаа авдаг тогтолцоог нэвтрүүлэх;
- Үүргээ хэрэгжүүлэхгүй хууль зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэдэг механизм үйлчлэх тогтолцоотой болох;
- Татварын албаны үйлчилгээг жинхэнэ утгаар нь төрийн үйлчилгээ болгох, татварын байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх бодлого боловсруулах;
- Татварын хууль тогтоомжийн заалтыг бусад хууль тогтоомжтой нийцүүлэх, хуулиудын хоорондын уялдааг хангах.

2. Татварын орлогын төлөвлөгөөг улсын төсвийн орлогын чиг баримжаа гэсэн үзлийг төлөвшүүлэх. Татварын алба, татварын байцаагчийн үйл ажиллагааг төсвийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлтээр үнэлэх бус хураавал зохих татварын хэдэн хувийг хураан авснаар, гүйцэтгэвэл зохих ажлыг ямар түвшинд гүйцэтгэсэн, ажлын үр ашиг, үр дүнг харгалздаг механизмд шилжиж. Өөрөөр хэлбэл татварын албаны ажлын гол үзүүлэлт нь ямар хэмжээний төлөвлөгөөг яаж биелүүлсэнд тулгуурлах бус ногдуулсан татварынхаа хэдэн

хувийг хураан авч буй, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хэрхэн хяналт тавьж ажиллав гэдэг концепц баримтлах нь татварын албаны үндсэн чиг үүрэгтэй нийцэх юм.

3. **Татварын алба төрийн үйлчилгээ үзүүлдэг алба болон төлөвших.** Татварын хуулийн хэрэгжилтийг хангахад туслах үүднээс урьдчилсан хяналтыг хийх, ногдуулсан татвараа хураан авахад чиглэсэн зохион байгуулалтад шилжих. Үүний тулд татварын ногдол хийх, тайлан гаргах ажилд татварын мэргэжилтнийг татан оролцуулах, өөрөө удирдах ёсны байгууллагын туслалцааг авах ажлыг эрчимжүүлэх замаар татвар хураах зардлаа хэмнэх төдийгүй хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх.
4. **Татварын хяналт шалгалтыг татвар төлөгчдөд туслалцаа үзүүлэх үйлчилгээ болгон төлөвшүүлэх.** Татварын хяналт шалгалт нь "Х" болон алдагдалтай тайлан гаргаад байгаа, огт тайлангаа ирүүлдэггүй, тайлангаа худал мэдээлдэг хэсэгт чиглэх нь үндсэн чиг үүрэгтэйгээ нийцэх юм. Өөрөөр хэлбэл хяналт шалгалтыг субъектив нөлөөллийн үүднээс ямар нэг зөрчил илрүүлэх үзэлд тулгуурлаж бус харин татвар төлөгчдөд татвараа төлөхөд нь туслалцаа үзүүлэх замаар татвараас зайлсхийгчдийн хүрээг хязгаарлах, хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэх гэсэн концепцийг баримтлах нь төрийн үйлчилгээний зорилготой нийцнэ.
5. **Татвар төлөгчийн үүргээ хэрэгжүүлээгүй, ямар нэг байдлаар зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээдэг, хүлээлгэдэг механизм үйлчилдэг болох.** Татвар төлөгчийн үүргээ хэрэгжүүлж буйг хянах автоматжуулсан мэдээллийн системийг нэвтрүүлэх. Татварын өр төлбөр үүссэн тохиолдолд хугацаа хэтэрсний хүү тооцогддог, тайлан тушаах хугацаа хожимдуулсан бол торгууль шууд бодогддог, татварын албаны ажилчдын үйл ажиллагаа нь ил тод байх нөхцлийг бүрдүүлсэн програм бүхий автоматжуулалтыг нэвтрүүлэх нь мэдээлэл, бүртгэл, хяналтын уялдааг хангасан механизмыг бий болгох болно.
6. **Татвараа өөрөө тодорхойлон төлөх дадлыг төлөвшүүлэх.** Татвараа өөрөө тодорхойлон төлөх дадлыг төлөвшүүлэхэд татварын боловсролын тогтолцоог хөгжүүлэхээс эхлэх хэрэгтэй юм. Монгол Улсын стратеги төлөвлөгөөтэй уялдсан татварын боловсролын тогтолцоог бий болгох нөхцөл боломжийг бүрдүүлэхэд ҮТЕГ болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам хамтран шийдвэрлэж хэрэгжүүлэх арга хэмжээ авах цаг нь болжээ. Энэ арга хэмжээнд ирээдүйн татвар төлөгчдөд татварын мэдэгдэхүүн олгох, татварын хуулийн хэрэгжилтийг хангах мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, татварын сурах бичиг, багшлах боловсон хүчний асуудлыг хамтад нь шийдвэрлэх шаардлагатай юм.

Төрийн батлан гаргасан татварын хуулиудийг хэрэгжүүлэх асуудал нь бүхэлдээ хууль эрх зүй, тооцоолол, бүртгэл, тайлангийн ажилбаруудад тулгуурласан санхүү, эдийн засаг, хууль эрх зүйн нарийн мэдлэг, ур чадвар шаардсан асуудал болох нь өнөөдөр практикт улам тодорхой болж байна. Иймээс “Татвар төлөгчдийн нийгмийн сэтгэлгээг бүрдүүлэх, татвараа өөрөө тодорхойлон төлөх дадлыг төлөвшүүлэхэд туслалцаа үзүүлэх” төсөл боловсруулснаа санал болгож байна (Төслийн агуулга, хэрэгцээг хавсаргав.)

7. **Татварын бүртгэлийг хөгжүүлэх.** Татварын хуулиудын хэрэгжилт нь бүртгэл, тооцоолол, тайлагналын ажилбаруудаар хийгдэх тул татвартай холбоотой ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн арга зүйгээр бүртгэж тайлагнах нь татварын алба, татвар төлөгчид аль алинд нь хамааралтай төдийгүй татварын хяналт шалгалт хийх, аливаа маргааныг шийдвэрлэх, мэдээ тайлан үнэн зөв болоход тустайг бодолцон татварын бүртгэлийг хөгжүүлэх, зөрүүг зохицуулах асуудлаар төрөөс бодлого боловсруулан хэрэгжүүлэх нь зүйтэй юм. ААНОАТ-ын тайлангийн хүрээнд үүсч буй зөрүүний нөлөөллийг судлан нягтлан бодох бүртгэлд хэрхэн бүртгэх арга зүйг татвар төлөгчдөд эзэмшүүлэх шаардлагатай байна (Зөрүүний нөлөөллийг судлан хавсралтаар хавсаргав.)
8. **Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланг өөрчлөх.** ААНОАТ-ын тайланг санхүүгийн тайлангийн татвар төлөхийн өмнөх ашгаас хөөн зохих зохицуулалтуудыг хийн татвар ногдуулах орлогыг тодорхойлоход чиглэх нь татварын зардал, татварын өглөгийг бодитоор тодорхойлж нягтлан бодох бүртгэлийн арга зүйгээр бүртгэж тайлагнах боломжтой болно. Ингэснээр татварын алба татвар төлөгчийн мэдээлэлд нягтлан бодох бүртгэлийн арга зүйгээр үнэлэлт, дүгнэлт өгөх, шийдвэр гаргах нөхцөл бүрдэх төдийгүй мэдээллийн үнэн зөв байдлыг хангахад тустай билээ. Иймээс санхүүгийн мэдээллийн хоорондын уялдаа холбоог хангах тайланг батлан мөрдөх нь татвар хураалтад шийдвэрлэвэл зохих олон асуудлыг шийдвэрлэх болно (Тайлангийн загварыг хавсралтаар хавсаргав.)
9. **Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль хэрэгжүүлэх аргачлалыг боловсронгуй болгох**
ААНОАТ-ын хуулийг хэрэгжүүлэх аргачлалыг сайжруулахын тулд:
 - Аргачлалын агуулгыг бүтцийн зохион байгуулалтад оруулах (кодчлох). Шаардлагагүй газар хуулийн заалтыг хуулж оруулалгүйгээр харин хуулийн-р заалтын дагуу гэдгээр тайлбараа жишээгээр баяжуулах байдлаар оруулах.

- Нягтлан бодох бүртгэлийн энгийн ажил гүйлгээний дансны харилцаанаас татвартай холбоотой үүсэх ажил гүйлгээнүүдийн харилцааг тусгах нь нэгдсэн ойлголт өгөх, бүртгэлийн арга зүйг хөгжүүлэхэд тустай болно.
- Бусад хууль тогтоомжтой холбоотой заалтуудыг оруулахдаа ямар хууль, дүрэм, заавар болохыг нь зааж шигтгээ болгон оруулах.
- Зайлшгүй мэдвэл зохих зүйлсийн эх сурвалжийг тодорхой зааж оруулах. Тухайлбал: Тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалт, Хэвийн хорогдол тооцох журам нь хэдэн оны ямар эрх зүйгээр батлагдсан юу болохыг нь тодорхой заах.
- Хуульд заасан зарим заалтыг хэрхэн хэрэгжүүлэх нь аргачлалд тусаагүй тодорхой бус байгааг анхаарах. Үүнд:
 - Хуулийн 11.1–ийг ямар тохиолдолд гарах, яаж нотлох
 - Төлөөний газар яаж татвараа төлөх
 - 13.4 – татвар төлөгч бүх хөрөнгөө татвар ногдох орлогод ашиглаж байгаа л гэж тайлагнана, яаж хэрэгжүүлэх вэ?
 - 13.7 – ашиглахаа зогсоовол гэдгийг ямар хөрөнгөнд яаж тодорхойлох вэ? Автомашин эвдэрснээс зогсвол яах вэ?
 - НББ–ийн зүгээс тооцооллоор бүртгэдэг зардлуудыг баримтаар нотлогдсон гэж үзэх үү? Гэх мэт.

Аргачлал нь хуулийг хэрэгжүүлэх арга зүй болох тул хуулийн заалтыг хуулан оруулахаас илүү тухайн заалтыг яаж ойлгож, хэрхэн хэрэгжүүлэх арга замыг тодорхой болгон нэг мөр мөрдүүлэх зорилгоор хуулийн заалтуудыг нарийсган тайлбарлаж, бүртгэл, тайланд тусгах арга зүйгээр хангах үүднээс боловсруулах хэрэгтэй юм. Нягтлан бодох бүртгэл, татварын бүртгэл нь яг нийцэхгүй, ялгаатай ч Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийг хэрэгжүүлэх нь байгууллагын нягтлан бодох бүртгэлд суурилах тул уялдах учиртай гэдгийг бодолцон аргачлалд тайлбар оруулах хэрэгтэй юм.

10. Татварын тогтолцоонд судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх бодлого боловсруулах.

Санхүүгийн салбарын хүрээнд татвар үүслийн хувьд эхнийх байдгийн адил хөгжлийн хувьд тэргүүлж байж улс орны зохицуулах хүрээ зохицуулагдаж төрийн бодлого хэрэгжих учир татварын тогтолцоонд судалгааны ажлыг эрчимжүүлэх үүднээс бодлого боловсруулан хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Иймээс судлагдвал зохих чиглэлүүдийг зөвлөмж болгож байна. Үүнд:

- Татварын боловсролын тогтолцоо
- Татварын бодлогод нөлөөлж буй хүчин зүйлс
- Татварын авилгалын асуудал

- Татварын эрх зүйн актууд, бусад хууль эрх зүйн нийцэлт
- Татварын албаны болон улс, орон нутгийн татварын зохион байгуулалт
- Татварын хяналт шалгалтын үйл ажиллагаа
- Хууль бүрийн хувьд хэрэгжилтийн байдал
- Татварын итгэмжлэгдсэн үйл ажиллагааны төлөвшил
- Татвар төлөгчдийн нийгмийн сэтгэлгээ
- Татварын албаны хүний нөөцийн асуудал
- Татварын албаны үйлчилгээ гэх зэргээр нарийсгасан судалгаа хийж түүний дагуу шийдвэр гаргах нь улс орны хөгжилд тустай болно.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан

1. ТГД: 2. Нэр: _____

3. Татвар төлөгчийн одоогийн хаяг :

Аймаг, хот: _____ Утас1: _____ Утас 2: _____
 Сум, дүүрэг: _____ Факс : _____
 Баг, хороо: _____ Шуудангийн хайрцаг No.: _____
 Гудамж, хороолол: _____ E-mail хаяг: _____
 Байшин: _____
 Хашаа, хаалга: _____

4. Эрхлэх үйл ажиллагаа: Үндсэн: - _____

5. Тайлант хугацаа: он улирал

() Тухайн тайлангийн хугацаанд үйлдвэрлэл явуулж, борлуулалт хийгээгүй бол
 (x)- ээр тэмдэглэнэ

I. Татвар ногдуулах орлого, татварын өглөгийн тооцоолол (мянган төгрөгөөр)

Үзүүлэлтүүд		Мөр	Т.Т-ийн тодорхойлсон	Тат.алба Хянасан	
Санхүүгийн тайлангийн татвар төлөхийн өмнөх ашиг		1			
Хасах нь	1 Татвараас чөлөөлөгдөх орлогын дүн (мөр 3+4+5)	2			
	Засгийн газрын өрийн бичгийн /бонд/ хүү	3			
	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах зарчмаар МУ-ын ЗГ-тай байгуулсан гэрээний дагуу МУ-ын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа оршин суугч бус албан татвар төлөгчийн өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон энэ хуулийн 16.1., 16.2.1. дэх хэсэгт заасан хувиар албан татвар ногдуулах орлого	5			
	Гишүүдийнхээ бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагааны зуучлалын үнийн зөрүүгээс олсон хоршооны орлого	5			
	2 Тусгайлсан хувь хэмжээтэй орлого (мөр 7+19)	6			
	Үүнээс	2.1. Татвар нь суутгалаар төлөгдсөн орлогын дүн (мөр 8+9+...+18)	7		
		• Ногдол ашгийн орлого	8		
		• Эрхийн шимтгэлийн орлого	9		

		Үзүүлэлтүүд	Мөр	Т.Т-ийн тодорхойлсон	Тат.алба Хянасан
Хасах нь	Үүнээс	• Эрх борлуулсны орлого	10		
		• Үл хөдлөх хөрөнгө борлуулсны олз	11		
		• Хүүгийн орлого	12		
		- Зээлийн хүү	13		
		- Харилцах дансны үлдэгдлийн хүү	14		
		- Хадгаламжийн хүү	15		
		- Батлан даалт гаргасны төлбөр	16		
		- Өрийн бичгийн хүү /бондын хүү/	17		
		• Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэг худалдсан буюу төлбөртэй ашиглуулсан, эротик тоглолт явуулсан үйлчилгээний орлого	18		
		2.2. Татварыг нь тооцоолж төлөх орлогын дүн (мөр 20-21-22)	19		
		1. Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлогын дүн	20		
		2. Баримтаар нотлогдох зардал	21		
		3. Хонжворт олгосон мөнгө болон барааны үнэ	22		
		3. Хөнгөлөгдөх орлого	23		
		1. Үр тариа, төмс, хүнсний ногоо; сүү; жимс жимсгэнэ; тэжээлийн ургамал үйлдвэрлэж, тариалж борлуулсан орлогын дүн	24		
		2. Холбогдон гарсан баримтаар нотлогдох зардлын дүн	25		
		3. Татвар ногдуулах орлого (мөр 24-25)	26		
			27		
Нэмэх нь	Үүнээс	1. Хязгаарлалт бүхий зардал (мөр 29+32+33)	28		
		1. Урсгал засварын зардлын хэтэрсэн хэсгийн дүн	29		
		- Үл хөдлөх хөрөнгийн үлдэгдэл өртөг..... x 2% =.....	30		
		- Бусад хөрөнгийн үлдэгдэл өртөг..... x 5% =.....	31		
		2. Албан томилолтын зардлын хэтэрсэн дүн / төрийн албан хаагчдын албан томилолтын зардлын дүнгээс 2 дахинаас илүүгүй байна /	32		
		3. Тогтоосон хэмжээнээс хэтэрсэн хэвийн хорогдол	33		

		Үзүүлэлтүүд	Мөр	Т.Т-ийн тодорхойлсон	Тат.алба Хянасан	
Нэмэх нь	Үүнээс	2.Зардалд тавигдах хязгаарлалт, үл хасагдах зардал (мөр 35+36+ ... +48)	34			
		1. Албан татвараас чөлөөлөгдөх орлого олоход гарсан зардал	35			
		2. Хуульд заасны дагуу албан татвар суутгах шаардлагатай боловч суутгаагүй төлбөр	36			
		3. Албан татвар төлөгчийн буруутай үйл ажиллагаатай холбогдон төлсөн торгууль, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлсөн төлбөр	37			
		4. Банк, банк бус санхүүгийн байгууллагын зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан, хадгаламж зээлийн хоршооны зээлийн эрсдлийн сангийн татвар ногдох орлогоос хасагдсан зээлийн төлөгдсөн дүн	38			
		5. Хэвийн бус зээлийн үлдэгдэлд байгуулсан сан	39			
		6. Хөдлөх хөрөнгө борлуулахтай холбогдон гарсан зардал	40			
		7. Найдваргүй авлагын зардал	41			
		8. Мэргэжлийн сонин, сэтгүүлээс бусад хэвлэлийн захиалга	42			
		9. Гүүдвилийн элэгдүүлэлт	43			
		10. Хэвийн бус хорогдол	44			
		11.	45			
			46			
			47			
			48			
			3.Үндсэн хөрөнгөнөөс бусад хөрөнгөнд төлсөн гаалийн албан татвар	49		
			4.Зээлийн хүүгийн зардал (мөр 51+52+53+54)	50		
		Үүнээс	1. Үндсэн болон туслах үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхлэх, түүнчлэн эд хөрөнгө худалдан авахаас өөр зорилгоор авсан зээлийн хүүгийн төлбөр	51		
			2. Албан татвар төлөгч аж ахуйн нэгжийг хяналтандаа байлгадаг МУ-д байнга оршин суугч хувь хүнээс авсан зээлийн хүүгийн төлбөр	52		
3. Барилга байгууламж барих, тоног төхөөрөмж угсрах, суурилуулах хугацаанд уг зээлийн хүүд төлсөн төлбөр	53					

Үзүүлэлтүүд		Мөр	Т.Т-ийн тодорхойлсон	Тат.алба Хянасан	
Нэмэх нь	Үүнээс	4. Хөрөнгө оруулагчаас албан татвар төлөгчид сүүлд олгосон зээлийн дүн өмнө нь оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээнээс гурав дахинаас илүү гарсан дүнд төлсөн хүүгийн төлбөр	54		
	5. Элэгдлийн зардал (мөр 56+57+58)		55		
	Үүнээс	1. Албан татвар ногдох орлого олохтой холбоогүй ашиглагдаж байгаа хөрөнгөд байгуулсан элэгдэл, хорогдлын шимтгэлийн дүн	56		
		2. Албан татвар ногдох орлого олох зориулалтаар ашиглаж байгаад ашиглахгүй болсон болон өөр зориулалтаар ашиглах үед байгуулсан элэгдэл хорогдлын шимтгэлийн дүн	57		
		3. Ашиглаагүй байгаа үндсэн хөрөнгөд байгуулсан элэгдэл хорогдлын шимтгэлийн дүн	58		
		4.	59		
	6.		60		
	Татвар ногдуулах орлогын дүн (мөр 1-2-6-26-27+28+34+49+50+55)		61		
	Нэмэх нь: Сайн дурын даатгалын хураамжийн хэтэрсэн дүн		62		
	Татвар ногдуулах орлогын дүн (мөр 61+62)		63		
- Өмнөх жилийн татварын тайлангаар гарсан алдагдал / тухайн жилийн албан татвар ногдуулах орлогын дүнгийн 50 хувиас хэтрэхгүй/ (1 дэх жил, 2 дахь жил)		64			
Эцсийн татвар ногдуулах орлогын дүн (мөр 63-64)		65			
Ногдуулсан татвар		66			
Хөнгөлөгдөх татварын дүн		67			
	1. Үр тариа, төмс, хүнсний ногоо; сүү; жимс жимсгэнэ; тэжээлийн ургамал үйлдвэрлэж, тариалж борлуулсан орлогод ногдох албан татвар	68			
	- Хөнгөлөгдөх албан татварын дүн	69			
	2. Тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт оруулсан хөрөнгө оруулалтын дүн (1-р жил, 2 -р жил, 3-р жил)	70			
	- Хөнгөлөгдөх албан татварын дүн	71			
	3. 50-иас дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийт ажиллагчдад эзлэх хувь	72			
	- Хөнгөлөгдөх албан татварын дүн	73			

Үзүүлэлтүүд	Мөр	Т.Т-ийн тодорхойлсон	Тат.алба Хянасан
Шаталсан хувь хэмжээгээр ногдуулах албан татвар (мөр 66-69,71,73)	74		
Тусгайлсан хувь хэмжээгээр ногдуулах албан татвар			
Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлогод ногдуулсан татвар (19* 40%)	75		
Нийт төлбөл зохих албан татварын дүн (мөр 74+75)	76		
Татварын зардал (Санхүүгийн тайлангийн)			
Орлогын албан татварын нөлөөлөл (+, -)			

II. Татварын тооцоолол

Дебет

Кредит

Тайлангийн эхний үлдэгдэл	Илүү	1		
	Дутуу	2		
Ногдуулсан албан татвар		3		
Дансаар төлсөн	Гүйцэтгэл	4		
	Өөрчлөлт /+,-/	5		
Бэлэн бусаар төлсөн		6		
Илүү төлөлтөд суутгасан		7		
Буцаан олгосон		8		
Хүчингүй болгосон		9		
Тайлангийн эцсийн үлдэгдэл	Илүү	10		
	Дутуу	11		

III. Өртөг зардлын дэлгэрэнгүй тайлан

Үзүүлэлтүүд	Мөр	Т.Т-ийн тодорхойлсон	Тат.алба Хянасан
I. Санхүүгийн тайлангийн орлогын тайлан дахь:	1		
1. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2		
2. Үйл ажиллагааны зардлын дүн	3		
- Борлуулалтын зардлын дүн	4		
- Захиргааны зардлын дүн	5		
3. Үйл ажиллагааны бус зардлын дүн	6		
4. Онцгой шинжтэй зардлын дүн	7		
Нийт өртөг, зардлын дүн	8		

Үзүүлэлтүүд	Мөр	Т.Т-ийн тодорхойлсон	Тат.алба Хянасан
II. Татвар ногдох орлогоос хасагдах зардал	9		
Цалин, хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл хөлс	10		
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл	11		
Түүхий эд, үндсэн болон туслах материал, хагас боловсруулсан зүйл	12		
Эргэлтийн бус сав баглаа боодлын зардал	13		
Цахилгаан эрчим хүч, дулаан, уур ус	14		
Бараа, материалын хэвийн хорогдол	15		
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгслэл	16		
Ажиллагчдад олгосон шагнал, урамшуулал, байр, орон сууцны хөлсний болон унаа, хоол, түлшний үнийн хөнгөлөлт	17		
Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэл	18		
Урсгал засварын зардал	19		
Энэ хуулийн 16.2 т зааснаас гадна үндсэн болон туслах үйлдвэрлэл, ажил үйлчилгээг явуулах, хөрөнгө худалдан авах зорилгоор авсан зээлийн хүүгийн зардал	20		
Хөрөнгө оруулагчаас олгосон зээлд төлсөн хүүгийн зардал	21		
Гадаад валютийн ханшийн зөрүүгийн бодит алдагдал	22		
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс	23		
Түрээсийн төлбөр	24		
Санхүүгийн түрээсийн төлбөрийн хүү	25		
Мэргэжлийн сонин, сэтгүүлийн захиалга	26		
Заавал даатгуулах даатгалын хураамж	27		
Сайн дурын даатгалын хураамж	28		
Төсөвт төлөхөөр тайлагнасан онцгой албан татвар	29		
Төсөвт төлөхөөр тайлагнасан үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	30		
Төсөвт төлөхөөр тайлагнасан зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	31		
Төсөвт төлөхөөр тайлагнасан АТБӨЯХ албан татвар	32		
Төсөвт төлөхөөр тайлагнасан газар, байгалийн нөөц ашигласны төлбөр, хураамж	33		

Үзүүлэлтүүд	Мөр	Т.Т-ийн тодорхойлсон	Тат.алба Хянасан
Зээлийн эрсдлийн сан, болзошгүй алдагдлын сан, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгө, даатгалын байгууллагын тухайн жилд байгуулсан нөөцийн сан	34		
Зар сурталчилгааны зардал	35		
Ажиллагсдын сургалт, давтан сургалтын гүйцэтгэлээр нь тооцсон зардал	36		
Албан томилолтын зардал	37		
Үр бордоо, мал амьтны тэжээл, эм тарилга, ургамал хамгааллын арга хэмжээнд зарцуулсан зардал	38		
Тээврийн зардал	39		
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал	40		
Хөдөлмөр хамгааллын зардал	41		
Холбоо, бичиг хэрэг, цэвэрлэгээ, харуул хамгаалалтын зардал	42		
Гамшгийн улмаас учирсан хохирол	43		
Бараа, материалын хэвийн хорогдол	44		
Байгаль орчныг нөхөн сэргээх зорилгоор төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө	45		
	46		
	47		
	48		
	49		
Татвар ногдох орлогоос хасагдах зардлын дүн (10+11+... +49)	50		
III Татвар төлөхийн өмнөх ашиг гаргахад хасагдсан өртөг зардлын дүн	51		
Хасах нь: 1. Хязгаарлалт бүхий зардлын хэтэрсэн дүн	52		
2. Зардалд тавигдах хязгаарлалт, үл хасагдах зардлын дүн	53		
3. Зээлийн хүүгийн зардлын тохируулга	54		
4. Элэгдлийн зардлын тохируулга	55		
5. Үндсэн хөрөнгөнөөс бусад хөрөнгөнд төлсөн гаалийн албан татвар	56		

Үзүүлэлтүүд		Мөр	Т.Т-ийн тодор- хойлсон	Тат.алба Хянасан
		57		
		58		
		59		
	Татвар ногдох орлогоос хасагдах зардлын дүн (51-52-...-59); (50=60)	60		

Тайланг үнэн зөв гаргасан:

Тайланг хүлээн авсан:

Дарга /Захирал/:

Татварын улсын байцаагч:

200.. оны .. сарын ...

200.. оны ... сарын

Ерөнхий нягтлан бодогч:

200.. оны .. сарын ...

Татварын итгэмжлэгдсэн

нягтлан бодогч:

200.. оны ... сарын ...

Хавсралт 2

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль
(НББ-ийн зорилго, татварын бүртгэлийн зорилгын зөрүү)

№		Санхүүгийн бүртгэлийн зорилго	Татварын зорилго	Зөрүү үүсэх шалтгаан
1.	Чөлөөлөгдөх орлого			
	Засгийн газрын өрийн бичгийн хүү	Хүүгийн орлого гэж бүртгэнэ	ТНОрлогоос чөлөөлнө	Санхүүгийн тайланд орлого гэж бүртгэсэн учир татварын тайланд ТТӨА-аас хасч ТНО-ыг тодорхойлно
	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа МУ-д байрладаггүй албан татвар төлөгчийн өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтын орлого	Борлуулалтын орлого гэж бүртгэнэ	ТНОрлогоос чөлөөлнө	
	Гишүүдийнхээ бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагааны зуучлалын үнийн зөрүүгээс олсон хоршооны орлого	Борлуулалтын орлого гэж бүртгэнэ	ТНОрлогоос чөлөөлнө	
2	Тусгайлсан хувь хэмжээтэй орлого			
	<ul style="list-style-type: none"> • ногдол ашгийн орлого; • эрхийн шимтгэлийн орлого; • эрх борлуулсны орлого; 	Үндсэн бус үйл ажиллагааны орлого гэж бүртгэнэ	ТНОрлогоор бүртгэнэ	Тусгайлсан хувьтай, татварыг үнийн дүнгээс нь тооцно, татвар нь суутгалаар төлөгдөнө ТТӨА-д бүртгэгдсэн учир хасч ТНО-ыг тодорхойлох бөгөөд татварын өглөгийг тодорхойлоход өөр хувь хэрэглэнэ
	-хүүгийн орлого (зээлийн хүү, харилцах дансны үлдэгдлийн хүү, мөнгөн хадгаламжийн хүү, батлан даалт гаргасны төлбөр, өрийн бичиг/бонд/-ийн хүү)	Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого гэж бүртгэнэ. Хүүгийн орлого, зардлын зөрүүгээр	ТНОрлогоор бүртгэнэ	

№		Санхүүгийн бүртгэлийн зорилго	Татварын зорилго	Зөрүү үүсэх шалтгаан
	-эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэг худалдсан буюу төлбөртэй ашиглуулсан, түүнчлэн эротик тоглолт явуулсан үйлчилгээний орлого	Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого гэж бүртгэнэ	Нийт дүнгээр орлогоор бүртгэнэ	Орлогын нийт дүнгээс тусгайлсан хувь хэмжээгээр тооцон татвар суутгалаар төлөгдөнө
	-үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;	Үндсэн бус үйл ажиллагааны олз, гарзыг хүлээн зөвшөөрнө	Борлуулалтын орлого нь ТНО болно	Борлуулсан үнийн дүнгээс тусгайлсан хувиар тооцож татвар нь суутгалаар төлөгдөнө
	-Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого	Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого	Уг орлогыг олохтой холбогдон гарсан баримтаар нотлогдох зардал, хонжворт олгосон мөнгөн хөрөнгө болон барааны үнийг хасна	Тусгайлсан хувь хэмжээ
3	Хөдлөх хөрөнгө борлуулсан орлого	Үндсэн бус үйл ажиллагааны олз, гарзыг хүлээн зөвшөөрнө	Үлдэгдэл өртгийг хасна	Холбогдон гарах зардал нь ТНО болно
4.	Хязгаарлалт бүхий зардал			
	Урсгал засварын зардал Капиталжихгүй зардал	Стандартын дагуу -Хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэх - Хүчин чадлыг нэмэгдүүлэх - Бүтээгдэхүүний чанар сайжрах нөхцөлөөс бусад нь хамааруулж бүртгэнэ	үл хөдлөх эд хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 2 хувь, бусад хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 5 хувиас хэтрэхээргүй	Тогтоосон хэмжээнээс хэтэрсэн зардлыг их засварын зардлаар бүртгэнэ

№		Санхүүгийн бүртгэлийн зорилго	Татварын зорилго	Зөрүү үүсэх шалтгаан
	Сайн дурын даатгалын хураамж	Гүйцэтгэлээр бүртгэнэ	ТНО-ын 15%-иас хэтрэхгүй	Хэтэрсэн дүнг ТНО-д нэмж татвараа тооцно
	Албан томилолтын зардал	Гүйцэтгэлээр бүртгэнэ	Төрийн албан хаагчийн зардлыг 2 дахин нэмэгдүүлэхээс хэтрэхгүй	Хэтэрсэн дүнг ТНО-д нэмж татвараа тооцно
	Бараа материалын хэвийн хорогдол	Хэвийн хорогдол, хэвийн бус хорогдол гэж бүртгэнэ. Хэвийн хорогдол зардал, хэвийн бус нь татварын дараах цэвэр ашгийг бууруулна	ЗГ-аас тогтоосон хэмжээнд	Зөвшөөрөгдсөнөөс хэтэрсэн хэсэг нь
5	Зардалд тавигдах хязгаарлалт			
	Албан татвараас чөлөөлөгдөх орлого олоход гарсан зардал;	Зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ	Зардал гэж тооцохгүй	Бүртгэгдсэн зардлыг бууруулж ТНО-оо тооцно
	Албан татвар төлөгчийн баримтаар нотлогдоогүй зардал;	Стандартын дагуу зардлыг бүртгэнэ	Зардал гэж тооцохгүй	
	Суутган тооцох шаардлагатай боловч албан татвар суутгаагүй төлбөр.	Зардлаар хүлээн зөвшөөрнө	Зардал гэж тооцохгүй	Зардлыг бууруулна
6	Үл хасагдах зардал			
	Санхүүгийн түрээсийн төлбөр	Балансад бүртгэн хүүгийн зардлыг бүртгэнэ	Хүүгийн зардлын бүртгэнэ	Зөрүү үүсэхгүй
	Албан татвар төлөгчийн буруутай үйл ажиллагаатай холбогдон төлсөн торгууль, алданги, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлсөн төлбөр.	Үндсэн бус үйл ажиллагааны олз, гарзыг хүлээн зөвшөөрнө	Зардлаар хүлээн зөвшөөрөхгүй	ТНО-оос хасагдахгүй

№		Санхүүгийн бүртгэлийн зорилго	Татварын зорилго	Зөрүү үүсэх шалтгаан
7	ТНО-оос хасагдах			
	Үндсэн хөрөнгөөс бусад импортын бараа, материал, түүхий эдийн гаалийн албан татвар	Тухайн бараа материалын өртгөөр бүртгэнэ	Тухайн тайлант үед нь нийт дүнгээр хасна	Борлогдоогүй барааны өртөгт шингэсэн хэмжээгээр зөрүү үүснэ
	Банк, банк бус санхүүгийн байгууллагын хэвийн зээлийн үлдэгдэлд байгуулсан санд төвлөрүүлсэн хөрөнгө	Зээлийн эрсдлийн сан гэж бүртгэнэ	ТНО-оос хэвийн зээлийн үлдэгдэлд байгуулсан санг хасна	Хэвийн бус зээлийн үлдэгдэлд байгуулсан дүнгээр зөрнө
8	Зээлийн хүүгийн зардал			
	Үндсэн болон туслах үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхлэх, түүнчлэн эд хөрөнгө худалдан авах зорилгоор авсан зээлийн хүүгийн төлбөр	Стандартын шаардлага хөрөнгийг бэлтгэх ажиллагаа хугацаа шаардагдах хөрөнгийн өртөгт хүүгийн зардлыг капиталжуулна	Албан татвар ногдох орлогоос хасч тооцно.	Тайлант үеийн зардлаар бүртгэсэн, капиталжуулсан хүүгийн зардлын зөрүүгээс үүсэх тохируулга
	Албан татвар төлөгч аж ахуйн нэгжийг хяналтандаа байлгадаг Монгол Улсад байнга оршин суугч хувь хүнээс авсан зээлийн хүүгийн төлбөр	Хаанаас зээлсэн нь хамаарахгүй Стандартын шаардлага хөрөнгийг бэлтгэх ажиллагаа хугацаа шаардагдах хөрөнгийн өртөгт хүүгийн зардлыг капиталжуулна	Тухайн албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлогоос хасч тооцохгүй бөгөөд энэ зардлыг зээл олгосон тухайн хувь хүний ногдол ашигт тооцож албан татвар ногдуулна.	ТНО-оос хасахгүй Ногдол ашгаар тооцож татварыг нь суутган авч төсөвт төлнө
	Хөрөнгө оруулагчаас албан татвар төлөгчид сүүлд олгосон зээлийн дүн өмнө нь оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээнээс гурав дахинаас илүү гарсан бол ийнхүү илүү гарсан зээлд төлсөн хүүгийн төлбөр	Стандартын шаардлага хөрөнгийг бэлтгэх ажиллагаа хугацаа шаардагдах хөрөнгийн өртөгт хүүгийн зардлыг капиталжуулна	Албан татвар ногдох орлогоос хасч тооцохгүй бөгөөд түүнийг тухайн хөрөнгө оруулагчийн ногдол ашигт тооцож албан татвар ногдуулна.	ТНО-оос хасахгүй Ногдол ашгаар тооцож татварыг нь суутган авч төсөвт төлнө

№		Санхүүгийн бүртгэлийн зорилго	Татварын зорилго	Зөрүү үүсэх шалтгаан
	Зээлийн хөрөнгөөр барилга байгууламж барих, тоног төхөөрөмж угсрах, суурилуулах хугацаанд уг зээлийн хүүд төлсөн төлбөр	Стандартын шаардлага хөрөнгийг бэлтгэх ажиллагаа хугацаа шаардагдах хөрөнгийн өртөгт хүүгийн зардлыг капиталжуулна	Тухайн хөрөнгийн өртгийн хэсэгт оруулж тооцох бөгөөд түүнийг ашиглалтад оруулсан үеэс зээлийн хүүд төлсөн төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасч тооцно	Зөрүү үүсэхгүй
9	Хөнгөлөлт			
	Үр тариа, төмс, хүнсний ногоо, сүү, жимс жимсгэнэ, тэжээлийн ургамал үйлдвэрлэсэн буюу тариалсан аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод	Орлого, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ	Ногдох албан татварыг 50 хувиар хөнгөлнө	Татварын хөнгөлөлтийг тооцохын тулд тусад нь бүртгэх
	МУ-ын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт... хөрөнгө оруулсан бол уг хөрөнгө оруулалт		10 хувьтай тэнцэх албан татварын хөнгөлөлтийг үзүүлнэ.	Төлөх татварын тооцоонд хамаарна
	50-иас дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилладаг аж ахуйн нэгжид нийт ажиллагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эзэлж байгаа хувь хэмжээгээр		Албан татварын хөнгөлөлт үзүүлнэ.	Төлөх татварын тооцоонд хамаарна
10	Алдагдлыг шилжүүлэн тооцох			
	Алдагдал	Алдагдал нь дараагийн тайланд хамаарахгүй	Алдагдал гарсан татварын жилийн дараахь дараалсан 2 жилийн албан татвар ногдуулах орлогоос хасч тооцно	Төлөх татварын тооцоонд хамаарна

№		Санхүүгийн бүртгэлийн зорилго	Татварын зорилго	Зөрүү үүсэх шалтгаан
11	Элэгдлийн зардал			
	Арга	Аль нэг аргыг сонгож болно	Шулуун шугамын арга	Аргын сонголт
	Хугацаа	Хугацааг холбогдох журмын дагуу сонгоно	Татварын хуулиар заасан хугацааг хэрэглэнэ	Баримтлах эрх зүйн сонголт
	Элэгдлийн зардлыг тооцох	Нийт бүртгэлд байгаа хөрөнгөнд тооцно	Албан татвар ногдох орлого олохтой холбоотой ашиглагдаж байгаа хөрөнгөд элэгдэл, хорогдлын шимтгэлийг хүлээн зөвшөөрнө	Хөрөнгийг ашиглаж байгаа, ашиглахгүй байгаа, албан татвар ногдох орлогод ашиглаж байгаа гэдгээр элэгдлийг ялгаж тооцно
	Хөрөнгийн ашиглалтын зориулалт өөрчлөгдөхөд /Албан татвар ногдох орлого олох зориулалтаар ашиглаж байгаад ашиглахгүй болсон болон өөр зориулалтаар ашиглах үед/	Хөрөнгийн ангилал өөрчлөгдөх үед тухайн үеийн бодит үнэ цэнээр үнэлгээг өөрчлөн олз, гарзыг бүртгэнэ. Энэ нь бодит олз, гарз биш учир татвар ногдуулахгүй	Уг хөрөнгийг үлдэгдэл өртөг, зах зээлийн үнийн аль их үнээр худалдан борлуулсан гэж үзэж албан татвар ногдуулна.	Хөрөнгөнд тавих хяналттай холбоотой
	Ашиглаагүй байгаа үндсэн хөрөнгө	Стандарт ийм заалт байхгүй	Элэгдэл хорогдлын шимтгэл байгуулахгүй	
12	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	Хангамжийн зардал нэрээр зарцуулалтаар бүртгэнэ	Худалдан авсан дүнгээр зардлаар хүлээн зөвшөөрөх	Аккурэль, мөнгөн суурьт зарчмын зөрүү
13	Зар сурталчилгааны зардал			
	Зар сурталчилгааны зардал	Хууль, хууль бусын ялгаа байхгүй	Хууль бус зар сурталчилгаанд зарцуулсан зардал гаргасан байвал албан татвар ногдох орлогоос хасагдахгүй.	

№		Санхүүгийн бүртгэлийн зорилго	Татварын зорилго	Зөрүү үүсэх шалтгаан
14	Татварын хуульд тодорхой бус зүйлүүд			
	Өртөг тооцох аргын сонголт	Аргуудын аль нэгийг сонгон хэрэглэнэ	Тодорхойгүй	
	Найдваргүй авлагын зардал	Зардлаар бүртгэнэ	Тодорхойгүй	
	Хэвийн бус хорогдол	Зардлаар бүртгэнэ	Тодорхойгүй	
	Байгалийн нөөцийн хорогдуулалт	Зардлаар бүртгэнэ	Тодорхойгүй	
	Гүүдвилийн элэгдүүлэлт	Зардалд хүлээн зөвшөөрөхгүй	Тодорхойгүй	

Хавсралт 3

Татвар цуглуулах механизм фокус ярилцлага

2006-10-13 15 цагаас болов.

Татвар төлөгч өөрт ногдох татвараа өөрөө тодорхойлон төлөх үүргийн хэрэгжилтэнд нөлөөлж буй шалтгаан нь

О.Цогт (УТЕГ-ын татвар хураалтын хэлтсийн дарга):

- Хууль эрх зүйн тодорхой бус байдал
- Хувь хэмжээ өндөр байгаа
- Татварын алба хүрч чадахгүй байгаа
- Татвар төлөгч хуулиа мэдэхгүй, мэдэхийг хүсэхгүй байгаа
- Хариуцлага хүлээхээс айхгүй байгаа

Өнөржаргал (СЭЗДС-ийн багш):

- Компани байгуулах шалгуур сул байгаа нь цаасан дээрх компани их болсон
- Татвараа шударгаар төлсөн, төлөөгүйн ялгаа нийгэмд тэр бүр харагддаггүй. Хариуцлага байхгүй
- Бэлэн мөнгөний гүйлгээнд хяналт тавих боломжгүй

Сайнжаргал (Монгол - Алт ХХК-ны санхүүгийн албаны дарга):

- Хариуцлага сул
- Компани байгуулах шалгуур
- Бэлэн мөнгөний механизм

Тунгалаг (Хан-Уул дүүргийн МБТ-ийн дарга):

- Хариуцлага хүлээлгэх мэдээлэл хангалтай бус
- Хөндлөнгийн мэдээллийн баазыг бий болгох, ашиглалтыг сайжруулах

Цэнд-Аюуш (Хан-Уул дүүргийн татвар хураалтын тасгийн дарга):

- Аж ахуйн нэгжийг бүртгэх шалгуур
- Бэлэн мөнгөний гүйлгээнд хяналт тавих механизм байхгүй
- Төрийн байгууллагууд мэдээллээр татварын албыг хангах хуулийн зохицуулалт байхгүй

Цэцэгням (Баянгол дүүргийн ТХТ-ын дарга):

- Аж ахуйн нэгж байгуулах дүрмийн сан /1 хүн хэдэн ч компани байгуулах боломжтой байгаа, татан буулгалт хийдэггүй/
- Байгууллагын хаягжуулалт
- Гадаадын хөрөнгө оруулалттай компани /Хятад/
- Төрийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах эрх зүй
- Хаягжуулалт
- Сурталчилгаа

Төсвийн татварын орлогын төлөвлөгөө

Өнөржаргал:

- Төлөвлөгөө бол худлаа. Төлөвлөгөө, тайлан зөрүүтэй байдаг. Мөн банкинд зээл хүссэн тайлан, татварын албанд ирүүлсэн тайлан зөрүүтэй

Сайнжаргал:

- Төлөвлөгөө бол худлаа. Төлөвлөгөө тасарлаа татвараа төл гэж шахалт үзүүлдэг

Цогт:

- Татварын алба үндсэн үүргээ зөвхөн төсвийн орлого талаас нь нэн тэргүүнд тавьж байгаа

Тунгалаг:

- Төлөвлөгөө ажил дүгнэх үзүүлэлт болдог

Цэцэгням:

- Төлөвлөгөө үндэслэлтэй байх боломж байхгүй байгаа

Татвар төлөгчийн харьяалал

Тунгалаг:

- Эзний оршин байгаа хаяг, аж ахуйн нэгжийн хаяг
- Шилжилт эмх цэгцгүй

Цогт:

- Нэг хаягтаа байдаггүй, үүнийг зохицуулах хүндрэлтэй асуудал
- Хяналт тавих боломжгүй байдаг

Сайнжаргал:

- Байгууллагын байршил өөрчлөгдсөнөөр тэр бүр шилжүүлэг хийх нь хүндрэлтэй байдаг, нэг байгууллага олон татварын албатай харьцах болдог
- Татварын байгууллага янз бүрийн шаардлага тавьдаг

Тунгалаг:

- Харьяаллыг үл хөдлөх хөрөнгийн байршилтай уялдуулбал цэгцлэгдэх магадлалтай

Өнөржаргал:

- Улсын бүртгэлийн алба анх бүртгэл хийхдээ учир дутагдалтай ханддаг. Тэгээд л таньдаг хүн хайх жишээтэй

Цогт:

- ААН-ийг үйл ажиллагаа явуулах тогтмол хаягтай байх
- 1998 оны журмыг өөрчлөх
- Онлайнаар мэдээлэл авах, татварын албадын ажил үүргийн уялдааг сайжруулах асуудал яригдаж байна

Хяналт шалгалтын үр нөлөө**Тунгалаг:**

- Х болон алдагдалтай тайлан гаргасан аж ахуйн нэгжийг шалгахдаа стандартаа хангахад л чиглэдэг

Цогт:

- Татварын хяналт шалгалт үндсэн зорилгоо биелүүлж чадахгүй байгаа нь татвар төлөгчдөд татвараа төлөх сэтгэхүйд эерэг биш харин сөрөг нөлөөлж байна.
- Одоо азгүй, матаанд орсон хэсэг нь хяналт шалгалтанд хамрагдаж байна гэж үзэж болно

Өнөржаргал:

- Хяналт шалгалтын байцаагч нар хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн сурталчилгаа хийдэггүй
- Зөвхөн хариуцлага тооцох л ажил хийдэг

Тунгалаг:

- Манай дүүрэг Х тайлан гаргасан аж ахуйн нэгжид урьдчилсан хяналт хийж ажилладаг. Энэ нь үр дүнтэй байгаа

Цэнд-Аюуш:

- Нэг байцаагч дунджаар 220-иос дээш аж ахуйн нэгжийн тайлан авдаг. Ачаалал их. Урьдчилсан хяналт хийж зөвлөгөө өгснөөрөө татварын ногдуулалт нэмэгддэг

Мэдээлэл худалдаж авах**Цогт:**

- Мэдээлэлд үндэслэн шалгах нь их хэцүү, хүндрэлтэй
- Үндэслэл 50 хувьтай

Сайнжаргал:

- Муудалцсан этгээдүүд л бие биенээ матна

Ашигласан материалын жагсаалт

1. Монгол улсын үндсэн хууль. УБ., 1992
2. Татварын ерөнхий хууль. УБ., 1993
3. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль. УБ., 2002
4. Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хууль. УБ., 1993
5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль. УБ., 2006
6. “Татварыг хураах үйл ажиллагааны дүрэм” ҮТЕГ-ын даргын 2002 оны 231-р тушаал
7. “Татвар төлөгчийн бүртгэлийн журам” ҮТЕГ-ын даргын 2001 оны 119-р тушаал
8. “Татвар төлөгчийн бүртгэлийн журам” ҮТЕГ-ын даргын 2006 оны 258-р тушаал
9. “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн маягт нөхөх заавар” ҮТЕГ-ын даргын 2006 оны 267 тоот тушаал
10. “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийг хэрэгжүүлэх аргачлал” ҮТЕГ-ын даргын 2006 оны 235 тоот тушаал
11. “Татварын өр болон буцаан олголтын бүртгэл хөтлөх, өр барагдуулах журам” ҮТЕГ-ын даргын 2001 оны 142-р тушаал
12. “Татварын өрийг «Мэдэгдэх хуудас»-аар хураан барагдуулах тухай журам” Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 272-р тушаал
13. “Татварын өрийг татвар төлөгчийн банкин дахь хөрөнгөнөөс үл маргах журмаар гаргуулах тухай журам”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, ҮТЕГ-ын даргын 2002 оны 134/192-р тушаал
14. “Шүүхийн шийдвэртэй татварын өр төлбөр барагдуулах тухай”; ҮТЕГ-ын даргын 2002 оны 219-р тушаал
15. “Татварын өрийг татвар төлөгчийн эд хөрөнгө, цалин хөлс, бусад орлогоос гаргуулах тухай журам”, “Татварын өрөнд авсан эд хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах журам”, “Эд хөрөнгө битүүмжлэхэд баримтлах журам”, “Татвар төлөх хугацааг сунгахад баримтлах журам”, “Үзлэг хийхэд баримтлах журам” ҮТЕГ-ын даргын тушаал
16. Нямзагд С, Алтанзаяа Г, Татвар, татвар ногдуулалт. УБ., 2004
17. Алтанзаяа Г, Монгол улсын татварын бодлогын онол, арга зүйн үндэс. УБ., 2003
18. Нарандэлгэр Д, Удирдлагын ерөнхий онол, математик загварчлал. УБ., 1999
19. Энхбаяр Г, Отгонтуяа Л, Төрийн санхүүгийн удирдлага. УБ., 2002
20. Алтанзаяа Г, Баяраа Д, Мятавжанцан С, Татварын бүртгэл, хяналт шалгалт. УБ., 2002

21. Монгол Улсын зах зээлийн эдийн засгийн шилжилт болон хөгжлийг дэмжих судалгаа. Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг, ҮТЕГ. Эцсийн тайлан. 2001.
22. Татварын ажилтанд зориулсан сургалтын материал. Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг
23. Mihaly Hoge, Local and regional tax administration in transition countries. Hungary., 2000
24. Donors turn blind eye to extortion in tax collection in Africa. Development today, 2001
25. Helena Blazic. Compliance costs of taxation in a transition country.
26. Konstantin Pashiv, Corruption and tax compliance. 2005
27. A financial information system. 1997